



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, ШИЙДВЭР,
ХУУЛИЙН ТАЙЛВАР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№

1996 оны 1-р сар

№ 1 /44/

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | |
|--|----|
| 1. Ард нийтийн санал асуулгын тухай | 3 |
| 2. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай | 13 |
| 3. Гадаад худалдааны арбитрын тухай | 18 |
| 4. Монгол хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай | 34 |
| 5. Векселийн тухай | 47 |
| 6. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай | 55 |
| 7. Харилцаа холбооны тухай | 55 |
| 8. Женевийн Конвенцийн нэмэлт Протоколуудыг соёрхон батлах тухай | 69 |
| 9. Монгол Улсын 1996 оны улсын төвлөрсөн төсвийн тухай | 69 |

II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | |
|---|----|
| 10. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай №74 | 72 |
|---|----|

- | | |
|---|---|
| 11. Гадаад худалдааны арбитрын тухай хууль
батлагдсантай холбогдуулан авах зарим арга
хэмжээний тухай №75 | 7 |
| 12. Л. Ганбаатарыг төрийн хянан шалгах хорооны
гишүүнээр томилох тухай №76 | 7 |
| 13. Журам батлах тухай №77 | 7 |
| 14. Төрөөс мөнгөний бодлогын талвар 1996 онд
баримтлах чиглэлийг батлах тухай №79 | 7 |
| 15. Харилцаа холбооны тухай хуулийг хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай №86 | 8 |

III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | |
|---|---|
| 16. Сэрсэнжавын Дашцэрэнд Монгол Улсын
Хөдөлмөрийн баатар цол олгох тухай №155 | 8 |
| 17. Ш. Гунгаадоржийг Элчин сайдаар томилох
тухай №160 | 8 |
| 18. Журам батлах тухай №222 | 8 |

IV. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | |
|--|---|
| 19. Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам
батлах тухай №96 | 8 |
| 20. Журам батлах тухай №97 | 9 |
| 21. Зарим тогтоол, тогтоолын эвэлтыг хүчингүй
болсонд тооцох тухай №98 | 1 |
| 22. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын
тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга
хэмжээний тухай №100 | 1 |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 10 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь ард нийтийн санал асуулга /цаашид санал асуулга" гэх/ явуулах зарчим, журмыг тодорхойлож, санал асуулгыг бэлтгэн зохион байгуулж явуулахтай холбогдсон арилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Санал асуулгын тухай хууль тогтоомж

Санал асуулгын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн усад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Санал асуулгын зарчим

1. Санал асуулгад Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд оролцож, санал асуулгаар шийдвэрлэх суудлын талаар саналаа нууцаар гаргана.

2. Санал авах өдөр эх орондоо байгаа 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс нйгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан ушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр санал асуулгад оролцож саналаа өгөх эрхтэй. Шүүхийн хүчин өгөлдөр шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн орих газар ил эдэлж байгаа хүн санал асуулгад оролцохгүй.

4 дүгээр зүйл. Санал асуулгаар шийдвэрлэх асуудал

1. Санал асуулгыг төрийн дотоод, гадаад бодлогыг тодорхойлохтой холбогдсон тодорхой асуудлаар ард нийтийн сонголт ийлгэх шаардлага гарсан тохиолдолд явуулна.

2. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард нийтийн санал асуулга явуулж болно.

3. Нэг удаагийн санал асуулгыг хоёроос дээшгүй асуудлаар явуулна.

4. Ард нийтийн санал асуулгаар шийдсэн асуудалд цаашид нэмэлт өөрчлөлт оруулах бол Улсын Их Хурлаар хэлэлцэж, илт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар шийдвэрлэнэ.

5 дугаар зүйл. Санал асуулгыг эрхлэн явуулах
байгууллага

1. Санал асуулга явуулах ажлын бэлтгэлийг улсын хэмжээ Сонгуулийн ерөнхий хороо, бүх шатны засаг захиргаа, нут дэвсгэрийн хороод /цаашид "нутаг дэвсгэрийн хороод" гэж тус тус хариуцна.

2. Санал авах ажлыг бүх шатны засаг захиргаа, нут дэвсгэрийн нэгжийн хэмжээнд Сонгуулийн хэсгийн хороо /цаашид хэсгийн хороод гэнэ/ эрхэлнэ.

3. Санал асуулга дангаар явуулж байгаа тохиолдолд нут дэвсгэрийн хороог Сонгуулийн ерөнхий хороо, хэсгийн хороо дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч тус тус байгуулна.

4. Нутаг дэвсгэрийн хороод санал асуулгыг бэлтгэн явуулах ажлыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 15 дүгн зүйлд зааснаар зохион байгуулна.

5. Санал асуулгаар тавигдаж байгаа асуудлын талаар с шатны хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд ухуул сурталчилгаа хийхийг хориглоно.

6 дугаар зүйл. Сонгуулийн ерөнхий хорооны
бүрэн эрх

Сонгуулийн ерөнхий хороо санал асуулга бэлтгэн явуу талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ санал асуулга бэлтгэн явуулах ажлыг төлөвлөж зохион байгуулах;

2/ санал асуулгын тухай хууль тогтоомжийн биелэлт хянан, шалгах, түүнийг нэг мөр сахин биелүүлэх явдлыг хянах;

3/ нутаг дэвсгэрийн болон хэсгийн хороодын үйл ажиллагайг нэгтгэн удирдах;

4/ санал асуулгын тухай хууль тогтоомж зөрчигдсөн талаар өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх;

5/ санал асуулгын зардлын төсвийг батлагдсан хэмжээ дотор хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэл тайланг хэлэлцэж Улсын Их Хуралд тайлагнах;

6/ санал асуулгын баримт бичгийн загвар маягт, санал асуулгын тухай хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэх ажилчилсан заавар, зөвлөмж батлах, саналын дуудсыг хэвлүүлж хуваарилах, тараах, тооцоолох;

- 7/ санал асуулгын нэгдсэн дүнг гаргаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
 - 8/ санал асуулгын тухай хууль тогтоомжийг хэрэглэх талаар тайлбар гаргах саналыг эрх бүхий байгууллагад оруулах;
 - 9/ хуульд заасан бусад бүрэн эрх.
- 7 дугаар зүйл. Нутаг дэвсгэрийн хороодын бүрэн эрх
- Нутаг дэвсгэрийн хороод санал асуулга бэлтгэн явуулах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 1/ санал асуулга бэлтгэн явуулах ажлыг төлөвлөн зохион байгуулах;
 - 2/ санал асуулгын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, нэг мөр сахин биелүүлэх явдлыг хангах, хэсгийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн удирдах;
 - 3/ санал асуулгын тухай хууль тогтоомж зөрчигдсөн талаархи иргэдэд, гомдлыг хянан шийдвэрлэх;
 - 4/ санал авсан дүнгийн тухай хэсгийн хорооны шийдвэрийг нэгдсэн нутаг дэвсгэрийн хэмжээнд санал асуулгын дүнг өргөн, Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх;
 - 5/ дахин санал авах, санал асуулга явуулах ажлыг зохион байгуулах;
 - 6/ санал асуулгын баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон журмын дагуу цэгцлэн хүлээлгэж өгөх;
 - 7/ Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн үүргийг биелүүлэх;
 - 8/ хуульд заасан бусад бүрэн эрх.
- 8 дугаар зүйл. Хэсгийн хорооны бүрэн эрх
- Хэсгийн хороо санал асуулга явуулах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 1/ хэсгийн хорооны хавт, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр цагийг иргэдэд мэдээлэх;
 - 2/ санал асуулгад оролцогчийн үнэмлэх олгох;
 - 3/ санал асуулгад оролцогчид шинжүүдэг олгох, шинээр өрсөн иргэнийг бүртгэх;
 - 4/ санал асуулгад оролцогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хэмжээнд нэгтгэж шалгах;
 - 5/ санал авах байр, саналын хуудас, хайрцгийг бэлтгэж, иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах;
 - 6/ санал авалтын дүн гаргаж нутаг дэвсгэрийн хороонд үргэх;

7/ санал асуулгын баримт бичгийг Сонгуулийн ерөн хорооноос тогтоосон журмын дагуу цэгцэлж нутаг дэвсгэр хороонд хүлээлгэн өгөх;

8/ санал асуулгыг бэлтгэн явуулах асуудлаар гарсан өргө гомдлыг хянан шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламж.

9/ нутаг дэвсгэрийн хорооноос өгсөн үүргийг биелүүлэх.

10/ хуульд заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл. Санал асуулга бэлтгэн явуулах
ажлын ил тод байдал

1. Санал асуулга бэлтгэн явуулах ажил ил тод байна.

2. Төрийн байгууллагын харьмалал бүхий хэвлэл, мэдээлэл байгууллага санал асуулга бэлтгэн явуулах ажлын хяц, санал асуулгын дүнг олон нийтэд шуурхай үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.

10 дугаар зүйл. Санал асуулга явуулахтай холбогдсон зардал

1. Санал асуулга зохион байгуулж явуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ;

1/ санал, асуулгын хуудас, санал авалтын дүн, мэдээлэл маягт хэвлэх, сонгуулийн хороодын тэмдэг хийлгэх зардал.

2/ сонгуулийн ерөнхий хороо, нутаг дэвсгэрийн болон хэсэг хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал;

3/ санал асуулгатай холбогдсон таниулга, мэдээлэл зардал;

4/ Улсын Их Хурлаас тогтоосон бусад зардал.

2. Улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг Улсын Хурал батлана.

3. Хороодын ажиллах, санал авах байрыг төв, ерөн нутгийн төсвийн болон төрийн өмчийн байгууллагууд үнэ төлбөргүй гаргаж өгнө.

4. Нутаг дэвсгэрийн болон хэсгийн хороодыг ажлын хэргээр тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангахыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж засаг дарга хариуцна.

11 дүгээр зүйл. Санал асуулгыг санаачлах эрх бүхий
этгээд

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуулыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурал нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь хамтарч, мөн зүйл

дахь хэсэгт заасан асуудлаар Үндсэн хуулийн хорин зургаагаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль санаачлагчид тус с санал асуулга явуулахыг санаачлах эрхтэй. Иргэд санал гулга явуулах тухай саналаа Монгол Улсын Ерөнхийлөгч, стийн газар, Улсын Их Хурлын гишүүдэд уламжилна. Энэхүү аалд санал асуулга явуулах болсон үндэслэл, тооцоо, холбогдох гэд баримт бичгийг хавсаргана.

12 дугаар зүйл. Санал асуулга явуулах тухай асуудлыг
хэлэлцэн шийдвэрлэх

1. Тухайн асуудлаар санал асуулга явуулах эсэхийг Улсын Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар йдвэрлэнэ.

2. Санал асуулгаар шийдвэрлэх асуудлын асуулгыг илэр- йлсэн асуулт, түүнд өгөх эсрэг утга бүхий хоёр хариултын илбарыг Улсын Их Хурал хэлэлцэж батлана. Асуулт хариул- г хоёрдмол утгагүй, товч, тодорхой, ойлгомжтой томъёолж на.

13 дугаар зүйл. Санал асуулга товлон зарлах

1. Санал асуулга явуулах тухай шийдвэрт санал, асуулга гулах өдрийг уг шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш аас доошгүй хоногийн дараа явуулахаар товлон заана.

2. Иргэдийн саналыг ажлын болон баяр ёслолын бус өдөр та.

3. Санал асуулга явуулах тухай шийдвэрийг гарсан өдрөөс хойш нэн даруй хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тээлнэ.

4. Санал асуулгыг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн сон- гьттай хамтатган явуулна. Зайлшгүй шаардлагатай гэж Улсын Хурал үзвэл бусад үед санал асуулга явуулж болно.

4 дүгээр зүйл. Санал авах хэсэг, түүнийг байгуулах
Санал асуулгыг Улсын Их Хурлын, эсхүл Ерөнхийлөгчийн гуультай хамтатган явуулж байгаа бол сонгуулийн санал х хэсэг, санал асуулгын санал авах хэсэг нэг байна. Харин ал асуулгыг дангаар явуулж байгаа бол иргэдийн саналыг тоолох зорилгоор санал авах хэсгийг сум, дүүргийн Иргэдийн өологчдийн Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 20 огийн өмнө байгуулж хэсгийн дугаар, харьяалах нутаг агэр, төвийг зарлана.

Харин иргэд бөөнөөрөө шилжин суурьшсан зэрэг тохиолдол санал авах хэсгийг санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө байгуулах буюу шилжүүлэн байршуулж болно.

15 дугаар зүйл. Нэрийн жагсаалт

Санал асуулгад оролцох иргэдийн нэрийн жагсаалтыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 16 дугаар зүйлд заасан журмын дагуу үйлдэж санал авах өдрөөс 20 хоногийн өмнө санал авах хэсгийн хороонд өгнө.

16 дугаар зүйл. Нэрийн жагсаалтын талвар
гомдол гаргах

Нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн тухай иргэн гомдол гаргах, түүнийг эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэхэд сонгогчдын нэрийн жагсаалтын талаар гомдол гаргах журмыг баримтална.

17 дугаар зүйл. Санал асуулгын талвар явуулах
ухуулга, сурталчилгаа

Санал асуулгаар тавигдаж байгаа асуулгын талвар ирд нийт танхулах, мэдээллээр хангах асуудлыг төр хариуцна. Нам, ол нийтийн байгууллага өөрсдийн хүч хөрөнгөнд тулгуурлан сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу хууль зөвшөөрсөн хэлбэрээр ухуулга, сурталчилгаа явуулж болно.

2. Аливаа ухуулга, сурталчилгааг санал асуулга явуулах тухай Улсын Их Хурлын шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш эхэлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө зогсооно.

18 дугаар зүйл. Санал авах газар, хугацаа

1. Иргэдийн саналыг санал авахаар бэлтгэсэн байранд санал асуулга явуулах өдрийн 07 цагаас 22 цаг хүртэл хугацаа авна. Санал авах байр, хугацааг хэсгийн хороо санал авах өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ.

2. Иргэдээс саналаа нууцаар бэлтгэхэд хүрэлцэх тоо тасалгаа, саналын хайрцаг бүхий байрыг тухайн хэсгийг харуулах сум, дүүргийн Засаг дарга хариуцаж бэлтгүүлнэ.

19 дүгээр зүйл. Санал авах хуудас

1. Санал авах хуудсыг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан загварын дагуу хэллэж, Сонгуулийн ерөнхий хорооноос нутаг дэвсгэрийн хороонд, нутаг дэвсгэрийн хорооноос санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө санал авах хэсгийн хороо тус тус хүргүүлсэн байна.

2. Санал авах хуудсанд санал асуулгаар шийдвэрлэх асуудлын гуулгыг илэрхийлсэн асуултыг түүнд өгөх эсрэг утга бүхий оёр харилтын хувилбарын хамт Улсын Их Хурлаас баталсан амьболлоор хэллэсэн байна.

20 дугаар зүйл. Санал авах ажлыг зохион байгуулах

1. Санал асуулга явуулах өдрийн 07 цагт хэсгийн хорооны үрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчдийг байлцуулан саналын бүх айргийг шалган битүүмжилж, санал авах ажиллагааг эхэлнэ.

2. Хэсгийн хороо иргэдийн иргэний паспорт, түүнтэй адилтгах баримт бичгийг нэрийн жагсаалттай тулган үзэж, хүн бүрт санал авах хуудас олгоно.

Санал авах үед шилжин ирэгчдийг тэдний иргэний паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг, шилжүүлгийг үндэслэн нэрийн өмөлт жагсаалтад бүртгэж, саналын хуудас олгоно.

21 дүгээр зүйл. Санал өгөх

1. Иргэн санал өгөх байранд ирж, саналаа өөрөө өгнө. Харин нөхцөл зөрүү мэдлийн байдлаас болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас санал авах байранд хүрэлцэн ирж чадахгүй иргэний саналыг түүний хүсэлтээр санал авах хэсгийн хорооны өөрөөс доошгүй гишүүн очиж, битүүмжилсэн хайрцагаар авна.

2. Санал асуулгад оролцогч санал авах өдөр өөрийн биеэр үрэлцэн ирж саналаа өгөх боломжгүй бол саналын хуудсыг санал авах хэсгийн хороонд ирүүлснээс хойшхи хугацаанд ухайн хэсгийн хороонд урьдчилэн ирж саналаа битүүмжлэн өгч болно. Хэсгийн хороо битүүмжлэн үлдээсэн саналын нууцыг энд хадгална.

3. Иргэн саналын хуудсыг авч, санал өгөх тасалгаанд орж тус хуудсанд бичигдсэн асуулттай танилцсаны үндсэн дээр эсрэг утга бүхий хоёр харилтын аль нэгийг өмнөх дугаарыг дугуйлан тэмдэглэж хуудсаа саналын хайрцагт хийнэ.

4. Иргэн саналаа тэмдэглэхдээ алдаа гаргаж буруу тэмдэг тавьсан бол энэ тухайгаа уг хуудсаа саналын хайрцагт хийхээс өмнө сонгуулийн хэсгийн хороонд мэдэгдэж, хуудсаа хураалган авхин нэг хуудас авч болно.

Хураалгасан саналын хуудсыг хэсгийн хороо протоколд тэмдэглэж хадгална.

5. Санал бэлтгэх тасалгаанд санал өгөгч тухайн иргэнээс өөр хүн байхыг хориглоно. Саналын хуудсанд саналаа өөрөө

тэмдэглэж чадахгүй хүн санал авах хорооны гишүүнээс б
гагцхүү өөрийн итгэмжилсэн хүний туслалцаа авч болно.

22 дугаар зүйл. Саналын хуудсыг хүчингүйд тооцох

Дараахь тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцн

1/ батлагдсан загварын бус хуудсаар санал өгсөн;

2/ тухайн санал авах хэсгийн хорооны дарга, нарийн бич
даргын гарын үсэггүй буюу хэсгийн хорооны тэмдэггүй ху
хэрэглэсэн;

3/ хариултыг тэмдэглээгүй, эсхүл нэгээс илүү хар
тэмдэглэсэн, энэ хуульд зааснаас өөр тэмдэглэл хийсэн;

4/ асуулт хариултыг дарсан.

23 дугаар зүйл. Санал тоолох

1. Санал тоолох ажлыг ил тод, нээлттэй явуулна. С
тоолоход иргэдийн болон хэвлэл мэдээллийн байгуулл
телеологчид байлцаж болно.

2. Санал асуулга явуулж буй өдрийн 22 цаг болмогц с
авах ажлыг зогсоож, санал тоолох тухай мэдэгдэн олго
үлдсэн саналын хуудсыг тоолж битүүмжилсний дараа сан
хайрцгийг нээнэ. Санал тоолох цаг болоогүй байхад сан
хайрцаг нээх, санал тоолох ажиллагааг завсарлахыг хориг.

3. Хэсгийн хороо санал асуулгад оролцох иргэдийн нэ
жагсаалтыг баримтлан тухайн хэсгийн иргэдийн тоо, сан
хуудас авсан иргэдийн тоо, саналын хайрцгаас гарсан
буюу хүчинтэй хүчингүй хуудасны тоо, асуултын хариулт
өгсөн саналын тоог тус тус хэсгийн хэмжээгээр тоолж гар

4. Хэсгийн хороо хуралдаанаараа санал тоолсон дүнг хэлэ
шийдээр гаргаж уншин сонсгосны дараа нутаг дэвсгэ
хороонд нэн даруй хүргүүлнэ.

24 дүгээр зүйл. Санал асуулгын дүнг нэгтгэн хүргүүл

1. Нутаг дэвсгэрийн хороо нь хэсгийн хороодын шийдэл
үндэслэн нэрийн жагсаалтад бичигдсэн иргэдийн тоо сан
хуудас авсан иргэний тоо, хүчинтэй болон хүчингүй хууд
тоо, асуултын хариулт бүрт өгсөн саналын тоог тус тус
дэвсгэрийн хэмжээгээр нэгтгэн гаргана.

2. Санал асуулгын дүнг гаргахдаа саналын хүчинтэй хуу
тооцно.

3. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд явуулсан санал асуу
дүнг нутаг дэвсгэрийн хороо 3 хоногийн дотор нэгтгэн ги

уралдаанаараа хэлэлцэн Сонгуулийн ерөнхий хороонд 2 хоногийн дотор мэдээлнэ.

25 дугаар зүйл. Санал авах хэсэгт санал авалтыг хүчингүй болсонд тооцох, дахин санал авах

1. Санал авах хэсэгт явуулсан санал авалтыг нутаг дэвсгэрийн хороо дараахь тохиолдолд хүчингүйд тооцно:

1/ гал, усны аюул зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад хэцээлд өмнө зарласнаас өөр байранд, түүнчлэн саналыг бичүүмжлэн авснаас бусад тохиолдолд төвлөн зарласнаас өөр өдөр шал авсан;

2/ санал авч эхэлснээс хойш саналын хайрцгийг алдсан, эргдүүлсэн, хуульд заасан цагаас өмнө нээсэн;

3/ хэсгийн хорооны гишүүн буюу иргэдэд хүч хэрэглэн ирэмт үзүүлсэн аливаа үйлдэл нь санал асуулгын дүнг гажуулуулахад хүргэсэн;

4/ хэсгийн хорооны гишүүд, бусад байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, хууран мэхлэх зэргээр санал асуулгын тухай хууль тогтоомж зөрчсөн нь санал асуулгын дүнд ноцтой мөөлсөн.

2. Санал авалтыг хүчингүй болсонд тооцсон тухай нутаг дэвсгэрийн хорооны шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор дахин санал авна. Дахин санал авах шийдвэрийг нутаг дэвсгэрийн хороо гаргана. Уг шийдвэрт дахин санал авах байр, өдрийг авна. Санал авалт хэсгийн хэмжээгээр хүчингүй болсон тохиолдолд тухайн хэсгийн нийт иргэдээс дахин санал авна.

3. Санал авах байранд өөрөө хүрэлцэн ирж чадахгүй иргэдийн талыг авсан саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, хуульд заасан хугацаанаас өмнө нээснээс уг хайрцаг дахь саналыг хүчингүйд тооцсон бол уг хайрцагт санал өгсөн иргэдээс дахин санал авна.

26 дугаар зүйл. Санал асуулгын дүнг гаргах, санал асуулга явуулсан асуудлыг шийдвэрлэгдсэнд тооцох

1. Нутаг дэвсгэрийн хороодоос санал асуулгын дүнг ирүүлснээс хойш 14 хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороо уг дүнг батгаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

2. Улсын Их Хурал санал асуулга хуулийн дагуу явагдсан эх талаар санал хураана. Улсын Их Хурлын хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи санал асуулга хуулийн дагуу явагдсан гэж үзвэл уг асуудлыг ард нийтийн санал асуулгаар шийдвэрлэгдсэнд тооцно.

3. Санал асуулгад оролцсон иргэдийн саналын хуудсын олонх хүчингүй болсон бол дахин санал асуулга явуулах эсэхийг Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэнэ.

4. Санал асуулгад нэрийн жагсаалтад бичигдсэн иргэдийг олонхи оролцоогүй бол дахин санал асуулга явуулахгүй бөгөөд уг санал асуулгыг ард нийт дэмжээгүй гэж үзнэ.

5. Санал асуулгаар нэгэнт шийдвэрлэгдсэн асуудлаар жилийн дотор, санал асуулгаар шийдвэрлэгдээгүй асуудлаар Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд, гэхдээ уг санал асуулга явуулснаас хойш 2 жилийн дотор дахин санал асуулга явуулахгүй.

6. Санал асуулгын талаар Сонгуулийн ерөнхий хороон гаргасан шийдвэр Үндсэн хууль зөрчсөн гэж Үндсэн хуулийг цэц үзсэн бол санал асуулгыг дахин явуулна.

27 дугаар зүйл. Санал асуулгын талаархи маргааныг шийдвэрлэх

Санал асуулгын талаархи маргааныг Үндсэн хуулийн цэц шүүх, Сонгуулийн ерөнхий хороо, нутаг дэвсгэрийн болон хэсгийн хороод хууль тогтоомжид заасан харьяалал журмыг дагуу шийдвэрлэнэ.

28 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүдээлгэх хариуцлага

Ард нийтийн санал асуулгын тухай хууль зөрчсөн нь эрүүгийг хариуцлага хүдээлгэхээргүй бол шүүгч дараахь шийтгэлийг ногдуулна:

1/ Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 3, 4, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй Засаг дарга, төсө байгууллагын эрх баригчийг 20000 хүртэл төгрөгөөр торгох.

2/ энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмыг зөрчсөн нам, олон нийтийн байгууллагыг 100000 хүртэл гэм буруутай албан тшаалтан, иргэнийг 20000-25000 төгрөгөөр тус тус торгох;

3/ энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5, 23 дугаар зүйлийн дахь хэсэгт заасныг зөрчсөн хэсгийн хорооны гишүүнийг 1000 20000 төгрөгөөр торгох;

4/ санал асуулга явуулах үйл ажиллагаанд санаатайгаар сахицсан, санал асуулгад оролцохоос татгалзахыг нийтэд уриалсан бусдын нэрийн өмнөөс санал асуулгад оролцсон, санал тоол

слыг зориуд саатуулсан бол буруутай этгээдийг 20000-25000 гргөгөөр торгох.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь худалдаа, аж үйлдвэрийн танхим олон худалдааны танхим /цаашид "танхим" гэх/-ын бүрэн эрх, Д ажиллагааны үндсэн чиглэл, түүний тогтолцоо, зохион йгуулалтын хэлбэрийг тодорхойлох, танхим болон төрийн ба сад байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн хоорондын харил аг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Танхимын тухай хууль тогтоомж

1. Танхимын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний уль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоом йн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд танхимын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг гаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Танхимын тухай ойлголт

1. Танхим нь аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдаа, ддээрлэл эрхлэхтэй холбогдсон нийтлэг эрх, хууль ёсны йг сонирхлыг хамгаалах болон худалдаа, үйлдвэрлэлийг мжих зорилгоор байгуулсан олон нийтийн байгууллага мөн.

2. Танхим нь хуулийн этгээд мөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Танхимын зорилт, бүрэн эрх, тогтолцоо

4 дүгээр зүйл. Танхимын зорилт, бүрэн эрх

1. Танхим нь улс орны эдийн засгийн хөгжилд тус дэмж. үзүүлэх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай нөхцөл б. дүүлэх, аж ахуйн нэгж байгууллагуудаас гадаад, дотоод байгууллагатай худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан, т. нихийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, өөрийн орны бар бүтээгдэхүүнийг экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх зорилт хэрэгжүүлнэ.

2. Танхим нь дараахь бүрэн эрх эдэлнэ:

1/ гишүүдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг төлөөл хамгаалах асуудлаар төрийн байгууллагатай харилцах;

2/ үйл ажиллагааны дүрэм, бүтэц, зохион байгуулал батлах;

3/ салбар болон төлөөлөгчийн газраа дотоод, гадаадад ижиллуулах;

3. Танхим нь бүрэн эрхийнхээ хүрээнд дараахь үйл ажилла явуулна.

1/ дотоод, гадаадын зах зээлийн мэдээлэл солилцох;

2/ дотоод гадаадын эдийн засгийн байгууллага, үйлдв худалдааныхны судалгааны болон ажил хэргийн төлөөлөг солилцох, уулзалт, хэлэлцээг зохион байгуулах;

3/ гадаадын аж ахуйн нэгж, байгууллагуудад үйлдвэр худалдаа эрхлэхтэй нь холбогдсон үйлчилгээ үзүүлэх;

4/ дотоод, гадаадад үйлдвэр, худалдааны олон улсын бо төрөлжсөн үзэсгэлэн, нармаг зохион байгуулах;

5/ реклам, сурталчилгааны үйлчилгээ үзүүлэх, уран сай зарлал, чимэглэлийн эхийг бэлтгэх, хийлгэх

6/ аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөлгөө өгөх, үйлд худалдааны түнш эрж олохтой холбогдсон мэдээллээр хан боловсон хүчин бэлтгэхэд нь туслах болон бусад үйлчи. үзүүлэх;

7/ олон улсын болон гадаад улсын худалдаа, эдийн засг байгууллага, танхим, худалдаа, үйлдвэрлэл дэмжих байг лагатай хамтран ажиллах;

8/ дотоодын шинээр бий болсон жижиг, дунд үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

9/ Монгол улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бусад үйл ажиллагаа явуулах.

5 дугаар зүйл. Танхимын тогтолцоо

1. Монгол Улсад үндэсний танхим нэг байна.

2. Аймаг, нийслэлийн, эсхүл аймаг дундын танхим байж болно.

6 дугаар зүйл. Үндэсний танхим

1. Монголын үндэсний танхимын зорилт, бүрэн эрхийг Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим хэрэгжүүлнэ.

2. Үндэсний танхим нь танхимын нийтлэг зорилт, бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ дараахь тодорхой бүрэн эрхтэй байна:

1/ төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, түүнийг дотоод гадаадад тайлбарлан таниулах, хэрэгжилтэд нь тус дэмжлэг үзүүлэх;

2/ худалдаа, үйлдвэрийнхний нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлөн илэрхийлэх, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах;

3/ экспортын барааны гарал, үүслийг гэрчлэх;

4/ хуульд зааснаар дэргэдээ гадаад худалдааны арбитр байгуулан ажиллуулах.

5/ экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах;

6/ давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх.

7 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн, аймаг дундын танхим

1. Аймаг, нийслэлийн эсхүл аймаг дундын танхим тухайн нутаг дээсгэрт нэг байна.

2. Аймаг, нийслэлийн, аймаг дундын танхим нь бие даан үйл ажиллагаа явуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Танхимыг үүсгэн байгуулах, бүртгүүлэх,
танхимын дүрэм

8 дугаар зүйл. Танхимыг үүсгэн байгуулах

1. Үндэсний танхимыг Иргэний хуульд заасан нөхцөл, журмын дагуу аймаг, нийслэлийн, аймаг дундын танхим, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөлтэйгээр үүсгэн байгуулна.

2. Аймаг, нийслэлийн, аймаг дундын танхимыг 50-нас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага Иргэний хуульд заасан нөхцөл, журмын дагуу үүсгэн байгуулж болно.

3. Үүсгэн байгуулагчид бүх гишүүний хурлаа хийж, дүрмэ батлана.

4. Танхимд иргэн элсэж болно.

9 дүгээр зүйл. Танхимыг бүртгэх журам

1. Үүсгэн байгуулагчид дүрмээ баталснаас хойш 14 хоногий дотор танхимыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөл бүртгэх байгууллага /Хууль зүйн зам/-д гаргана.

2. Улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөлд дараахь барим бичгийг хавсаргана:

1/ танхимын нэр, төв нь байрлаж байгаа газрын хаяг, бүтэц зохион байгуулалтын тухай мэдээ;

2/ дүрэм;

3/ гишүүдийн бүртгэл.

3. Бүртгэх байгууллага өргөдөл, баримт бичгийг хүлээ авснаас хойш 30 хоногийн дотор Иргэний хуульд заасан журмы дагуу хянан шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл. Танхимын дүрэм

1. Танхимын дүрэмд дараахь асуудлыг тусгана:

1/ дүрмийн зорилт;

2/ гишүүний төрөл, эрх үүрэг, гишүүн элсүүлэх, чөлөөлөг гишүүнээс гарах болзол, журам;

3/ удирдлага, зохион байгуулалт;

4/ дүрэм зөрчсөн тохиолдолд гишүүнд хүлээлгэх хариуцлаг.

2. Үндэсний танхим нь энэ хуулийн 6 дугаар зүйлийн 2 дэх хэсгийн 3, 5, 6-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх албы байгуулан ажиллуулна. Түүний ажиллах журмыг зөвлөл тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Танхимын санхүүжилт, эд хөрөнгийн хариуцлага

11 дүгээр зүйл. Танхимын санхүүжилт, түүний эх үүсвэр

1. Танхимын санхүүжилт дарвахь эх үүсвэрээс бүрдэнэ:
 - 1/ гишүүний татвар;
 - 2/ иргэд, байгууллагын хандив;
 - 3/ үйлчилгээний орлого.
2. Танхим нь ашиг олох зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулахгүй боловч Иргэний хууль, энэ хуульд заасан буюу үрмийнхээ зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээг олбертэй гүйцэтгэнэ.
3. Танхимын үйлчилгээний холсинь хэмжээг танхимын саналыг идэвхэн Сангийн сайд, Худалдаа, үйлдвэрийн сайд хамтран огтоосно.
 - 12 дугаар зүйл. Танхимын эд хөрөнгийн хариуцлага
 1. Танхим нь өөрийн эд хөрөнгийн хэмжээгээр хариуцлага үлдэнэ.
 2. Танхим гишүүдийнхээ бусдын өмнө хүлээх үүргийг, гишүүд танхимын хүлээх үүргийг тус тус хариуцахгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ

Танхимын үйл ажиллагаа дуусгавар болох

- 13 дугаар зүйл. Танхимыг өөрчлөн байгуулах
 1. Хэд хэдэн аймгийн танхим хоорондоо нэгдэж аймаг дундын танхим байгуулах, эсхүл 1 буюу хэд хэдэн аймгийн танхим аймаг дундын танхимд нийлж болно. Эдгээр нэгдсэн аймгийн танхимын эрх, үүрэг шинээр буй болсон, нийлсэн аймгийн танхимын эрх, үүрэг өргөжсөн аймаг дундын танхимд тус тус илжинэ.
 2. Аймаг дундын танхим хэд хэдэн аймгийн танхим болж унаагдах, эсхүл аймаг дундын танхимаас нэг буюу хэд хэдэн аймгийн танхим тусгаарлан гарч болно. Аймаг дундын танхимын эрх, үүрэг хуваагдсан, тусгаарласны эцэст буй болсон танхимуудад шилжинэ.
 3. Танхимыг өөрчлөн байгуулах асуудлыг бүх гишүүдийн урлаар шийдвэрлэж, өөрчлөн байгуулах комисс томилно.
 4. Танхим өөрчлөн байгуулагдах тухай бүртгэх байгууллагад үртгүүлнэ.
- 14 дүгээр зүйл. Танхимыг татаж буулгах
Дор дурдсан тохиолдолд танхимыг татаж буулгана:

1/ үйл ажиллагаагаа цашид үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн үндэслэлээр танхимыг татан буулгах тухай бүх гишүүдий хурлын шийдвэр гарсан;

2/ хуулийг удаа дараа буюу ноцтойгоор зорчсоноос танхимыг татан буулгах тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон

3/ гишүүн аж ахуйн нэгж, байгууллагын тоо 50 хүрэхгүй болсноос бүртгэх байгууллага татан буулгахаар шийдвэрлэсэн

2. Танхимыг татан буулгах асуудлыг шийдвэрлэсэн байгууллага татан буулгах комисс томилно.

3. Татан буулгах комисс Иргэний хуулийн 31 дүгээр зүйл заасан ажиллагааг явуулна.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
ХТГ

ГАДААД ХУДАЛДААНЫ АРБИТРЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь гадаад эдийн засгийн хэлцэл, э хөрөнгийн шинжтэй харилцаанаас үүссэн эрх зүйн маргаанта холбогдуулан ашиг сонирхлоо хамгаалж иргэн хуулийн этгээдэд гаргасан нэхэмжлэлийг гадаад худалдааны арбитрт арбитры хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Арбитрын тухай хууль тогтоомж,
олон улсын гэрээ

1. Арбитрын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

3 дугаар зүйл. Гадаад худалдааны арбитр

1. Гадаад худалдааны арбитр нь энэ хуульд заасан маргааныг арбитрын хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх үйл ажиллагааг эрхлэн явуулах бүрэн эрх бүхий төрийн бус, ашгийн төлөө бус хуулийн этгээд мөн.

2. Гадаад худалдааны арбитрын үүргийг Монголын үндэсний танхим дэргэдэх арбитр /цаашид "арбитр" гэх/ гүйцэтгэнэ.

3. Арбитр нь Улаанбаатар хотод байрлана.

4. Арбитр нь дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, 15-аас доошгүй арбитрчдын бүрэлдэхүүнтэй байна. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэнийг арбитрын бүрэлдэхүүнд томилдохгүй.

5. Арбитрын дарга, арбитрчдыг үндэсний танхимын зөвлөл 3 жилийн хугацаагаар томилно.

6. Арбитрын ерөнхий нарийн бичгийн даргыг зөвлөл томилно.

7. Арбитр өөрийн дүрэмтэй байх бөгөөд түүнийг зөвлөл батална.

4 дүгээр зүйл. Арбитрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

1. Арбитрын үйл ажиллагааг хэвийн явуулахад үндэсний танхим бүх талын дэмжлэг үзүүлнэ.

2. Арбитрын дарга, ерөнхий нарийн бичгийн даргын цалин хөлс, арбитрчдын урамшууллын хэмжээг үндэсний танхимын зөвлөл тогтооно.

5 дугаар зүйл. Арбитрын тухай гэрээ, хэлэлцээр

1. Гэрээт харилцаанаас үүсэх маргааныг арбитраар шийдвэрлүүлэх талаар талууд харилцан тохиролцож гэрээнд заах буюу бие даасан хэлэлцээр байгуулна.

2. Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээрт маргааныг арбитраар шийдвэрлүүлэх тухай заасан бол уг хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээний хувьд арбитрын тухай хэлэлцээр байгуулагдсанд тооцно.

6 дугаар зүйл. Арбитрын харьяалан шийдвэрлэх маргаан

Арбитр нь арбитрын гэрээ, хэлэлцээр бүхий дараахь маргааныг харьяалан шийдвэрлэнэ:

1/ нэг талаас Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, нөгөө талаас гадаад улсын иргэн, хуулийн этгээдийн хооронд гадвад эдийн засгийн гэрээ, хэлцлээс үүссэн болон мөнхүү гэрээний өмнөх маргаан;

2/ Монгол Улсад ажиллаж байсан гадвадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дотоодын болон гадвадын үүсгэн байгуулагчдын хооронд үүссэн маргаан;

3/ гадаадын хуулийн этгээдийн хоорондын маргаан.

7 дугаар зүйл. Маргааныг арбитрт шилжүүлэх

Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан эрх зүйн маргааны аль нэг тал шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд түүнийг Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу арбитрт шилжүүлнэ.

8 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэхэд баримтлах эрх зүйн болон заншлын хэм хэмжээ

1. Арбитр хэргийг хянан шийдвэрлэхдээ талуудын тохиролцон сонгож авсан улсын хууль тогтоомж буюу олон улсын гэрээ, хэрэв талууд энэ талаар тохиролцоогүй бол аль нэг талын харьяалагдах улсын хууль тогтоомж буюу олон улсын гэрээг баримтлана.

2. Арбитр имар ч хэргийг шийдвэрлэхдээ талуудын хооронд байгуулсан гэрээ, тухайн хэлцлийн талаар тогтсон заншлын хэм хэмжээг нэгэн адил баримтлана.

9 дүгээр зүйл. Нэхэмжлэл, арбитрт хэрэг үүсгэх

1. Энэ хуульд зааснаар арбитраар шийдвэрлүүлэхээр гаргасан тус улсын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн арбитрын хэрэг /цаашид "хэрэг" гэх/ үүсгэнэ.

2. Нэхэмжлэлд талуудын нэр, хаяг, тухайн арбитраар маргааныг шийдвэрлүүлэхээр тохиролцсон гэрээ, хэлэлцээр, нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үндэслэх нотлох баримтууд, нэхэмжлэлийн үнийг зааж, арбитрын зардал төлсөн баримтыг хавсаргана.

3. Хариуцагч сөрөг нэхэмжлэл гарганаал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

10 дугаар зүйл. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах

1. Дараахь үндэслэлийн аль нэг нь байвал арбитр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана:

1/ арбитраар харьяалан шийдвэрлэх маргаан бий бол;

2/ эрхийн чадамжгүй буюу төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан бол;

3/ нэхэмжлэлд дурдсан асуудлыг шийдвэрлэсэн шүүхийн буюу арбитрын хүчин төгөлдөр шийдвэр байгаа бол.

2. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах асуудлыг арбитрын дарга шийдвэрлэнэ.

11 дүгээр зүйл. Талууд арбитрын өмнө эрх тэгш байх

Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг иргэдийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин, шүтлэг, үзэл бодол, боловсрол, улсын харъяалал, болон бусад байдал, аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэр, эрх хэмжээ, гишүүний байдал, улсын харьяаллаар нь илгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явуулна.

12 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хэл

1. Арбитрт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулна.

2. Хэргийн оролцогчид нь монгол хэл мэдэхгүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэлмэрчээр дамжуулан тэдэнд танилцуулна. Хэргийн оролцогчдыг цугларсан баримттай хэлмэрчээр туслуулан танилцах боломжоор арбитр хангана.

3. Арбитр шаардлагатай бүх баримт бичгийг монгол хэл дээр орчуулахыг талуудаас шаардах эрхтэй.

13 дугаар зүйл. Арбитрын хуралдаан явуулах хэлбэр, нууц хадгалах

1. Арбитрын хуралдааныг нээлттэй явуулна.

2. Хэргийн нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний болон талуудын худалдааны нууцтай холбогдолтой бол арбитр өөрийн санаачилгаар буюу талуудын хүсэлтээр хуралдааныг хаалттай явуулж болно. Энэ тохиолдолд шийдвэрийг ил сонсоно.

3. Арбитрын хуралдааны үед илэрхий болсон төр, байгууллага, хувь хүний нууцыг хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн болон хуралдаанд оролцогчид хадгалах үүрэгтэй.

14 дүгээр зүйл. Хэрэг хэлэлцэх хугацаа

1. Хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээрээр тусгай хугацаа тогтоогоогүй бол арбитрын хэргийг нэхэмжлэл хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор хянан хэлэлцэнэ.

2. Хэргийг хэлэлцэх хугацааг талуудын тохиролцсоноор буюу хүндэтгэн үзэх шалтгаантай бол хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн өөрийн санаачилгаар сунгаж болно.

15 дугаар зүйл. Хэрэг хэлэлцэх газар

1. Хэргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт хэлэлцэн шийдвэрлэнэ.

2. Талууд тохиролцон хүсэлт гаргавал өөр улсын нутаг дэвсгэрт хэргийг хэлэлцэхээр хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн шийдвэрлэж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн, түүний бүрэн эрх, хэргийн оролцогчид

16 дугаар зүйл. Хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн, түүнийг томилох

1. Талууд нэг арбитрчаар шийдвэрлүүлэхээр тохиролцоогүй бол гурван арбитрчийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг хянан шийдвэрлэнэ.

2. Хэргийг гурван арбитрч шийдвэрлэх бол тал тус бүр нэг арбитрч томилж, томилогдсон хоёр арбитрч хуралдаан даргалах гуравдахь арбитрчийг томилно.

3. Хэрэв аль нэг тал арбитраас мэдэгдэл авснаас хойш 14 хоногийн дотор арбитрчийг томилоогүй буюу томилогдсон хоёр арбитрч тогтоосон хугацаанд гуравдахь арбитрчийг томилоогүй бол түүнийг арбитрын дарга томилно.

4. Хэргийг нэг арбитрчаар шийдвэрлүүлэхээр тохиролцсон боловч талууд түүнийг томилж чадаагүй бол арбитрын дарга томилно.

17 дугаар зүйл. Арбитрчийг татгалзан гаргах үндэслэл

Дараахь үндэслэл байвал арбитрч хэрэг хэлэлцэхэд оролцож болохгүй:

1/ арбитрч нь тухайн хэргийн оролцогчийн төрөл садан, эсхүл хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүнд хоорондоо төрөл садан хүмүүс орсон байвал;

2/ нэхэмжлэгч, харилцагчийн аль нэгийн нь хувь нийлүүлэгч байх буюу бусад байдлаар тухайн хэрэгт хувийн сонирхолтой байвал;

3/ тухайн маргаан бүхий харилцаанд талуудын аль нэгний өмгөөлөгч, зөвлөгчөөр урьд оролцож байсан бол;

4/ хэргийг шударгаар шийдвэрлэж чадахгүй гэсэн үндэслэл бүхий бусад шалтгаан байвал.

18 дугаар зүйл. Арбитрчийг татгалзах

1. Энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан үндэслэл байна гэж үзвэл томилогдсон арбитрч энэ тухайгаа түүнийг томилсон этгээдэд мэдэгдэж өөрөө татгалзан гарах үүрэгтэй. Дээрх үндэслэлээр аль ч арбитрчийг талууд хэрэг шийдвэрлүүлэхээс татгалзаж болно.

2. Арбитрчийг томилсны дараа илэрхий болсон үндэслэлээр арбитрч томилсон тал түүнийг татгалзан гаргах эрхтэй. Арбитрын дарга энэ үндэслэлээр өөрийн томилсон арбитрчийг сольж болно.

3. Татгалзлыг хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүнд орж буй бусад арбитрчид шийдвэрлэнэ. Хэргийг нэг арбитрч шийдвэрлэх тохиолдолд түүнийг татгалзсан, эсхүл хоёр буюу бүх арбитрчийн эсрэг татгалзал гарсан бол түүнийг арбитрын дарга шийдвэрлэнэ. Харин арбитрч өөрөө татгалзсан бол энэ журам хамаарахгүй.

19 дүгээр зүйл. Хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүний
бүрэн эрх

1. Хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан асуудлаар тогтоол гаргах эрхтэй.

2. Хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн бүрэн эрхээ хэтрүүдэн тогтоол гаргасан гэж аль нэг тал үзвэл хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны аль ч үед гомдол гаргаж болно.

3. Хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн гомдлыг хянан үзэж, 7 хоногийн дотор харжу өгнө. Өгсөн харжууг аль нэг тал хүлээн зөвшөөрөөгүй бол арбитрын даргад гомдлоо гаргаж болно. Ийнхүү гомдол гаргасан явдал арбитраас хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг үргэлжлүүлэхэд свад болохгүй. Арбитрын дарга энэ гомдлыг хянаж, 7 хоногийн дотор харжу өгнө.

20 дугаар зүйл. Арбитрчийн бүрэн эрх дуусгавар болох.

Хэргийг шийдвэрлэхээр томилогдсон арбитрч тодорхой шалтгааны улмаас үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон эсхүл өөрөө татгалзсан буюу талууд түүнийг татгалзан гаргасан тохиолдолд арбитрчийн тухайн хэргийг шийдвэрлэх бүрэн эрх дуусгавар болно.

21 дугаар зүйл. Арбитрчийг солих.

Энэ хуулийн 20 дугаар зүйлд зааснаар арбитрчийн бүрэн эрх дуусганаар болсон бол өөр арбитрчийг энэ хуульд заасан журмаар томилно.

22 дугаар зүйл. Хэргийн оролцогчдын бүрэлдэхүүн

Талууд, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгчийг хэргийн оролцогчид гэнэ.

23 дугаар зүйл. Талууд

1. Нэхэмжлэгч, хариуцагчийг талууд гэнэ.

2. Нэхэмжлэгч нь нэхэмжлэл гаргасан үндэслэл буюу нэхэмжлэлийг өөрчлөх, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасгах, эсхүл нэхэмжлэлээс бүрмөсөн татгалзах, эвлэрэн хэлэлцэх эрхтэй.

3. Хариуцагч нь нэхэмжлэлийг зөвшөөрөн хүдээхээс татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, эвлэрэн хэлэлцэх эрхтэй.

24 дугаар зүйл. Хэргийн оролцогчдын эрх, үүрэг

1. Оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоходоо дараахь эрх эдэлнэ:

1/ хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны аль ч үед хэргийн материалтай танилцах;

2/ хуралдаан дэргалзгчийн зөвшөөрлөөр хуралдааны үед бусад оролцогчдод асуулт тавих;

3/ шинжээч томилох, үзлэг явуулах зэрэг ажиллагаа гүйцэтгэхийг арбитрт хүсэх, арбитрын хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах хүсэлт тавих;

4/ арбитрчид, шинжээч, хэлмэрчийг татгалзах.

2. Оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоходоо дараахь үүрэг хүлээнэ:

1/ арбитрт гаргаж өгсөн нэхэмжлэл болон бусад бүх бичиг баримтын хуулбарыг ногоо талд илгээх;

2/ арбитрын тавьсан шаардлагыг бислүүлэх;

3/ арбитрын хүчин төгөлдөр шийдвэрийг бислүүлэх.

25 дугаар зүйл. Гуравдагч этгээд

1. Гэрээт харилцаанд оролцож байгаа гуравдагч этгээд нь өөрийн эрх, ашиг сонирхлыг хөндөгдөж байна гэж үзвэл маргаж байгаа зүйлийн талаар бие даасан шаардлага гаргаж, уг хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд арбитрын шийдвэр гарахаас өмнө оролцож болно. Ийнхүү оролцсон этгээд нэхэмжлэгчийн бүрэн эрхийг эдэлнэ.

2. Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийн бүрэн эрхийг эдэлж оролцоно.

26 дугаар зүйл. Хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны эрхийг залгамжлан авах

1. Маргалдаж байгаа талуудын аль нэг нь уг хэрэгт оролцох боломжгүй болсон, иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан, шаардлага, үүргээ, бусдад шилжүүлсэн бол арбитр тэрхүү талыг түүний эрх залгамжлан авбал зохих этгээдээр сольж болно. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд хийгдэж болно.

2. Эрх залгамжлагч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарсан этгээдийн гүйцэтгэвэл зохих үүргийг эрх залгамжилсан хэмжээгээр хариуцна.

27 дугаар зүйл. Хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд талуудыг төлөөлөх

1. Талууд нь өөрсдөө буюу төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.

2. Төлөөлөгчийн бүрэн эрхийг хуульд заасны дагуу бүрдүүлсэн итгэмжлэлээр тодорхойлно. Итгэмжлэлд талуудын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх эрхийн заримыг төлөөлөгчид эдлүүлэхгүй байхаар зааж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Нотлох баримт

28 дугаар зүйл. Нотлох баримт

1. Талуудаас өөрсдийн шаардлага, татгалзлаа үндэслэж байгаа, арбитр хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг нотлох баримт гэнэ.

2. Арбитрын хэрэгт нотлох баримт нь талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээдийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл /гэрээ, хэлэлцээр, протокол, тодорхойлолт, төлбөрийн даалгавар, тооцооны баримт, хилээр нэвтрүүлэх барааны гаалийн мэдүүлэг, чанарын сертификатыг гэх мэт/ болон эд мөрийн баримт, шинжээчийн дүгнэлт, үзлэгийн тэмдэглэлээс бүрдэнэ.

29 дүгээр зүйл. Нотлох баримт гаргах, цуглуулах

1. Талууд тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээд нь өөрийн шаардлага, татгалзлын үндэс болж байгаа нөхцөл байдлыг өөрөө нотлох үүрэгтэй.

2. Талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээд нь хуурамч нотлох баримт гаргах буюу хууль бус аргаар цуглуулахыг хориглоно. Ийм арга хэлбэрээр гаргасан нотлох баримт нь нотлох чанараа алдах бөгөөд арбитрын шийдвэрийн үндэслэл болохгүй.

3. Нотлох баримтыг арбитрын хуралдаан эхлэхийн өмнө болон хуралдааны үед гаргаж болно.

4. Арбитрын хуралдааны явцад шинэ нотлох баримт бүрдүүлэхийг талууд хүсвэл хуралдааныг хойшлуулж түүнийг гаргаж өгөхийг талуудаас шаардах буюу эсхүл арбитр энэ хуулийн 30, 33 дугаар зүйлд заасан ажиллагаа явуулж болно.

30 дугаар зүйл. Шинжээч, түүний эрх, үүрэг,
шинжээчийн дүгнэлт

1. Хэрэв талууд өөрөөр тохиролцоогүй бол хэргийг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, соёл урлаг, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд арбитр хэргийн оролцогчийн хүсэлтээр буюу өөрийн санаачилгаар шинжээч томилно.

2. Шаардлагатай бол хэд хэдэн шинжээчийг нэгэн зэрэг томилж болох бөгөөд тэдгээр нь санал нэгтэй байвал нэг дүгнэлт гаргана. Харин аль нэг шинжээч нь бусад шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал дүгнэлтээ тусад нь гаргаж болно.

3. Хэрэгт холбогдолтой бүх төрлийн баримт мэдээлэл, бараа, бусад эд зүйлийг шинжээчид гаргаж өгөхийг арбитр талуудаас шаардаж болно.

4. Талууд хүссэн болон шаардлагатай тохиолдолд арбитрын дуудсанаар шинжээч хүрэлцэн ирэх, дүгнэлтээ тайлбарлах, тавьсан асуултад үнэн зөв хариулах үүрэгтэй.

5. Шинжээч нь шаардлагатай гэж үзвэл тухайн хэргийн материалтай танилцах, нэмэлт материал гаргаж өгөхийг арбитрт хүсэх эрхтэй.

6. Шинжээч дүгнэлтээ бичгээр гаргаж, гарын үсгээ зурна. Ямар шинжилгээ хийсэн түүний үндсэн дээр гарсан дүгнэлт, арбитраас тавьсан асуултад өгсөн үндэслэл бүхий хариулыг шинжээчийн дүгнэлтэд тодорхой бичнэ.

31 дүгээр зүйл. Хэлмэрч

1. Хэргийн оролцогч нь монгол хэл мэдэхгүй, түүгээр харилцаж чадахгүй бол хэлмэрчээ өөрөө сонгон авна.

2. Хэлмэрч нь тухайн этгээдийн нэхэмжлэл, хүсэлт, тайлбар, түүнчлэн оролцогчдын тайлбар, хүсэлт, арбитрын хуралдааны болон хянан шийдвэрлэх бусад ажиллагаа, арбитрын шийдвэрийн агуулгыг түүнд хэлмэрчилж өгөх, хэргийн материалтай танилцахад нь туслах үүрэгтэй.

3. Хэлмэрч нь арбитрын дуудсанаар хүрэлцэн ирэх, үнэн зөв хэлмэрчлэх үүрэгтэй.

32 дугаар зүйл. Шинжээч, хэлмэрчийг татгалзах

1. Шинжээч дүгнэлтийг шударгаар гаргах, хэлмэрч үнэн зөв хэлмэрчлэх нь эргэлзээтэй гэж талууд үзвэл тэдгээрийг татгалзаж болно.

2. Шинжээч хэлмэрчийг татгалзан гаргах асуудлыг хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

33 дугаар зүйл. Үзлэг хийх

1. Арбитр хэргийг хянан шийдвэрлэхдээ зарим байдлыг тодруулахын тулд бараа, эд зүйл, баримт бичигт үзлэг хийж болно.

2. Үзлэгийг хэргийн оролцогчдыг оролцуулан хийж, энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу тэмдэглэл үйлдэнэ. Хэргийн оролцогчид ирээгүй явдал нь үзлэг хийхэд саад болохгүй.

34 дүгээр зүйл. Тэмдэглэл

1. Арбитр хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан болон хуралдаанаас гадуур явагдсан бусад ажиллагааны явцын тухай дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлийг хуралдааны нарийн бичгийн дарга хөтөлнө.

2. Тэмдэглэлд хуралдаан болон ажиллагааг хэн, хэзээ, хаана явуулсан, түүний эхэлсэн, дууссан цаг, түүнд оролцогчдын овог, нэр, хаяг, түүнчлэн үйл ажиллагааны дэс дараалал, явц, алэрсэн нөхцөл байдлыг бичнэ.

3. Хэргийн оролцогчид хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, түүнд засвар оруулахаар хүсэлт гаргаж болно. Түүнд хуралдаан даргалагч болон хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг турна.

4. Арбитрын бусад ажиллагааны тэмдэглэлд оролцсон, байлцсан бүх хүн гарын үсэг зурна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Арбитрын зардал

35 дугаар зүйл. Арбитрын зардал

1. Арбитрын зардал нь үндсэн болон нэмэлт зардлаас бүрдэнэ.

2. Арбитрчдын урамшуулал болон арбитрын үйлчилгээнд зориулан нэхэмжлэлийн үнийн дүнгийн тодорхой хувь хэмжээгээр талуудаас төлж буй зардлыг үндсэн зардал гэнэ.

3. Үндсэн зардлын хэмжээг арбитрын даргын санал болгосноор Сангийн сайд тогтооно.

4. Арбитрт хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллаганы явцад гарсан дараахь зардлыг нэмэлт зардал гэнэ:

1/ шинжээчийн тээвэр, байр, хоолны зардал, арбитрын шийдвэрээр гүйцэтгэсэн ажил нь үүрэгт ажилд нь хамаарахгүй бол ажлын хөлс;

2/ үзлэг хийхэд гарсан зардал;

3/ арбитрын байнгын байрлах газраас өөр газарт арбитрын хуралдаан хийсэнтэй холбогдсон зардал.

36 дугаар зүйл. Арбитрын үндсэн зардлыг хуваарилах

1. Арбитрын үндсэн зардлыг нэхэмжлэл бүрэн хангагдсан тохиолдолд хариуцагчаар, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нөхцөлд нэхэмжлэгчээр төлүүлнэ.

2. Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол арбитрын үндсэн зардлыг хангасан буюу хэрэгсэхгүй болгосон нэхэмжлэлийн үнийн дүнд дүйцүүлэн нэхэмжлэгч, хариуцагчид хуваарилан хариуцуулна.

37 дугаар зүйл. Арбитрын нэмэлт зардлыг нөхөн
толүүлэх

1. Арбитрын нэмэлт зардлыг дараахь журмаар тооцож буруутай талаас нөхөн төлүүлнэ:

1/ шинжээчид олгох тээвэр, байрны зардлыг зохих баримтыг үндэслэн хоолны зардлыг тус улсын хууль тогтоомжийн дагуу ажлын хөлсийг дундаж үнэлгээгээр;

2/ энэ хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 2, 3-т завсан зардлыг гүйцэтгэлийн баримтаар.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт завсан асуудлыг хэрэг хэрэгсэхгүй болгосон тогтоолд буюу хэрэг шийдвэрлэсэн шийдвэрт заана.

38 дугаар зүйл. Арбитрын үндсэн зардлын зарим хэсгийг буцаан олгох

1. Арбитрын хуралдааныг хийхээс өмнө талууд эвлэрэн хэлэлцсэн, нэхэмжлэгч нэхэмжлэлээ буцаан авсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүрснээр хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл хэргийг нэг арбитрч шийдвэрлэсэн бол гарсан зардлыг харгалзан үндсэн зардлын зарим хэсгийг буцаан олгоно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт завсан асуудлыг хэрэг хэрэгсэхгүй болгосон тухай тогтоолд буюу хэрэг шийдвэрлэсэн шийдвэрт заана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Арбитрын хуралдаанаар хэргийг хянан хэлэлцэх

39 дүгээр зүйл. Хэрэг хянан хэлэлцэх журам

1. Талууд тохиролцож арбитрт хэрэг хянан хэлэлцэх журмыг тогтоож болно.

2. Талууд хэрэг хянан хэлэлцэх журам тогтоох талаар тохиролцоогүй бол арбитр энэ хуулийн дагуу хэргийг хянан хэлэлцэнэ.

40 дүгээр зүйл. Арбитрын хуралдааныг нээх

Арбитрын хуралдаан даргалагч хуралдааныг нээж ямар хэрэг хэлэлцэх, талууд тэдгээрийн маргааны агуулгын талаар мэдэгдэнэ.

41 дүгээр зүйл. Хуралдааны ирц, оролцогчдын эрхийг шалгах

1. Арбитрын хуралдааны ирцийг хуралдааны нарийн бичгийн дарга бүртгэж мэдээлнэ.

2. Хуралдаан даргалагч оролцогчидтой нэг бүрчлэн танилцаж, албан тушаалтан буюу төлөөлөгчийн бүрэн эрх, итгэмжлэлийг шалгана.

42 дугаар зүйл. Талууд, тэдгээрийн төлөөлөгч арбитрын хуралдаанд ирээгүйгээс гарах холбогдол

1. Талууд тэдгээрийн төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол арбитрын хуралдааныг хойшлуулна. Хэрэв тэдгээр нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол цугларсан материалыг үндэсэн хэргийг хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.

2. Бусад оролцогч ирээгүй тохиолдолд хэргийг хинан хэлэлцэх эсэхийг хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

43 дугаар зүйл. Хэргийн оролцогчдын эрх, үүргийг тайлбарлаж өгөх

Хуралдаан даргалагч хэргийн оролцогчдод тэдний эрх, үүргийг тайлбарлаж өгнө.

44 дүгээр зүйл. Хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх

Шинэ нотлох баримт бүрдүүлэх, хэрэг хэлэлцэхтэй холбогдсон бусад асуудлын талаар талууд, тэдгээрийн төлөөлөгчдөөс гаргасан хүсэлтийг бусад оролцогчдын саналыг сонсмогц хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн даруй шийдвэрлэж мэдэгдэнэ.

45 дугаар зүйл. Хэргийг шилжүүлэх

Нэхэмжлэлийг харьяаллын дагуу нэгэнт хүлээн авсан бол арбитр уг хэргийг хинан шийдвэрлэж дуусгах ёстой боловч талуудын тохиролцсоноор өөр улсын арбитрт шийдвэрлүүлэх хүсэлт гаргавал арбитрын хуралдаанаас өмнө тухайн хэргийг шилжүүлж болно.

46 дугаар зүйл. Хэргийг хэлэлцэж эхлэх

1. Хэрэг хэлэлцэх ажиллагаа нь илтгэгч хэргийн талаар илтгэснээр эхэлнэ.

2. Нэхэмжлэгч нэхэмжлэлээ дэмжиж байгаа эсэх, хариуцагч нь нэхэмжлэгчийн шаардлагыг зөвшөөрч байгаа эсэх, талууд эвлэрсэн хэлэлцэх хүсэлтэй байгаа эсэхийг хуралдаан даргалагч асууна.

47 дугаар зүйл. Хэргийг хэрэгсэхгүй болгох

1. Арбитр дараахь тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгоно:

1/ нэхэмжлэгч өөрийн шаардлагаас татгалзсаныг хариуцагч эсэргүүцээгүй бөгөөд түүний хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхгүй гэж хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн үзсэн;

2/ талууд эвлэрсэн, хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг зөвшөөрсөн хүлээсэн;

3/ талуудын аль нэг нь болох иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан бөгөөд тэдгээрийн эрх залгамжлагч байхгүй;

4/ хоон хэлэлцэх хугацаа дууссан.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан асуудлаар гаргасан тогтоолыг арбитрын шийдвэрийн нэгэн адил журмаар биелүүлнэ.

48 дугаар зүйл. Нотлох баримтыг шинжлэх

1. Хуралдаан дээр гэрч шинжээчийн тайлбарыг сонсож, хэрэгт авагдсан бичмэл болон эд мөрийн баримтыг нэг бүрчлэн шинжлэн судална.

2. Хэргийн оролцогчид нь хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр гэрч, шинжээчид асуулт тавьж болно.

3. Нотлох баримтыг шинжлэн судалсны дараа хуралдаан даргалагч нь нэмж тодруулах зүйл байгаа эсэхийг хэргийн оролцогчдоос асууна.

49 дүгээр зүйл. Хэргийн оролцогчид харилцан асуулт тавьж тайлбар авах

1. Нэхэмжлэгч, түүний талд оролцож байгаа гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч нь шаардлага, түүний үндэслэлээ гаргаж нотлох бөгөөд хариуцагч түүний талд оролцож байгаа гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч татгалзал, түүнийг үндэслэж байгаа нотлох баримтаа гаргаж, харилцан асуулт тавьж, тайлбар авч болно.

2. Ийнхүү харилцан асуулт тавьж, тайлбар авч байх үед хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн хэдийд нь ч асуулт тавьж тодруулж болно.

50 дугаар зүйл. Шийдвэр сонсох, хуралдаан хаах

Хэргийн талаар авагдсан нотлох баримтыг бүх талаас нь шинжлэн судалж, хэргийн оролцогчдын шаардлага, тайлбарыг сонссоны дараа хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн тусгайлан зөвлөлдөж шийдвэр гарган, түүний агуулгыг сонсож, хуралдаан хавсныг мэдэгдэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Арбитрын шийдвэр, түүнийг гаргах, биелүүлэх

51 дүгээр зүйл. Арбитрын шийдвэр гаргах

1. Арбитраас хэрэг хянан хэлэлцээд шийдвэр гаргана.

2. Арбитрын шийдвэр эцсийн бөгөөд заавал биелэгдэх хүчинтэй байна.

3. Арбитрын шийдвэр нь хэрэгт байгаа болон хуралдаан дээр хэлэлцэгдсэн нотлох баримтын үндсэн дээр гарсан хууль ёсны үндэслэл бүхий байна.

4. Хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн арбитра шийдвэрийг олонхийн саналаар бичгээр гаргаж, гарын үсгээ зурна.

52 дугаар зүйл. Арбитрын шийдвэрийн агуулга

1. Арбитрын шийдвэрт дараахь зүйлийг заана:

1/ Арбитрын нэр, шийдвэр гаргасан газар, хугацаа;

2/ шийдвэр гаргасан үндэслэл;

3/ нэхэмжлэлийн шаардлагыг хэрхсэн тухай;

4/ талуудын хариуцах арбитрын зардлын хэмжээ.

2. Арбитр хэргийг хянан хэлэлцээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

1/ нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангах;

2/ нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгох;

3/ нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох.

53 дугаар зүйл. Нэмэлт шийдвэр гаргах

1. Шийдвэр гарсан өдрөөс хойш 60 хоногийн дотор арбитр өөрийн санваачилгаар буюу талуудын хүсэлтээр дараахь тохиолдолд нэмэлт шийдвэр гаргаж болно:

1/ нэхэмжлэлийн ямар нэг шаардлагын талаар шийдвэр гаргалгүй орхигдуулсан;

2/ нэхэмжлэгчийн шаардаж авах мөнгө, эд хөрөнгийн хэмжээ буюу хариуцагч нь ямар ажиллагаа гүйцэтгэхийг заагаагүй;

3/ арбитрын зардлыг цохон төлүүлэх асуудлыг шийдвэрлээгүй;

4/ шийдвэрийг тайлбарлах болон тооцооны алдааг залруулах шаардлагатай;

5/ хэргийн оролцогчид эрхийн чадамжгүй болох нь илэрсэн;

6/ энэ хуульд заасан хэрэгсэллэмэ бус маргаан шийдвэрлэсэн.

2. Арбитрын шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар нэмэлт шийдвэр гаргахыг аль ч тал арбитрт хүсэж болно. Арбитрт хүсэлт гаргасан тал энэ тухайгаа мөнгө талд мэдэгдэх үүрэгтэй.

3. Арбитр шийдвэр гаргаснаас хойш 30 хоногийн дотор өөрийн санваачилгаар, эсхүл талуудын тавьсан хүсэлт үндэслэлтэй гэж үзвэл энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-4-г заасан үндэслэлээр шийдвэрээ залруулах, өөрчлөх, тайлбарлах байдлаар, 5, 6-д заасан үндэслэлээр шийдвэрээ хүчингүй болгох байдлаар нэмэлт шийдвэр гаргана. Шийдвэрээ залруулах, өөрчлөх, тайлбарлах байдлаар гаргасан нэмэлт шийдвэр нь урьдах шийдвэрийн нэгэн адил хүчинтэй бөгөөд түүний бүрэлдэхүүн хэсэг нь болно.

Урьдахь шийднэрээ хүчингүй болгосон бол нэмэлт шийдвэр хүчинтэй байна.

4. Арбитр шаардлагатай бол нэмэлт шийдвэр гаргах хугацааг сунгаж болно.

54 дүгээр зүйл. Арбитрын шийдвэр хүчин төгөлдөр болох

1. Арбитрын шийдвэр нь гарсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

2. Арбитрын шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа хэргийн оролцогчид буюу тэдгээрийн эрх залгамжлагчид арбитраар нэгэнт шийдвэрлэсэн нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээр арбитрт болон шүүхэд дахин нэхэмжлэл гаргахгүй.

55 дугаар зүйл. Арбитрын тогтоол, түүнийг гаргах

Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 10 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн 2, 14 дүгээр зүйлийн 2, 15 дугаар зүйлийн 2, 16 дугаар зүйлийн 3, 4, 18 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 25 дугаар зүйл, 26 дугаар зүйлийн 1, 29 дүгээр зүйлийн 4, 30 дугаар зүйлийн 1, 32 дугаар зүйлийн 2, 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 42, 45, 47 дугаар зүйлд заасан тохиолдолд арбитрын тогтоол гаргана. Арбитрын тогтоолыг хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн, тэдгээр нь томилогдоогүй бол арбитрын дарга бичгээр гаргана.

56 дугаар зүйл. Арбитрын шийдвэрийг биелүүлэх

1. Талууд арбитрын шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй.

2. Талууд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар гүйцэтгүүлэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд хүсэлт гаргана. Уг хүсэлтэд арбитрын шийдвэр болон арбитрын тухай гэрээ, хэлэлцээрийн эх буюу түүний зохих ёсоор гэрчилсэн хуулбарыг хаясргаана.

3. Арбитрын шийдвэрийг Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн ариантургадугаар бүлэгт заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлнэ.

4. Арбитрын шийдвэрийг гадаад улсад биелүүлэх тухай асуудлыг олон улсын гэрээ, конвенцид зааснаар зохицуулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Хууль хүчин төгөлдөр болох

57 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

1. Энэ хуулийг 1995 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2. Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдөр ажиллагаанд байгаа хэргийг хянан шийдвэрлэхэд энэ хуулийг буцааж хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 10 дугаар
сарын 31-ний өдөр

Улаанбаатар
хот

МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, БАНКНЫ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдээс банкинд мөнгөн хөрөнгө хадгалуулах, хоорондын төлбөр тооцоогоо банкнаар дамжуулан гүйцэтгэх, банкнаас зээл авах, түүнийг эргүүлэн төлөх, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо,
банкны зээлийн үйл ажиллагааны
тухай хууль тогтоомж

1. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, Банкны хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Мөнгөн хадгаламж

3 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн тухай ойлголт

1. Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд /цаашид "хадгалуулагч" гэх/-ийн мөнгөн хадгаламжийн гэрээний үндсэн дээр банк /цаашид "хадгалагч" гэх/-д хадгалуулсан үндэсний болон гадаад валютыг мөнгөн хадгаламж /цаашид "мөнгөн хадгаламж" гэх/ гэнэ.

2. Хадгалагч нь хадгалуулагчтай мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулах үедээ өөрийн үйл ажиллагаатай холбогдсон үнэн зөв мэдээлэл өгнө.

3. Хадгалагч мөнгөн хадгаламжийн хүү, хугацааг нийтэд зарлах бөгөөд уг нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн хадгалуулагч мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулж, мөнгөн хөрөнгөө хадгалуулна.

4. Банкны байгууллагаас эрхлэх мөнгөн хадгаламжийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Мөнгөн хадгаламжийн гэрээ

1. Иргэний хуулийн 364 дүгээр зүйлд заасны дагуу мөнгөн хадгаламжийн гэрээгээр банк нь хадгалуулагчийн мөнгийг хадгалах, түүнийг хадгалуулсан буюу эрх бүхий этгээдэд эргүүлэн өгөх, хариу төлбөр /хүү/ төлөх үүрэг хүлээнэ.

2. Мөнгөн хадгаламжийн гэрээнд хадгаламжийн хугацаа, хадгалуулах мөнгөн хөрөнгийн дүн, хүү тосгох журам, мөнгөн хадгаламжийн гэрээг цуцлах нөхцөл, гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүйн төлөө талуудын хүлээх хариуцлагыг заана.

3. Мөнгөн хадгаламжийн гэрээ нь хадгаламжийн дөвтөр, сертификат зэрэг хэлбэртэй байж болох бөгөөд Иргэний хуулийн 364 дүгээр зүйлд заасны дагуу түүнийг бичгээр хийнэ.

5 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн гэрээний хугацаа

1. Мөнгөн хадгаламжийн гэрээг Иргэний хуулийн 365 дугаар зүйлд заасны дагуу тодорхой буюу тодорхой, бус хугацаагаар байгуулж болно.

2. Тодорхой хугацаа эвэж хадгалуулсан мөнгөн хадгаламжийг хугацаатай, тодорхой бус хугацаагаар хадгалуулсан мөнгөн хадгаламжийг хугацаагүй мөнгөн хадгаламжид тооцно.

3. Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан бол хадгалагч нь хадгалуулагчийн хүссэн үед түүний хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүү төлөх үүрэгтэй.

4. Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой хугацаагаар байгуулсан бол уг хугацаа дууссаны дараа хадгалагч нь хадгалуулагчийн анхны шаардлагаар мөнгийг буцаан өгч хүү төлөх үүрэгтэй.

5. Гэрээнд заасан хугацаа дууссан боловч хадгалуулагч хадгалуулсан мөнгөө буцаан авах тухай, эсхүл гэрээг дахин сунгуулах шаардлага тавиагүй бол уг мөнгөн хадгаламжийг хугацаагүй мөнгөн хадгаламжид тооцож, хүүг хугацаагүй мөнгөн хадгаламжийн адил хэмжээгээр бодно. Хэрэв мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан бол хугацаатай мөнгөн хадгаламжийн хугацаа дууссан тохиолдолд уг гэрээний хугацааг тодорхой хугацаагаар сунгаж болно.

6. Тодорхой хугацаагаар байгуулсан мөнгөн хадгаламжийн гэрээг хадгалагч нэг талын санаачилгаар өөрчлөх, хугацаанаас өмнө цуцлах эрхгүй.

7. Мөнгөн хадгаламжийн гэрээний хугацааг дансанд орлогын гүйлгээ хийгдсэн өдрөөс эхлэн тоолж, зарлагын гүйлгээ хийгдсэн өдрөөр дуусгавар болгоно.

8. Хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээг тохиролцсон хугацаанаас өмнө хадгалуулагчийн хүсэлтээр цуцлахад хадгалуулсан хугацаанаас нь хамааруулан мөнгөн хадгаламжийн хүүг гэрээнд заасан хэмжээгээр бууруулж болно.

9. Хадгалуулагч нь хадгалуулагчвас энэ зүйлийн 3, 4, 6 дахь хэсэгт заасан үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан хохирол болон гэрээнд заасан бол анз төлүүлэхээр шаардах эрхтэй.

6 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн хүү

1. Мөнгөн хадгаламж хүүтэй байна.

2. Хугацаатай мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээ нь мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хугацааг дуустал анх тохиролцсон хэвээр байна.

3. Мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хүүгийн хэмжээ өөрчлөгдөөгүй тохиолдолд хугацаатай мөнгөн хадгаламжид орлогын гүйлгээ хийгдэх хүүг уг гэрээний дагуу хэвээр мөрдөнө. Хадгалагчийн тогтоосон хүүгийн хэмжээ өөрчлөгдсөнөөс хойшхи хугацаанд хийсэн аливаа орлогын хувьд мөнгөн хадгаламжийн гэрээг шинээр байгуулна.

4. Хугацаагүй мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг хадгалагчаас өөрчлөх тохиолдолд энэ тухай нийтэд мэдэгдсэнээс хойш 1 сарын дараа тодорхой бус хугацаагаар байгуулсан мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хүүгийн хэмжээ өөрчлөгдсөнд тооцно. Хэрэв хадгалуулагч энэ нөхцөлийг зөвшөөрөхгүй бол гэрээг цуцалж болно.

5. Мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг бодох аргачлалыг Монголбанк батлана.

7 дугаар зүйл. Хадгалуулагч, хадгалагчийн эрх, үүрэг
Иргэний хуулийн 367 дугаар зүйл, Банкны хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу мөнгөн хадгаламжийн гэрээнд зааснаар талууд дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

1. Хадгалуулагч:

1/ хадгалуулсан мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах хэлбэрийг сонгох;

2/ хадгалуулсан мөнгөн хөрөнгөндөө хүүгийн орлого авах;

3/ мөнгөн хадгаламжийн гүйлгээ, үлдэгдлийг дансны хуулга болон мөнгөн хадгаламжийн дэвтэртэйгээ тулган шалгах;

4/ хугацаатай мөнгөн хадгаламжаас гэрээнд заасан хугацааны дотор зарлагын гүйлгээ хийхгүй байх, зайлшгүй тохиолдолд гүйлгээ хийхээр бол хүсэлтийг бичгээр гаргаж, гэрээнд өөрчлөлт оруулахаар хадгалагчтай харилцан тохиролцох;

5/ мөнгөн хадгаламжийг дундаа хамтран өмчлөх, итгэмжлэл олгох;

6/ мөнгөн хадгаламжийг өвлүүдэх, гэрээслэх, бэлэглэх;

7/ хадгалагчаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэх;

8/ талуудын харилцан тохиролцсон бусад эрх, үүрэг.

2. Хадгалагч:

1/ хадгалуулагчийн нэр дээр данс нээх буюу сертификат зэрэг үнэт цаас олгох;

2/ хадгалуулагчийн мөнгөн хөрөнгөнөөс зөвхөн түүний зөвшөөрөл буюу даалгавраар гүйлгээ хийх;

3/ гэрээнд заасан нөхцөлийн дагуу хадгалуулагчийн тавьсан анхим шаардлагаар түүний хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүү төлөх;

4/ мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг үнэн зөв бодож олгох;

5/ хадгалуулагчийн дансыг нууцыг хадгалах;

6/ өөрийн буруугаас учруулсан хохирлыг нөхөн төлөх;

7/ талуудын харилцан тохиролцсон бусад эрх, үүрэг.

3. Хадгалагч нь мөнгөн хадгаламжид авсан мөнгөн хөрөнгийг өөрийн гүйлгээнд хэрэглэн түүний бүрэн бүтэн байдлыг хангана.

8 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн данс, түүний төрөл

1. Хадгалагч нь мөнгөн хөрөнгөө хадгалуулсан иргэн, хуулийн этгээд тус бүрт мөнгөн хадгаламжийн данс нээж, Харин хадгалуулагч нь сертификат зэрэг үнэт цаас авсан бол данс нээхгүй байж болно.

2. Хадгалагч нь хадгалуулагчийн мөнгөн хөрөнгийг хадгалахдаа хууль тогтоомж болон талуудын байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол харилцах данс нээж, түүний даалгавраар төлбөр гүйцэтгэж, харилцах дансыг тогтвортой үлдэгдэлд нь хүү төлж болно.

9 дүгээр зүйл. Мөнгөн хадгаламжийн баталгаа

Хадгалагч дампуурах буюу татан буугдах тохиолдолд мөнгөн хадгаламж, түүний хүүг төлбөр тооцоо барагдуулах авлагаас тэргүүн ээлжинд олгоно.

10 дугаар зүйл. Итгэмжлэлийг үндэслэн гүйлгээ хийх

1. Хадгалуулагч нь мөнгөн хадгаламжийн орлого, зарлагын гүйлгээг итгэмжлэгдэгчээр дамжуулан хийлгэж болно.

2. Хадгалагч нь Иргэний хуулийн 61 дүгээр зүйлд заасан шаардлага хангасан хүчин төгөлдөр итгэмжлэл, итгэмжлэгдэгчийн иргэний паспорт, түүнтэй адилтгах баримт бичгийг үндэслэн гүйлгээ хийнэ.

11 дүгээр зүйл. Мөнгөн хадгаламжийг өв залгамжлуулах, гэрээслэх тохиолдолд гүйлгээ хийх

1. Хадгалуулагч нь нас барсан болон нас барсан гэж зарлагдсан тохиолдолд хадгалагч нь мөнгөн хадгаламжийг хууль ёсын буюу гэрээслэлээр өв залгамжлах эрх бүхий этгээдэд олгох, эсхүд уул гэрээг түүний нэр дээр шинэчлэн хийнэ.

2. Хадгалагч нь мөнгөн хадгаламжийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шилжүүлэхдээ өв залгамжлах эрхийн гэрчилгээ, өв залгамжлагчийн паспорт буюу түүнтэй адилтгах баримт бичгийг үндэслэн болгоно.

3. Өвлөгчид шилжээгүй өв нээгдсэн мөнгөн хадгаламжаас гүйлгээ хийхийг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төлбөр тооцоо

12 дугаар зүйл. Данс нээх, хаах

1. Иргэн, хуулийн этгээд тогтоосон журмын дагуу банкинд данс нээлгэж, төлбөр тооцооны үүрэг гүйцэтгүүлэх эрхтэй. Хуулийн этгээд данс нээлгэхийн тулд дор дурдсан баримт бичиг бүрдүүлнэ:

1/ өргөдөл;

2/ улсын бүртгээд бүртгүүлсэн гэрчилгээний баталгаатай хуулбар;

3/ мөнгөн хөрөнгө захиран зарцуулах албан тушаалтын овог, нэр төлбөр тооцооны баримтад зурах гарын үсгийн маяг. Гарын үсгийн маяг нь нотариатын баталгаатай байна;

4/ тамга, тэмдгийн дардас.

2. Иргэн данс нээлгэхийн тулд дор дурдсан баримт бичиг бүрдүүлнэ:

1/ өргөдөл;

2/ мөнгөн хөрөнгө захиран зарцуулах тухай мэдүүлэг, төлбөр тооцооны баримтад зурах гарын үсгийн маяг. Гарын үсгийн маяг нь нотариатын баталгаатай байна.

3. Банк дээр дурдсан баримт бичгийг хянан үзээд 10 хоногийн дотор данс нээх буюу энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан баримт бичгүүд эргэлзээтэй бол данс нээхээс татгалзах эрхтэй.

13 дугаар зүйл. Төлбөр тооцооны хэлбэр

1. Банкаар дамжуулан хийгдэх мөнгөн хадгаламж, зээл, харилцах дансны орлого, зарлагын гүйлгээ нь бэлэн болон бэлэн бус хэлбэрээр байж болно.

2. Банкаар дамжуулан үндэсний болон гадаад улсын бэлэн мөнгөн тэмдэгтээр хийх гүйлгээг бэлэн бус мөнгөний төлбөр тооцоо гэнэ.

3. Төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрийг Монголбанк тогтооно.

14 дүгээр зүйл. Бэлэн мөнгөний төлбөр тооцоо

1. Бэлэн мөнгөний төлбөр тооцоог банкаар дамжуулан гүйцэтгэх ажиллагааг төлбөр тооцоонд оролцогч талууд харилцан тохиролцоно.

2. Бэлэн мөнгийг банкинд төвлөрүүлэх ажиллагааг талууд харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно.

15 дугаар зүйл. Бэлэн бус мөнгөний төлбөр тооцоо

1. Иргэн, хуулийн этгээд оролцсон бэлэн бус хэлбэрээр хийх төлбөр тооцоог банкаар дамжуулан гүйцэтгэнэ.

2. Бэлэн бус мөнгөний төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, чек, нексель, төлбөрийн карт болон төлбөр тооцооны бусад баримтаар гүйцэтгэнэ.

3. Төлбөр хариуцагч, төлбөр хүлээн авагч нь бэлэн бус мөнгөний төлбөр тооцооны ямар хэлбэрээр харилцахаа өөрсдөө сонгож авна. Төлбөрийн нэхэмжлэлээр хийх төлбөрийг гагцхүү төлбөр хариуцагчийн мөнгөн хөрөнгийг зарцуулах эрх бүхий этгээдийн зөвшөөрсөн нөхцөлд гүйцэтгэнэ.

16 дугаар зүйл. Төлбөр тооцоонд оролцогч талууд

Банкаар дамжуулан хийх төлбөр тооцооны харилцаанд төлбөр хүлээн авагч, төлбөр хариуцагч оролцоно.

17 дугаар зүйл. Банкаар дамжуулан төлбөр тооцоог гүйцэтгэх

1. Банк нь иргэн, хуулийн этгээд оролцсон төлбөр тооцоог гүйцэтгэхдээ уг төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрийг шалгана. Төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрт уг баримтыг бичсэн өн, сар, өдөр, төлбөр хүлээн авагч, төлбөр хариуцагчийн дансны дугаар, нэр, тэдгээрийг үйлчлэгч банкны нэр, гүйлгээний утга, мөнгөний дүнг тоо болон үсгээр бичиж, баталгаатай гармы үсэг зурж, тамга эсхүл тэмдэг дарсан байна.

2. Хүлээн авсан дэс дарааллыг баримтлан банк төлбөр тооцоог гүйцэтгэнэ.

3. Банк нь төлбөр хариуцагчаас ирүүлсэн төлбөрийн гүйлгээг тэр өдөрт нь багтаан гүйцэтгэнэ. Энэ шаардлагыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлдэггүйгээс үүсэх анзыг Иргэний хуулийн 180 дугаар зүйлд заасан хэмжээгээр банк төлнө.

4. Данс эзэмшигчийн хүсэлтээр банк нь гүйлгээ хийгдсэн дансны хуудлыг данс эзэмшигчид өгнө.

18 дугаар зүйл. Төлбөр хүлээн авагч

Төлбөр хүлээн авагч нь ажил, үйлчилгээний үнэ, хөлс, нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүний үнийг төлбөр тооцооны тодорхой хэлбэрийн бүрдүүлбэрийг хангасан баримтын дагуу нэхэмжилнэ.

19 дүгээр зүйл. Төлбөр хариуцагч

19 дүгээр зүйл. Төлбөр хариуцагч

Төлбөр хариуцагч гүйцэтгүүлдсэн ажил, үйлчилгээний болон худалдан авсан бараа, бүтээгдэхүүний үнэ хэлсийг төлөхийг зөвшөөрсөн бол төлбөр тооцооны тодорхой хэлбэрийн бүрдүүлбэрийн дагуу төлбөр төлөх үүрэг хүлээнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Банкны зээлийн үйл ажиллагаа

20 дугаар зүйл. Банкнаас зээл олгох

1. Банк /цаашид "зээлдүүлэгч" гэх/ тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэж төлөгдөх барьцаа, эсхүл батлан даалттайгаар өөрийн болон түүнд хадгалуулсан бусдын мөнгөн хөрөнгийн зохих хэсгийг өөрийн нэрийн өмнөөс бусад этгээд /цаашид "зээлдэгч" гэх/-д олгохыг банкнаас зээл олгох /цаашид "зээл" гэх/ гэнэ.

21 дүгээр зүйл. Зээл олгох ажиллагаа

1. Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, хүүгийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг тогтоон нийтэд мэдээлнэ.

2. Зээлдүүлэгч нь хүү, хугацаа болон бусад нөхцөлийн талаар зээлдэгчтэй харилцан тохиролцож байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр түүнд зээлийн данс нээж, зээл олгоно.

3. Зээл олгох хэлбэрийг зээлдэгч, зээлдүүлэгч нь зээлийн гэрээндээ харилцан тохиролцоно.

4. Зээлдэгчийн зээлийн дансанд гүйлгээ хийгдсэнээр зээлийг олгосонд тооцоо.

5. Зээлдүүлэгч нь зээл олгохдоо тухайн зээлдэгчийн санхүүгийн чадвар, бусад банкнаас авсан зээл, мэдээллийг холбогдох байгууллаагаас авах эрхтэй.

22 дугаар зүйл. Зээлийн гэрээ

1. Иргэний хуулийн 368 дугаар зүйлд заасны дагуу банкнаас олгох зээлийн гэрээгээр банк нь өөрийн өмчлөл буюу эзэмшилд байгаа мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмаар зээлдэгч /иргэд, хуулийн этгээд, төр/-ийн өмчлөл буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, /иргэний хуулийн 88 дугаар зүйл/-д тодорхой хугацаагаар шилжүүлэх, зээлдэгч нь тогтоосон хугацаанд уг мөнгийг хүүгийн хамт буцаан төлөх үүрэг тус тус хүлээнэ. Банкнаас олгох зээлийн гэрээг бичгээр хийнэ.

2. Зээлийн гэрээнд зээлдэгч, зээлдүүлэгчийн оршин байгаа газрын хаяг, зээлийн дансны дугаар, зориулалт, зээлдэх мөнгөний дүн, хугацаа, зээлийн хүүгийн хэмжээ, уг гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангах арга хэлбэр, гэрээний нөхцөлийг өөрчлөх, гэрээг цуцлах талаар тодорхой тусгана.

3. Зээлийн гэрээний хугацаа дууссан нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй зээлдэгчийг зээлийн гэрээний үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

4. Тодорхой төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр олгох зээлийн эх үүсвэрийг зээлдүүлэгчид хамтарч гаргаж болно. Хамтарч зээл олгохдоо энэ талаар гэрээ байгуулна.

5. Монгол Улсын Засгийн газрын шугамаар гадаад орон, олон улсын байгууллагаас авсан зээлтэй холбогдсон харилцааг бусад хууль тогтоомжоор зохицуулна.

6. Засгийн газрын мэдлийн гадаад эх үүсвэр, олон улсын байгууллагын хөрөнгийн эх үүсвэрээр хийгдэх зээлийн харилцааг зээлдэгч болон Засгийн газар, төлбөр тооцоог гүйцэтгэгч банкны хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

7. Зээлийн гэрээнд авсан зээлээ бүхэлд нь буюу хэсэгчлэн эргүүлэн төлөх нөхцөлийг таах болно.

23 дугаар зүйл. Зээлийн хувийн хэрэг

1. Зээлдүүлэгч нь зээлдэгч бүрийн нэр дээр зээлийн хувийн хэрэг нээж хөтөлнө.

2. Зээлийн хувийн хэрэг дараахь бүрдүүлдэртэй байна:

1/ зээл олгохыг хүссэн өргөдөл;

2/ зээлийн гэрээ;

3/ зээлийн барьцаанд баруулах эд хөрөнгийн тодорхойлолт, үнэлгээ болон уг хөрөнгийг эзэмших эрхийн бичиг, түүнийг шалгасан баримт, эсхүл зээлийн батлан даалт, батлан даагчийн бүртгэл, судалгаа;

4/ зээлээр санхүүжигдэх объектын зохих байгууллагаар хивуулж, батлуулсан зураг төсөл, уг зураг төсөлд өрсөн өөрчлөлт, түүнтэй холбоотой төлбөр тооцооны баримт, гүйцэтгэлийн тайлан, гэрээний хувь, эдийн засгийн үр ашгийн тооцоо;

5/ захиалагч болон хөндлөнгийн шалгагчийн дүгнэлт;

6/ санхүүгийн тайлан;

7/ зээлийн ашиглалт шалгасан материал;

8/ зээлдэгчийн бусад банкнаас авсан зээлийн талаарх өөрийн болон зээлийн сангийн мэдээлэл.

3. Зээл олгохыг хүссэн өргөдөлд зээлийн зориулалт, авах зээлийн хэмжээ, хугацааны талаар товч тодорхой бичиж гарын үсэг зурж, тамга дарсан байна.

4. Зээлийн барьцаанд бариулах эд хөрөнгийн тодорхойлолтод иргэн, хуулийн этгээдээс барьцаалж байгаа эд хөрөнгийг зээлдүүлэгч банкны эрх бүхий хүмүүсээс газар дээр нь очиж, нэгбүрчлэн үзэж өгсөн үнээлэлт, дүнг тусгасан байна. Зээлийн барьцаанд бариулах эд хөрөнгийг шалгасан баримтад дээрх тодорхойлолтыг үндэслэн уг хөрөнгийн бүрэн бүтэн байдал, үнэ, чанар зэргийг бичнэ.

5. Зээлийн батлан даагчийн бүртгэлд батлан даагчийн нэр, хаяг, харилцагч банкны нэр, харилцах дансны дугаар зэргийг тусгана. Батлан даагчийн үйлдвэрлэлийн хүчин чадал, үйл ажиллагааны талаар зээлдэгчийн эзлэ судалж тэмдэглэсэн байна.

6. Зээлийн ашиглалтыг шалгасан материалд авсан зээлээ зориулалтын дагуу үр дүнтэй ашиглаж байгаа эсэхийг тодорхой тоо хэмжээ, үнийн дүнгээр нь тодорхойлж бичнэ.

7. Зээлдүүлэгч нь зээлдэгчээс энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.

24 дүгээр зүйл. Зээлийн хүү

1. Зээлийг ашигласан хугацаанд гэрээнд заасан хэмжээгээр тооцсон зээлдэгчийн хариу төлбөр буюу зээлийн үнэ нь зээлийн хүү болно.

2. Зээлийн хүүг гэрээнд заасан хугацаагаар тооцож бодно.

3. Зээлийг хугацаанд нь төлөөгүй бол Иргэний хуулийн 368 дугаар зүйлд заасны дагуу үндсэн хүү, хэрэв гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлнө. Нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээг үндсэн хүүгийн 20 хувиас хэтрүүлэхгүйгээр тогтооно.

4. Зээлийн хүүгийн хэмжээг бодох аргачлалыг Монголбанк батална.

25 дугаар зүйл. Зээлийн хугацаа хэтрэлт

1. Зээлийн гэрээнд заасан хугацаанд төлөгдөөгүй зээл, түүний хүүг хугацаа хэтэрсэн зээлийн болон тусгай дансанд бүртгэнэ.

2. Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн хэмжээг энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр зээлийн гэрээнд тусгана.

26 дугаар зүйл. Зээлийн ашиглалт

Зээлийг гэрээнд заасан зориулалтаар нь ашиглана. Олгосон зээлийн ашиглалтыг зээлдүүлэгч шалгаж, тухайн зориулалтаар олгосон зээл эргэж төлөгдөх найдваргүй гэж үзвэл зээл олголтыг зогсоож, уг зээлийг хугацаанаас нь өмнө төлүүлэхийг шаардах эрхтэй.

27 дугаар зүйл. Зээлийн ангилал

1. Зээлдүүлэгч олгосон зээлдээ судалгаа хийж, зээлийнхээ үлдэгдлийг Монголбанкнаас баталсан зааврын дагуу ангилна.

2. Монголбанк, Сангийн яамнаас тогтоосон журмын дагуу зээлдүүлэгч нь зээл төлөгдөхөд учирч болох болзошгүй алдагдлаас хамгаалах санг өөрийн ашгаас, байгалийн аюул, гамшиг, гэнэтийн осол зэрэг зээлдүүлэгчийн үйл ажиллагаанаас үл хамарах шалтгаанаар зээл төлөгдөхөд учирч болох болзошгүй алдагдлаас хамгаалах санг өөрийн ажиллагааны зардлаас байгуулна.

28 дугаар зүйл. Зээлийн батлан даалт

1. Зээлдэгч нь авсан зээл, түүний хүүг зээлийн гэрээнд заасан хугацаанд төлж чадахыг зээлдүүлэгчийн өмнө баталж, хэрэв төлж чадахгүй бол түүний нэрийн өмнөөс уг төлбөрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгэх үүргийг гуравдагч этгээд хүлээхийг зээлийн батлан даалт, батлан даалт гаргасан этгээдийг батлан даагч гэнэ.

2. Зээлдэгч нь Иргэний хуулийн 184 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу батлан даагчтай гэрээ байгуулна.

3. Батлан даагч хүлээсэн үүргээ хууль, гэрээнд заасны дагуу биелүүлж, зээлдэгчийн нэгэн адил хариуцлага хүлээнэ.

4. Батлан даагч нь санхүүгийн хувьд уг зээлийн төлбөрийг хийх чадвартай, үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгөтэй этгээд байна. Батлан даагчийн санхүүгийн чадварын талаар үйлчлэгч банк, улсын бүртгэлд бүртгэсэн байгууллага тодорхойлолт гаргаж болно.

5. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлснээр батлан даалт дуусгавар болно.

29 дүгээр зүйл. Зээлийн барьцаа

1. Зээлдэгч зээлийн гэрээнд заасан хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй тохиолдолд үүргийн биелэлтийг хангуулахаар зээлдэгчээс барьцаалсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь зээлийн барьцаа болно.

2. Зээлийн барьцаанд баруулах эд хөрөнгийн үнэлгээг зээлийн гэрээ байгуулахдаа харилцан тохиролцоно.

3. Зээлийн барьцаалсан эд хөрөнгө нь хуулиар хориглоогүй бөгөөд иргэн, хуулийн этгээдийн өөрийн хөрөнгөөр баригдсан орон сууц, үл хөдлөх эд хөрөнгө, түргэн борлогдох бараа материал, үнэт зэвсэг, үнэт цаас болон зээлдүүдэгчээс хүлээн зөвшөөрсөн бусад хөрөнгө байж болно.

4. Зээлдэгч зээлийн гэрээнд заасан хугацаандаа гэрээнийхээ үүргийг биелүүлдэггүй бол зээлийн гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн зээлийн барьцаалсан эд хөрөнгийг худалдах эрх зээлдүүдэгчид үүснэ.

5. Зээлийн барьцаалсан эд хөрөнгийг хадгалах, хамгаалах, бусдын өмчлөлд шилжүүлэхтэй холбоотой харилцааг хууль, зээлийн гэрээнд заасны дагуу зохицуулна.

6. Зээлийн барьцаалсан эд хөрөнгө үрэгдэж, устгагдсан тохиолдолд түүнээс үүдэн гарах маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

30 дугаар зүйл. Зээл төлүүлэх ажиллагаа

1. Зээлийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу зээлийг эргүүлэн төлөх үүргийг зээлдэгч хүлээнэ.

2. Зээлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол зээл, түүний хүүг төлөх хугацаа болмогц зээлдэгчийн болон батлан давгчийн данснаас үл маргалдах журмаар төлүүлнэ.

3. Зээлдэгч буюу түүний батлан давгчийн дансанд уг зээлийг төлөх мөнгөгүй бол зээлийг энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу барьцаалсан эд хөрөнгийг худалдаж төлүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл.

31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчөгчдөд хүлээлгэх хариуцлага

1. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд түүний гэм буруу, зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

2. Монгол хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийг дараахь байдлаар зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Сангийн яам, Монголбанкны хянан шалгагч болон арилжааны банкны хянан шалгагч нар нь өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд дор дурдсан шийтгэл ногдуулна:

1/ энэ хуулийн 5 дугаар зүйлийн 3, 4, 6 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт, мөн 10, 11 дэх зүйлийг зөрчиж, хадгалуулагчид хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлүүлж, банкны байгууллагын ажилтан, албан тушаалтныг 5000-20000 төгрөгөөр, хадгалагчийг 30000-150000 төгрөгөөр торгох;

2/ энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 4, 5, 6, 7-д заасныг зөрчиж, хадгалуулагчид хохирол учруулсан бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж, банкны байгууллагын ажилтан, албан тушаалтныг 10000-30000 төгрөгөөр, хадгалагчийг 50000-200000 төгрөгөөр торгох;

3/ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 3, 17 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтыг зөрчиж, бүрдүүлбэр дутуу төлбөр тооцооны баримтаар гүйлгээ хийсэн болон төлбөр тооцооны баримтыг дарагдуулсан буюу гүйлгээг саатуулсан бол банкны байгууллагын ажилтан, албан тушаалтныг 10000-50000 төгрөгөөр, банкны байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

4/ энэ хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасан зээлийн батлан даалт, барьцаалсан эд хөрөнгийн талаархи баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн байвал зээлийг зогсоож, иргэнийг 10000-20000 төгрөгөөр, албан тушаалтныг 20000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-200000 төгрөгөөр торгох.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 11 дүгээр
сарын 2-ны өдөр

Улаанбаатар
хот

ВЕКСЕЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээд болон тэдгээрийн хооронд хийх төлбөр тооцоонд векселийг хэрэглэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Векселийн тухай хууль тогтоомж

1. Векселийн тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, Банкны хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хууль тогтоомжоос өөрөөр завсан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1. "Вексель" гэж төлбөр хариуцагчгаас тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тогтоосон хугацаанд амар нэгэн нөхцөл болзолгүйгээр үл маргагдах журмаар вексель эзэмшигчид төлөхийг харилцан тохиролцож баталсан төлбөрийн баримтыг хэлнэ. Вексель нь төлбөр тооцооны үнэт цэвс мөн.

2. "Вексель бичигч" гэж тухайн векселийг бичсэн иргэн ба хуулийн этгээдийг хэлнэ.

3. "Энгийн вексель бичигч" гэж нийлүүлсэн бараа, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд нь бэлтгэн нийлүүлэгч, ажил, үйлчилгээ үзүүлэгчид төлөхийг баталж вексель бичсэн төлбөр хариуцагчийг хэлнэ.

4. "Шилжих вексель бичигч" гэж вексeld завсан төлбөрийг вексель эзэмшигчид төлөхийг төлбөр хариуцагчгаас нэхэмжилж байгаа этгээдийг хэлнэ.

5. "Вексель эзэмшигч" гэж уг векселиэр гэрчлэгдсэн эрхийг эзэмшиж байгаа иргэн ба хуулийн этгээд бөгөөд нийлүүлсэн бараа, үзүүлсэн ажил, үйлчилгээнийхээ төлбөр нэхэмжлэгчийг хэлнэ.

6. "Вексель шилжүүлэгч" гэж тухайн вексельд дамжуулах бичилт хийж түүгээр гэрчлэгдсэн эрхээ өөр этгээдэд шилжүүлж буй вексель эзэмшигчийг хэлнэ.

4 дүгээр зүйл. Векселийн төрөл, хэлбэр

1. Вексель нь энгийн, шилжих вексель гэсэн төрөлтэй байх бөгөөд тэдгээр нь зөвшөөрлийн болон мэдүүлгийн гэсэн хэлбэртэй байна.

2. Вексель бичигч тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг вексельд завсан хугацаанд вексель эзэмшигчид төлөхийг батлан бичсэн векселийг энгийн вексель гэнэ.

3. Вексель бичигч тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тогтоосон хугацаанд гуравдагч этгээдэд, эсхүл вексель эзэмшигчид төлөхийг төлбөр хариуцагчид даалгаж бичсэн векселийг шилжих вексель гэнэ.

4. Векселийн анхны эзэмшигчийн нэр хаягийг тодорхойлон бичсэн векселийг зөвшөөрлийн вексель гэнэ.

5. Эзэмшигчийн нэр хаягийг тодорхойлон заахгүйгээр "Энэ векселийг гардуулагчид төлнө" гэсэн буюу үүнтэй адил илэрхийллээр бичсэн векселийг мэдүүлгийн вексель гэнэ.

5 дугаар зүйл. Векселийн бүрдүүлбэр

1. Вексель нь дараахь бүрдүүлбэртэй байна:

1/ "Вексель" гэсэн бичвэр;

2/ тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг ямар нэгэн нөхцөл болзолгүйгээр төлөх тухай бичсэн заалт, эсхүл тэр хэмжээний мөнгөн хөрөнгө төлөхийг баталсан төлбөр хариуцагчийн зөвшөөрөл;

3/ төлбөр хариуцагчийн нэр, хаяг, төлбөр хийх банкны дахь харилцах дансны дугаар /энгийн вексельд төлбөр хариуцагч болон вексель бичигчийн нэр адилхан байна/;

4/ төлбөр гүйцэтгэх газар, төлбөр хариуцагчийн харилцах данс байгаа банкны нэр, хаяг;

5/ зөвшөөрлийн векселийн хувьд анхны эзэмшигчийн нэр;

6/ төлбөр гүйцэтгэх валютын нэр;

7/ төлбөр гүйцэтгэх хугацаа;

8/ вексель бичсэн он, сар, өдөр;

9/ вексель бичигчийн нэр, хаяг, гарын үсэг;

10/ шилжих векселийн хувьд төлбөрийн зөвшөөрөл өгсөн тэмдэглэл;

11/ "Вексельд заасан төлбөрийг үл маргалдах журмаар гүйцэтгэнэ. /Векселийн тухай хуулиас/" гэсэн бичвэр.

2. Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1, 2-т заасан нөхцөл бүхий векселийн бүрдүүлбэрт төлбөр гүйцэтгэх хугацааг "Вексель гардуулсан өдөр", эсхүл "Вексель гардуулснаас хойш . . . /тоо, үсгээр/ хоногийн дараа" гэж заана.

3. Векселийн загвар, хэрэглэх журмыг Монголбанк тогтооно.

4. Вексельд заасан төлбөрийг вексель бичсэн өдрөөс хойш нэг жил хүртэл хугацааны дотор төлсөн байхаар талууд тохиролцоно.

5. Вексельд төлбөр гүйцэтгэх зөвхөн нэг банкны нэр, хаягийг бичнэ.

6. Төлбөр гүйцэтгэх мөнгөний дүнг тоо, үсгээр засваргүй бичнэ. Мөнгөний дүнг хэд хэдэн хэсэг болгож бичихийг хоригдоно.

7. Төлбөр гүйцэтгэх хугацааг талууд харилцан тохиролцоно.

6 дугаар зүйл. Векселийг хүчин төгөлдөр бус гэж

тооцох үндэслэл

Дараахь нөхцөлд векселийг хүчин төгөлдөр бус гэж тооцно:

1/ энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрдүүлбэрийн бичилт дутуу;

2/ вексель бичигч болон төлбөрийн зөвшөөрөл өгөгч иргэний гарын үсэг, эсхүл хуулийн этгээдийн гарын үсэг, тамга буюу тэмдэггүй;

3/ векселийг батлагдсан загвар бүхий маягтан дээр бичээгүй;

4/ хуульд заасан бусад нөхцөлийг зөрчсөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Төлбөрийн зөвшөөрөл, төлбөрөөс татгалзах үндэслэл, төлбөрийг нэхэмжлэх

7 дугаар зүйл. Төлбөрийн зөвшөөрөл

1. Төлбөр хариуцагчаас төлбөр төлөхөөр зөвшөөрсөн тухай шилжих вексельд бичиж, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсныг "төлбөрийн зөвшөөрөл" гэнэ.

2. Төлбөр хариуцагчаас вексельд заасан төлбөрийг хэсэгчлэн төлөх зөвшөөрөл өгөхийг хориглоно.

3. Шилжих вексельд төлбөрийн зөвшөөрөл бичүүлэхийг вексель бичигч хариуцна.

8 дугаар зүйл. Төлбөрийн зөвшөөрөл өгөх хугацаа

1. Эзгийн вексель бичсэн өдрөөс төлбөрийн зөвшөөрөл өгсөн хугацаа эхэлнэ.

2. Шилжих вексельд төлбөрийн зөвшөөрлийг вексельд заасан төлбөрийн хугацаанаас өмнө өгнө.

9 дүгээр зүйл. Векселийн төлбөрийг гүйцэтгэх

1. Вексель эзэмшигч төлбөрийн хугацаа боломж векселийг гардуулснаар төлбөр хариуцагч төлбөрийг хийнэ. Төлбөр хариуцагч төлбөрийг хугацаанаас нь өмнө гүйцэтгэж болно.

2. Төлбөр хариуцагч нь вексельд заасан төлбөрийг хугацаанд нь болон түүний дараагийн ажлын 2 өдрийн дотор багтаан хийж, энэ тухай вексельд тэмдэглэнэ.

3. Төлбөр хариуцагчийн дампуурлын хэрэг шүүхэд очсон, эсхүл түүний эд хөрөнгийг албадлагын журмаар барьцаалснаас бусад тохиолдолд вексель эзэмшигч хугацаанаас нь өмнө төлбөр гүйцэтгэхийг төлбөр хариуцагчаас шаардахыг хориглоно.

4. Вексель эзэмшигч төлбөрийг вексельд заасан төлбөрийн хугацаанд банкаар дамжуулан нэхэмжилж болно. Банк төлбөр гүйцэтгэсний /үйлчилгээ үзүүлдсний/ шимтгэлийг авч болно. Векселиэр төлбөр тооцоо гүйцэтгэх журмыг Сангийн яам, Монгол-банк тогтооно.

10 дугаар зүйл. Төлбөрөөс татгалзах

1. Дараахь тохиолдолд төлбөр хариуцагч вексельд заасан төлбөр төлөхөөс татгалзаж болно:

1/ энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан үндэслэлийн дагуу векселийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;

2/ вексель бичсэнээс хойш нэг жил өнгөрсний дараа вексель эзэмшигч төлбөр гүйцэтгэхийг мэдэгдэж шаардсан.

2. Төлбөр хариуцагч нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан үндэслэлээр төлбөр төлөхөөс татгалзсан бол энэ тухай баримт үйлдэж, вексельд заасан төлбөрийн хугацаа дуусахаас өмнө нотариатаар батлуулсан байна.

3. Төлбөрийн зөвшөөрөл өгөхөөс татгалзахтай холбогдон гарсан маргааныг Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.

11 дүгээр зүйл. Төлбөр гүйцэтгэх мөнгөний нэгж

1. Вексельд заасан төлбөрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгөөр гүйцэтгэнэ.

2. Вексельд заасан төлбөрийг гадаад валютгаар нэхэмжилсэн тохиолдолд уг төлбөрийг тухайн этгээдтэй харилцан тохиролцсон, чөлөөтэй хөрвөдөг гадаад валютгаар гүйцэтгэнэ.

12 дугаар зүйл. Төлбөрийн хугацаа

Вексельд заасан төлбөр гүйцэтгэх хугацааг дараахь байдлаар тодорхойлно:

1/ векселийг гардуулж төлбөр хийхийг шаардсан хугацаанд;

2/ векселийг гардуулснаас хойш тодорхой хугацаанд;

3/ вексельд томлосон өдөр;

4/ вексель бичсэнээс хойш тодорхой хугацаанд.

13 дугаар зүйл. Векслийн хүү

Вексельд заасан төлбөр нь сарын, эсхүл жилийн хүүтэй байж болно. Хүүгийн хэмжээг талууд харилцан тохиролцоно. Энэ тухай уг вексельд тэмдэглэсэн байна.

14 дүгээр зүйл. Төлбөр нэхэмжлэх

1. Вексельд заасан төлбөрийг төлбөрийн хугацаа дууссаны дараахь ажлын 2 хоногийн дотор хийгээгүй тохиолдолд вексель эзэмшигч нь төлбөр хариуцагч, түүний батлан даагчаас төлбөрийг үл мэргалдах журмаар гаргуулан авах эрхтэй. Энэ тохиолдолд төлбөр хархуцагчийн харилцах данс байгаа банк хүчин төгөлдөр векселийг үндэслэн төлбөр хариуцагчийн данснаас төлбөрийг гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

2. Вексельд заасан төлбөрийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан дагуу гаргуулан авч чадаагүй бол вексель эзэмшигчийн төлбөрөө шүүхэд нэхэмжлэх эрх үүснэ. Энэ тохиолдолд вексель эзэмшигч:

1/ вексельд заасан дагуу хийгдээгүй төлбөр, хэрвээ хүүтэй гэж тохиролцсон бол түүнд бодогдсон хүүгийн хэмжээ;

2/ вексельд заасан төлбөрийн хугацаа ээтрүүлсэн хоног тутамд Иргэний хуулийн 180 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан дагуу төгтөөсөн хэмжээний алданги;

3/ төлбөрийг хугацаанд нь гүйцэтгэсэн бол вексель эзэмшигчид орох байсан орлого;

4/ нэхэмжлэл гаргахтай холбогдсон зардлыг тус тус төлүүлэх талаар нэхэмжлэл гаргах эрхтэй.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нэхэмжлэлийг энгийн болон шилжих вексель бичигч, төлбөрийн зөлшөөрөө өгөгч, вексель шилжүүлэгч болон тэдний батлан даагчдад хамтад нь, эсхүл тус бүрт нь гаргаж болно.

4. Төлбөр хариуцагч нь төлбөрөөс татгалзах хууль зүйн үндэслэлтэй гэж үзвэл дор дурдсан хугацаанд шүүхэд нэхэмжлэл гаргана:

1/ төлбөрийн зөвшөөрөл өгөхөөс татгалзсан тохиолдолд төлбөр хийх хугацааны дотор;

2/ төлбөр төлөхөөс татгалзсан тохиолдолд төлбөр гүйцэтгэхийг шаардаж вексель гардуулснаас хойш 10 хоногийн дотор.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Векселийн батлан даалт, вексель эзэмшихийг бусдад шилжүүлэх

15 дугаар зүйл. Батлан даагч

1. Төлбөр хариуцагчаас вексeld завсан төлбөр гүйцэтгэхийг батлан дааж, хэрэв уг үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд төлбөр хариуцагчийн өмнөөс төлбөр хийх үүрэг авч байгаа гуравдагч этгээдийг батлан даагч /цаашид "батлан даагч" гэх/ гэнэ. Батлан даагч нь банк, аж ахуйн нэгж байна.

2. Батлан даагч нь Иргэний хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3. Банк батлан даалт гаргах тохиолдолд төлбөр хариуцагчтай дараахь зүйлийг тохиролцож болно:

1/ төлбөр хариуцагчийн нэр дээр төлбөрийн тусгай нэрийн данс нээж, түүний орлогоос вексeld завсантай тэнцэх мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх;

2/ төлбөрийг тогтоосон хугацаанд төлбөр хариуцагчийн харилцах данснаас үл мөргөлдөх журмаар төлүүлэх;

3/ хэрэв төлбөр гүйцэтгэх өдөр төлбөр хариуцагчийн харилцах дансанд шаардагдах хэмжээний мөнгө байхгүй бол банк төлбөр хариуцагчид зээл олгож уг төлбөрийг төлөх.

16 дугаар зүйл. Векселийг бусдад шилжүүлэх.

1. Вексель эзэмшигч нь төлбөр гүйцэтгэх хугацааны дотор векселийг харилцан тохиролцсоны үндсэн дээр дараахь тохиолдолд бусдад шилжүүлж болно:

1/ төлбөр гүйцэтгэх хугацаанаас өмнө вексель эзэмшигчид мөнгөн хөрөнгө шаардлагатай бол;

2/ вексель эзэмшигч өөрийн зээлдүүлэгч буюу бэлтгэн нийлүүлэгчид өртэй бол.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд векселийг мөнгөний захаар дамжуулан бусдад, эсхүл банкинд худалдаж болно.

3. Арилжааны банк өөрийн хөрөнгийн эх үүсвэрт багтаан векселийг хямдруулан худалдаж авахдаа вексельд заасан төлбөрийн хүүг вексель худалдаж байгаа этгээдтэй харилцан тохиролцоно. Харин тухайн арилжааны банкинд түр хугацааны мөнгөн хөрөнгө хэрэгцээтэй болсон үед векселийг төв банкинд дахин хямдруулах замаар худалдаж болно. Дахин хямдруулалтын хүүгийн хэмжээг Монголбанк тогтооно.

4. Вексель эзэмших эрхийг хэсэгчлэн бусдад шилжүүлэхийг хориглоно.

17 дугаар зүйл. Дамжуулах бичилт

1. Векселиэр гэрчлэгдсэн эрхийг бусдад шилжүүлэхдээ векселийн маягтын ар талд, эсхүл түүний салшгүй хэсэг болсон нэмэлт хуудсанд дамжуулах бичилт хийнэ. Дамжуулах бичилт нь дараахь бүрдүүлбэртэй байна:

1/ вексель шилжүүлэгчийн нэр, хаяг;

2/ вексель шилжүүлэгчийн харилцах данс байгаа банкны нэр, дансны дугаар;

3/ вексель шилжүүлэгчийн гарын үсэг, тамга;

4/ вексель шилжүүлсэн өн, сар, өдөр;

5/ вексель шинээр эзэмшигчийн нэр, хаяг, түүний харилцах данс байгаа банкны нэр, дансны дугаар.

2. Мэдүүдгийн вексельд дамжуулах бичилт хийхгүй.

3. Дамжуулах бичилт хийснээр вексель эзэмшигчийн эрх уг векселийг шинээр эзэмшигчид шилжинэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

18 дугаар зүйл. Вексельтэй холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэх

1. Төлбөр хариуцагч вексельд заасан төлбөрийн хугацаанд төлбөрөө гүйцэтгээгүйтэй холбогдон гарсан маргааныг шүүх зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

2. Нийлүүлсэн бараа, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр тооцоог векселиэр хийх, энэ харилцвэтай холбогдон гарсан маргааныг Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.

19 дүгээр зүйл. Хариуцлага

1. Векселийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд түүний гэм буруу, зөрчлийн шинж байдал учруулсан хохирлын хэмжээг харгалзан хууль тогтоомжинд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2. Төлбөр хариуцагчийн өмнөөс төлбөрийн зөвшөөрлийг хуурамчаар үйлдэж гарын үсэг зурсан, төлбөр хариуцагчийг төлөөлөх эрхгүй этгээд хууль бусаар төлөөлж гарын үсэг зурсан бол ийнхүү гарын үсэг зурсан этгээд векселиэд заасан төлбөртэй холбогдсон бүхий л үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

3. Векселийн тухай хууль тогтоомжийг дөрөхь байдлаар зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд шүүгч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/ векселийн бүрдүүдбөрийн бичилтийг дутуу хялж вексель гаргасан, эсхүл векселиэд заасан төлбөрийг хэсэгчилж төлөхийг зөвшөөрсөн бол 15000-25000 төгрөгөөр торгох;

2/ энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төлбөрөөс татгалзсан, эсхүл төлбөрийн зөвшөөрөл өгөх хугацаа хэтрүүлсэн бол 20000-25000 төгрөгөөр торгох;

3/ энэ хуулийн 16 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд векселийг бусдад шилжүүлсэн, эсхүл дамжуулах бичилтгүйгээр векселийг шилжүүлсэн бол 10000-25000 төгрөгөөр торгох.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчлийг гаргасан болон векселийн тухай хууль тогтоомж зөрчсөнөөс учирсан материалын хохирлыг гэм буруутай этгээдээр зохих хууль тогтоомжийн дагуу нэхэн төлүүлэхийг сонирхогч этгээд нэхэмжлэх эрхтэй.

20 дугаар зүйл. Векселийг хувилах

Шээрдлагатай тохиолдолд векселийг хувилах болно. Векселийн энэхүү хувилсан хувь нь төлбөрийн хүчин төгөлдөр баримт болохгүй бөгөөд зөвхөн вексель бичигдсэнийг гэрчилнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 2 ДАХЬ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хууль батлагдсантай холбогдуулан Захиргааны хариуцлагын тухай хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Харилцаа холбооны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад харилцаа холбооны сүлжээ байгуулах, ашиглах, хамгаалах, төр болон үйлчлэгч байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хууль тогтоомж

1. Харилцаа холбооны тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ "шугам" гэж мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах, хүлээн авах зорилгоор байгуулсан аливаа дамжуулагч орчин /утас, орон зай зэрэг/, тэдгээрийг хамгаалахад хэрэглэдэг тусгаарлагч, сувагчлал, багана, цамхаг болон бусад зүйлсийн цогцолбор;

2/ "сүлжээ" гэж хоёр буюу түүнээс дээш хэрэглэгчдийн хооронд мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах болон хүлээн авахад хэрэглэгдэх холбооны шугам, шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, тээвэрлэх, гэрдуулахад зориулагдсан техник хэрэгслийн иж бүрдэл;

3/ "ашиглалт" гэж харилцаа холбооны сүлжээний тогтвортой ажиллагааг хангахад чиглэгдсэн засвар, хэмжилт, тохируулга хийх үйл ажиллагаа;

4/ "үйлчилгээ, үйлчлэгч" гэж харилцаа холбооны сүлжээг ашиглан хэрэглэгчдийн хэрэгцээг хангах үйл ажиллагаа; харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ эрхэддэг аж ахуйн нэгж, байгууллага;

5/ "завглах цэг" гэж үйлчлэгчийн болон үйлчлэгч хэрэглэгчдийн шугам, сүлжээ хоорондоо харилцан холбогдох цэг;

6/ "шуудангийн илгээмж" гэж шуудангийн байгууллагын одрийн тэмдгийн дардсаар баталгаажсан бичиг захидал, илгээлт болон шуудангаар илгээж байгаа бусад зүйл;

7/ "шуудангийн хаяг" гэж хэрэглэгчдийн /иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын/ оршин суудаг газрын /аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, хот, тосгон, гудамж, талбайн нэр болон барилга, орон сууц, хөшөөны дугаарыг багтаасан/ байршлын нэр, үйлчлэгчийн дугаар зэргийг агуулсан мэдээлэл;

8/ "шуудангийн үнэт цаас" гэж шуудангийн марк, захидалын маркжуулсан дугтуй, ил захидалын маркжуулсан хуудас.

ХОЁРДУГААР ВҮЛЭГ

Харилцаа, холбооны ашиглалт, үйлчилгээ,
үйлдвэрлэлийг төрөөс зохицуулах

4 дүгээр зүйл. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх, хөрөнгө оруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

2/ харилцаа холбооны салбарт шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

3/ радио долгионы зурвасыг төлөвлөх, долгион ашиглах эрхийн зөвшөөрөл олгож хяналт тавих;

4/ харилцаа холбооны сүлжээ, тоног төхөөрөмж, үйлчилгээний стандартыг боловсруулж батлуулах, ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хэрэгжилтэд хяналт тавих;

5/ шуудангийн өдрийн тэмдгийн дараас болон богцны лавны тэмдгийг баталгаажуулах;

6/ шуудангийн үнэт цаасыг үйлдвэрлэх, борлуулах бодлогыг боловсруулах, улсын фонд байгуулах;

7/ харилцаа холбооны үйлчилгээг найдвартай, шуурхай, чанартай байлгах, захидал харилцааны шууцны хамгаалалтанд хяналт тавих.

5 дугаар зүйл. Зохицуулах зөвлөл

1. Харилцаа холбооны салбарт өмчийн бүх төрөл, хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын үр ашигтай, шударга өрсөлдөх боломж бүрдүүлэх, тэдгээрийн харилцан ажиллах нөхцөл, болзол, журмыг боловсруулах, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэгтэй орон тооны бус зохицуулах зөвлөл ажиллана.

2. Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн нь харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхэлдэг өмчийн бүх төрөл, хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөлтэй байна.

3. Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн сайд томилж, дүрмийг Засгийн газар батална.

6 дугаар зүйл. Зохицуулах зөвлөлийн бүрэн эрх. Зохицуулах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх төрийн бодлогын талаар саналаа боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;

2/ төрийн захиргааны төв байгууллагаас харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход санал, зөвлөмж гаргах;

3/ харилцаа холбооны суурь сүлжээнд холбогдох өмчийн бүх төрөл, хэлбэрийн сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулахад тавих техникийн нөхцөл, шаардлагыг тогтоох;

4/ хоорондоо холбогдох сүлжээ бүхий үйлчлэгчдийн харилцан холболт хийх болон орлого хуваарилах зарчим, гэрээний ерөнхий нөхцөл, журмыг тогтоож зохицуулах;

5/ харилцаа холбооны үйлчилгээний тарифыг тодорхойлох үнэлгээний аргачлаал тогтоох.

7 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын бүрэн эрх

1. Бүх шатны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэрийн холбооны үйлчилгээг сайжруулж, хүн амд ойртуулах бодлогыг боловсруулж холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

2/ тухайн нутаг дэвсгэрт шуудан хүргэх хуваарийг хангаж зохицуулах;

3/ харилцаа холбооны шуурхай байдлыг хангах зорилгоор аймаг, нийслэл, дүүрэг, сум, хороо, хот, тосгоны гудамж, талбай, барилга, орон сууц, хашааг хаягжуулах арга хэмжээ авах;

4/ байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас харилцаа холбооны сүлжээнд гарсан ослыг арилгах ажлыг зохион байгуулахад туслах.

2. Радио телевизийн орон нутгийн сүлжээ байгуулж ашиглаж болно.

8 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл

1. Харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг, /даашид "тусгай зөвшөөрөл" гэх/ дараахь тохиолдолд олгоно:

1/ харилцаа холбооны суурь сүлжээг байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх;

2/ дотоодын хэрэглээний сүлжээгээр нийтийн үйлчилгээ эрхлэх;

3/ радио долгион ашиглах;

4/ холбоо, мэдээллийн техник, электрон хэрэгсэл үйлдвэрлэх;

5/ шуудангийн үнэт цаас үйлдвэрлэх.

2. Тусгай зөвшөөрлийг хууль тогтоомжид заасан шаардлага хангасан дараахь этгээдэд олгоно:

1/ Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн;

2/ Монгол улсын хуулийн дагуу байгуулагдсан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж.

3. Гадаадын хуулийн этгээдэд харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын зөвшөөрлийг үндэслэн олгоно.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад төрлийн харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх бол аж ахуйн нэгж, байгууллага иргэн энэ тухайгаа харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүнээс эрх олгогдсон байгууллагад мэдэгдэж бүртгүүлдэг.

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөл гаргах

1. Тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлийг сонирхогч этгээд төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

2. Тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөлд дараахь бичиг баримтыг хавсаргана:

1/ санхүү-эдийн засаг, техникийн болон мэргэжлийн боловсон хүчний чадавхи;

2/ үйл ажиллагааны үндсэн чиглэл, туршлага;

3/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар:

а/ үйлчилгээний хамрах хүрээ, байршил;

б/ нэвтрүүлэх технологи;

в/ үйлчилгээний тарифын санал;

г/ тусгай зөвшөөрлийн үнийн санал.

10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа

1. Тусгай зөвшөөрлийн хугацааг 20 хүртэл жилээр олгоно.

2. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах эсэх асуудлыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

11 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болох үндэслэл

1. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь эзэмшигчээс түүний хугацааг сунгуулах тухай өргөдөл гаргаагүй бол анх товлосон он, сар, өдрийн /огнооны/ дараагийн ажлын өдөр болмогц дуусгавар болно.

2. Дараахь тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг товлосноос өмнө дуусгавар болсонд тооцно:

1/ тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан;
2/ тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаагаа эхлээгүй;

3/ тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлдээгүйгээс эрх бүхий байгууллага уул зөвшөөрлийг дангаар буюу эзэмшигчийн хүсэлтээр цуцалсан.

3. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон нөхцөлд уг зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллага энэ тухай бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг цуцлах

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь зөрчил гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллага нь уг зөвшөөрлийг дангаараа цуцлах эрхтэй:

1/ харилцаа холбооны сүлжээ байгуулах, ашиглах, хамгаалах талаар хууль болон гэрээнд заасан үүргээ биелүүлдээгүй;

2/ тусгай зөвшөөрөлд зааснаас өөр төрлийн үйл ажиллагаа явуулсан.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн бол түүний хүсэлтээр уг зөвшөөрлийг хугацаанаас өмнө цуцалж болно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг цуцалснаас учирсан хохирлыг уг зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллага хариуцахгүй.

4. Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай эрх бүхий байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

13 дугаар зүйл. Харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт

1. Харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хууль тогтоомж, техник технологийн горимыг холбогдох этгээд хэрхэн биелүүлж байгаад харилцаа холбооны улсын хяналтын алба, түүний улсын байцаагч мэргэжлийн хяналт талъж, шалгалт хийнэ.

2. Харилцаа холбооны улсын хяналтын алба, түүний улсын байцаагчид нь төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасан эрх хэмжээнээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлдэг:

1/ харилцаа холбооны тухай хууль тогтоомжийн биелэлт, тусгай зөвшөөрөл олголт, түүний хэрэгжилтийг хянан шалгах;

2/ харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлд зайлшгүй мөрдөөл зохих технологийн горим, тогтоосон стандарт, техникийн нөхцөл болон энэ хуульд заасан бусад шаардлагыг хэрхэн биелүүлж байгааг шалгах;

3/ тусгай зөвшөөрөлгүйгээр харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхэлсэн, бүртгэлгүйгээр радио долгион ашигласан тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох арга хэмжээ авах.

ГҮРЭВДУГААР БҮЛЭГ

Харилцаа холбооны сүлжээ

14 дүгээр зүйл. Харилцаа холбооны сүлжээний төрөл

Харилцаа холбоо нь цахилгаан холбоо, шуудан, радио, телевизийн болон бусад мэдээллийн сүлжээнээс бүрдэх бөгөөд тэдгээр нь зориулалтаараа нийтийн үйлчилгээний болон дотоодын, тусгай хэрэглээний сүлжээ гэсэн төрөлтэй байна.

15 дугаар зүйл. Цахилгаан холбооны сүлжээ.

1. Хэрэглэгчдийн хооронд аялган тэмдэг, дохио, бичиг, дуу, дүрс зэрэг бүх төрлийн мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах болон хүлээн авахад зориулагдсан шугам, тоног төхөөрөмж, техник хэрэгслээс цахилгаан холбооны сүлжээ бүрдэнэ.

2. Улс хооронд болон аймаг, нийслэл, сум, баг хоорондын дамжуулах, хүлээн авах, холбох тоног төхөөрөмжөөс бүрдэнэ, улсын бүх нутаг дэвсгэрийг хамран зохион байгуулагдсан, нийтийн үйлчилгээнд зориулагдсан сүлжээг цахилгаан холбооны суурь сүлжээ гэнэ.

3. Цахилгаан холбооны суурь сүлжээг техник, технологийн нэгдсэн удирдлагатай, тасралтгүй ажиллагаатай байлаар зохион байгуулна.

16 дугаар зүйл. Шуудангийн сүлжээ

1. Шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, тээвэрлэх, гардуулахад зориулагдсан тоног төхөөрөмж, техник хэрэгслээс шуудангийн сүлжээ бүрдэнэ.

2. Улс хооронд болон улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамран шуудан солилцох боломжтой сүлжээг шуудангийн суурь сүлжээ гэнэ.

3. Шуудангийн суурь сүлжээний үйл ажиллагааг төрөөс зохицуулна.

4. Шуудан солилцох, хүргэх ажиллагааг дор дурдсан эрх бүхий байгууллага, албан тушаалтны батлагдсан хуваарь чиглэлийн дагуу зохион байгуулна:

1/ улс хоорондын шуудан солилцох, хүргэх үйл ажиллагааг хоёр талын харилцаа холбооны эрх бүхий байгууллагын гэрээ хэлэлцээрээр;

2/ аймаг, нийслэл, сумын төв, хотуудын хоорондох шуудан хүргэлтийг уг асуудал эрхэлсэн сайдын баталснаар;

3/ нийслэл, дүүрэг, сум, баг болон хот, тосгоны доторхи шуудан хүргэлтийг холбогдох Засаг даргын баталснаар.

5. Зорчигч тээвэр эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь шуудан холбооны байгууллагатай хийсэн гэрээний үндсэн дээр аймаг, нийслэл, сум, хот, баг хооронд шуудан тээвэрлэнэ.

17 дугаар зүйл. Радио, телевизийн нэвтрүүлгийн сүлжээ

1. Радио болон телевизийн хөтөлбөрийг нэвтрүүлэх, хүлээн авах, дамжуулах тоног төхөөрөмж, техник хэрэгслээс радио, телевизийн нэвтрүүлгийн сүлжээ бүрдэнэ.

2. Орон даяар хэрэглэгчдэд радио, телевизийн хөтөлбөрийг хүргэж байгаа тоног төхөөрөмж шугамын иж бүрдэл нь радио, телевизийн нэвтрүүлгийн суурь сүлжээ мөн.

3. Монгол улсын радио, телевизийн нэвтрүүлгийн сүлжээг радио телевизийн нэвтрүүлгийн хөтөлбөр бэлтгэх байгууллагын захиалга, хуваарийн дагуу ажиллуулна.

18 дугаар зүйл. Тусгай хэрэглээний холбооны сүлжээ

1. Монгол улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, иргэний хамгаалалт, нийгмийн хэв журам сахуулах, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хэрэгцээнд зориулан тусгай хэрэглээний холбооны сүлжээг байгуулан ажиллуулж болно.

2. Тусгай хэрэглээний холбооны сүлжээ төрийн хамгаалалтад байна.

3. Тусгай хэрэглээний холбооны сүлжээг байгуулах, ашиглах журмыг Засгийн газар батална.

4. Тусгай хэрэглээний холбооны хэрэгцээнд шаардлагатай цахилгаан холбооны суурь сүлжээний суваг, тоног төхөөрөмжийг гэрээний үндсэн дээр төлбөртэй хэрэглүүнэ.

5. Тусгай хэрэглээний холбооны мэдээллийг харилцаа холбооны суурь сүлжээгээр дамжуулахын өмнө нууцлах, хамгаалах арга хэмжээг мэдээлэл дамжуулагч байгууллага хариуцна.

19 дүгээр зүйл. Дотоодын хэрэглээний холбооны сүлжээ

1. Аж ахуйн нэгж, байгууллага нь дотооддоо технологийн удирдлага болон зохицуулалтыг шуурхай хангахад зориулагдсан дотоодын хэрэглээний холбооны сүлжээ байгуулан ажиллуулж болно.

2. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр дотоодын хэрэглээний холбооны сүлжээг цахилгаан холбооны суурь сүлжээнд холбож үйлчилгээ явуулж болно.

20 дугаар зүйл. Цахилгаан холбооны суурь сүлжээнд
холболт хийх

Дотоодын болон тусгай хэрэглээний цахилгаан холбооны сүлжээг цахилгаан холбооны суурь сүлжээнд холбох зааглах цэг хүртэл болон зааглах цэгт тавигдах нэмэгдэл шугам, тоног төхөөрөмжийг нийлүүлэх, санхүүжүүлэх асуудлыг дотоодын болон тусгай хэрэглээний холбооны сүлжээ эзэмшигч хариуцна. Зааглах цэгийн байршлыг Зохицуулах зөвлөл тогтооно.

21 дүгээр зүйл. Холбооны сүлжээг дайчлан ажиллуулах Монгол улсад онц болон дайны байдал зарласан тохиолдолд харилцаа холбооны сүлжээг хууль тогтоомжид зааснаар дайчлан ажиллуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтийн үйлчилгээний үйлчлэгч, хэрэглэгчийн
эрх, үүрэг

22 дугаар зүйл. Үйлчлэгч, хэрэглэгчийн харилцан хүлээх
үүрэг, хариуцлага

Үйлчлэгч, хэрэглэгчийн харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг Иргэний хуульд заасны дагуу гэрээгээр тогтооно.

23 дугаар зүйл. Үйлчлэгчийн эрх, үүрэг

1. Үйлчлэгч нь гэрээнд заасан эрхээс гадна дараахь эрхтэй:
1/ харилцаа холбооны үйлчилгээний тарифыг Зохицуулах зөвлөдөөс гаргасан үнэлгээний аргачлалын дагуу тогтоох;

2/ хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлдээгүй бол үйлчилгээг зогсоож гэрээг цуцлах;

2. Үйлчлэгч нь гэрээнд заасан үүргээс гадна дараахь үүрэгтэй:

1/ харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрлийн хүрээнд хэрэглэгчдэд ямар нэгэн илгаваргүйгээр найдвартай шуурхай үйлчлэх;

2/ харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн стандарт, техник, технологийн нөхцөл, горимыг дагаж мөрдөх;

3/ харилцаа холбооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, өргөтгөх, үйлчилгээний зориулалтыг өөрчлөх, түр зогсоох тухай хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдэх;

4/ харилцаа холбооны сүлжээгээр дамжиж байгаа бүх төрлийн мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах;

5/ байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед холбооны сүлжээг хууль тогтоомжийн дагуу бусдад саадгүй хэрэглүүдэх;

6/ байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсоноос бусад үед холбооны үйлчилгээг зогсоохгүй байх.

3. Үйлчлэгч байгууллагын ажиллагсад нь төрийн хамгаалалттай аж ахуйн нэгж, байгууллагад байгаа өөрийн мэдлийн холбооны шугам, сүлжээнд засвар, үйлчилгээ хийх үедээ холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч ажиллана.

4. Хүлээлгэн өгөх, буцаан хүргүүлэх тодорхой хаяггүй шуудангийн илгээмжийг үйлчлэгч хүлээн авснаас хойш 6 сар хадгалсаны дараа комисс төмнлж задлаад акт үйлдэнэ.

5. Задалсан илгээмжээс тодорхой хаяг гарвал уг хаягийн дагуу хүргэх ажлыг зохион байгуулна.

6. Задалсан илгээмжээс гарсан үндэсний болон гадвадын валют, үнэ бүхий зүйлийг улсын орлогод, иргэний бичиг баримтыг иргэний бүртгэл мэдээллийн байгууллагад тус тус шилжүүлнэ.

7. Тодорхой хаяггүй шуудангийн илгээмжийн эзэн тогтоогдсон нөхцөлд улсын орлого болгосон зүйлийг эргүүлэн өгөх буюу эргүүлэн өгөх боломжгүй бол хохирлыг нөхөн төлнө.

8. Тодорхой хаяггүй шуудангийн илгээмжийг хадгалах, задлах журмыг төрийн захиргаан төв байгууллага тогтооно.

24 дүгээр зүйл. Хэрэглэгчийн эрх, үүрэг

1. Хэрэглэгч гэрээнд заасан эрхээс гадна дараахь эрхтэй:

1/ харилцаа холбооны стандарт, техникийн нөхцөлийг хангасан тоног төхөөрөмж /телефон, телекс, факсимиль болон радиогийн аппарат, тэдгээрийн нэмэгдэл бусад хэрэгсэл/-ийг сонгон авч хэрэглэх;

2/ харилцаа холбооны сүлжээнд гарсан гэмтлийг зохих хугацаанд нь засварлахыг шаардах, энэ талаар мэдээлэл авах;

3/ байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсоноос өөр шалтгаанаар үйлчилгээгээ зогсоосон буюу тоног төхөөрөмжөө ажиллуулаагүй, шуудангийн илгээмжийг үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу хохирлыг нөхөн төлүүлэх.

4/ аж ахуйн нэгж, байгууллага, иргэн шуудан холбооны цэг салбарт хайрцгаар үйлчлүүлэх.

2. Хэрэглэгч гэрээнд заасан үүргээс гадна дараахь үүрэгтэй:

1/ өөрийн эзэмшлийн барилга, байгууламж, нутаг дэвсгэрт байрлуулсан харилцаа холбооны сүлжээ, тоног төхөөрөмжийг хамгаалах, түүнд гарсан болон гарч болох осол, зөрчлийн талаар үйлчлэгчид мэдээлэх;

2/ хэрэглэгч нь харилцаа холбооны үйлчилгээний үнэ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх;

3/ 9кГц-ээс дээших долгион үүсгэдэг тоног төхөөрөмжийг суурилуулж, ашиглахдаа харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авах, бүртгүүлэх, бусдын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүй байх.

ТАВДУГААР БҮЛЭГ

Харилцаа холбооны сүлжээг хамгаалах

25 дугаар зүйл. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг үүрэг

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь нийтлэг үүрэгтэй:

1/ инженерийн шугам, сүлжээний хайгуул хийх, барилга байгууламж, шугам, сүлжээ байгуулахдаа харилцаа холбооны шугам, сүлжээг эзэмшигчээс зохих зөвшөөрөл авах, түүнийг шилжүүлэх шаардлагатай бол уг ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх;

2/ орон сууц, барилга байгууламжийн зураг төсөвт холбооны хэрэгцээг зохих нормын дагуу хангах ажлыг заавал тусгаж гүйцэтгүүлэх;

3/ аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь шуудангийн байгууллагаас хаяг, индекс авч өөрчлөгдсөн тухай бүр тодотгол хийлгэж байх;

4/ тэсэрч дэлбэрэх /буу зэвсэг, дарь, сум зэрэг/, шатах /бензин шатахуун, спирт, хүчил, шүлт зэрэг/ бодис, гаалийн байгууллагаас хориглосон зүйлсийг шуудангаар илгээхгүй байх.

26 дугаар зүйл. Зурвас газар

1. Монгол улсын газрын нэгдмэл сангаас холбооны сүлжээнд зориулан олгосон газар, орон зайг холбооны зурвас газар гэнэ. Зурвас газар нь дараахь хэмжээтэй байна:

1/ агаарын баганат шугамын тал бүрээс 10 метр;

2/ кабелийн шугамын тал бүрээс 5 метр;

3/ радио релейн шугамын станц хоорондын буюу сансрын холбооны хиймэл дагуул, газрын станц хоорондын долгионы шууд тусгалын орон зай тухайн станцын тал бүрээс 300 метр голчтой;

4/ радио, телевизийн нэвтрүүлэх станцын тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамааруулан тогтоосон эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ.

Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан зурвас газрын хэмжээг хот, тосгоны дотор өөрөөр тогтоож болно.

2. Харилцаа холбооны шугам сүлжээгээр ашиглаат, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл авсан үйлчлэгч байгууллага нь уг шугам сүлжээний зурвас газрыг хууль тогтоомжийн дагуу эзэмшинэ.

3. Холбооны сүлжээ байрлаж байгаа зурвас газартай холбогдсон асуудлыг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага тус тусын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэж байна.

27 дугаар зүйл. Зурвас газрыг хамгаалах

1. Харилцаа холбооны зурвас газар үйлчлэгчийн эзэмшилд байна.

2. Харилцаа холбооны зурвас газар болохыг тодорхойлсон тэмдгийг шугамын чиглэлд тавина.

3. Харилцаа холбооны зурвас газарт дараахь ажил хийхийг хориглоно:

1/ барилга, гэр, хашаа барих, мод тарих;

2/ кабель гэмтээж болох зүйл хаях, химийн идэмхий бодис осгах;

3/ зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр ачаатай тээврийн хэрэгсдээр агаарын баганат шугамыг хондлон гарах.

4. Зурвас газарт ажил гүйцэтгэгч нь үйлчлэгчээс урьдчилан зөвшөөрөл авсан байна. Харилцаа холбооны зурвас газарт ажил гүйцэтгэсэн этгээд хондөгдсөн орчныг нөхөн сэргээх, тасан тохижуулах арга хэмжээг өөрийн зардлаар бүрэн хэрэгжүүлэх үүрэгтэй.

28 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх харауцлага

1. Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн харауцлага хүлээлгэхээргүй бол харилцаа холбооны улсын байцаагч дараахь захиргааны шийтгэл оногдуулна:

1/ нийтийн эзэмшлийн газарт тавигдсан харилцаа холбооны тоног төхөөрөмжийг эвдсэн, гэмтээсэн бол гэм буруутай этгээдийг 5000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 30000-150000 төгрөгөөр торгох;

2/ барилга байгууламж, инженерийн шугам, сүлжээний хайгуул хийх, зураг төсөл зохиох, барилга байгууламж, шугам сүлжээ байгуулахдаа тэдгээрийн талбайд орсон харилцаа холбооны шугам, сүлжээг зохих зөвшөөрөлгүйгээр тасалсан, зөөсөн үүний улмаас тухайн шугам сүлжээ /холбооны кабель, агаарын баганат шугам, хэрэглэгчийн кабелийн хайрцаг, шүүгээ, оруулгын утас, трансформатор, сувагчлал, шуудангийн хайрцаг зэрэг/-г гэмтээсэн, ашиглалтгүй болгосон бол гэм буруутай этгээдийг 5000-35000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгох;

3/ Харилцаа холбооны шугам, сүлжээний дагуу тавигдсан аливаа тэмдэг, шон, хамгаалах хэрэгсэл зэргийг унагасан, эвдэж устгасан, тэдгээрийн бичээсийг арилгасан, кабелийн шүүгээ, худаг, сувагчлал, шуудангийн хайрцагт хог хаясан, бусад зүйлээр бохирдуулсан бол гэм буруутай этгээдийг 3000-10000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 30000-150000 төгрөгөөр торгох;

4/ тусгай зөвшөөрөл бүртгэлгүйгээр радио долгион үүсгэх тоног төхөөрөмжийг ажиллуулсан, үйлдвэрлэсэн, холбооны сүлжээнд холболт хийж түүгээр дамжуулж байгаа мэдээллийг авсан, харилцаа холбооны ашиглалт, үйлчлэгээ эрхэлсэн бол гэм буруутай этгээдийг 5000-35000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгох;

5/ Энэ хуулийн 27 дугаар зүйлийн 3, 4 дэх заалтыг зөрчсөн бол гэм буруутай этгээдийг 2000-35000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгох;

6/ шуудангаар илгээхийг хориглосон буюу зөвшөөрсөн хэмжээ-нээс илүү тооны эд хөрөнгийг илгээсэн, түүнийг хүлээн авч ивуулсан, шуудан хүргэх хувиарийг тасалсан, шуудангийн ил-гээмжийг алдаж үрэгдүүлсэн, гэмтээсэн, задалсан бол гэм буруутай этгээдийг 1000-35000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгох;

7/ энэ хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтыг зөрчсөн бол гэм буруутай этгээдийг 5000-35000 төг-рөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгох;

8/ энэ хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3 дахь заалтыг зөрчсөн бол гэм буруутай этгээдийг 2000-25000 төг-рөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 30000-200000 төгрөгөөр торгох.

29 дүгээр зүйл. Хохирол нөхөн төлүүлэх

Харилцаа холбооны тухай хууль тогтоомж зөрчиж бусдад учруулсан хохирлыг хууль тогтоомжид заасны дагуу гэм буруу-тай этгээдээр нөхөн төлүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны II дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

Женевийн Конвенцийн нэмэлт Протоколуудыг соёрхон батлах тухай

Нэгдүгээр зүйл. "Дайнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай" 1949 оны Женевийн Конвенцуудын нэмэлт баримт бичиг болох 1977 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Женев хотноо байгуулж, гарын үсэг зурсан "Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалахтай холбогдолтой нэмэлт нэгдүгээр Протокол" болон "Олон улсын бус чанартай зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай нэмэлт хоёрдугаар Протокол"-ыг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Хоёрдугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь заалтыг иш үндэс болгон "Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалахтай холбогдолтой нэмэлт нэгдүгээр Протокол"-ын 85 дугаар зүйлийн 2 дахь заалтын талаар Монгол Улс зохих тайлбар хийх нь зүйтэй гэж үзсүгэй.

Гуравдугаар зүйл. "Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалахтай холбогдолтой нэмэлт нэгдүгээр Протокол"-ын 90 дүгээр зүйлд звасан "Хэрэг явдлыг тогтоох олон улсын комисс"-ын эрх хэмжээг Монгол Улс хүлээн зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАВАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны II дүгээр
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН 1996 ОНЫ УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1996 оны улсын төвлөрсөн төсвийн орлогын нийт

дүн, нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай:

/мянган төгрөгөөр/

Улсын төвлөрсөн төсвийн орлого-бүгд	116542572,4
1. Албан татварын орлого	87923591,1
1/орлогын албан татвар	30494092,4
2/гавлийн албан татвар	11182800,0
3/худалдааны албан татвар	13908416,1
4/онцгой албан татвар	7930248,0
5/авто бензин, дизелийн түлшний албан татвар	4099100,0
6/бусад албан татвар	572445,0
7/нийгмийн даатгалын шимтгэл	19736489,6
2. Татварын бус орлого	22118981,3
1/хувьцааны ногдол ашиг	7986343,5
2/бусад орлого	2956000,0
3/төсөвт байгууллагын өөрийн орлого	4176637,8
4/гадаад тусламжийн орлого	7000000,0
3. Хөрөнгийн орлого	6500000,0
1/өмч хувьчлалын сангийн орлого	6500000,0

2 дугаар зүйл. 1996 оны улсын төвлөрсөн төсвийн зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт, нийтийн ерөнхий үйлчилгээний зардал, батлан хамгаалах арга хэмжээний зардал, төвлөрүүлэн захирагчийн санхүүжилт, тэтгэврийн даатгалын сан боловч аймгийн төсөвт өгөх татаасмын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

(мянган төгрөгөөр)

Улсын төвлөрсөн төсвийн зарлага-бүгд	131395739,8
1/цалингийн сан	12421738,5
2/хөрөнгө оруулалт	17407100,0
Үүнээс шинээр эхлэх барилга объектын нийт төсөвт орлог	14960000,0
Үүний дотор 1996 онд санхүүжүүлэх хэмжээ	4040000,0
3/нийтийн ерөнхий үйлчилгээний зардал	6095553,6
4/батлан хамгаалах арга хэмжээний зардал	11662491,0
5/Монгол Улсын Ерөнхийлөгч,	

Ерөнхийлөгчийн Тамгын газрын төсөв	67265,0
6/Монгол Улсын Их Хурлын төсөв	678406,6
7/Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн төсөв	10421,0
8/Шүүхийн төсөв	589537,0
9/Прокурорын төсөв	337690,0
10/Татгуулын төв газрын төсөв	768457,0
11/тэтгэврийн давтгалын санд өгөх татаас	11561000,0
12/аймгийн төсөвт өгөх татаас	16970177,4

3 дугаар зүйл. Улсын төвлөрсөн төсвөөс аймагийн төсөвт өгөх т
вэсн хэмжээг дор дурдсанаар хуваарилан тогтоосугай:

Архангай	1361405,6
Баян-Өлгий	1066266,3
Баянхонгор	1181985,5
Булган	281101,5
Говь-Алтай	1198875,9
Дорноговь	859746,7
Дорнод	674481,8
Дундговь	810401,0
Завхан	1454430,0
Өвөрхангай	796767,0
Өмнөговь	864981,5
Сүхбаатар	1138458,8
Сэлэнгэ	127728,5
Төв	115366,1
Увс	1129338,6
Ховд	1102174,7
Хөвсгөл	1603607,7
Хэнтий	1080385,0
Говь-Сүмбэр	132674,7

Монгол Улсын Их Хуралн дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 74

Улаанбаатар
хот

**Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай
хууль батлагдсантай холбогдуулан авах
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль батлагдсантай холбогдуулан танхим бүртгэх, татан буулгахад дараахь журмыг мөрдлөг болгосугай.

1/Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг үндэсний танхим болгон өөрчлөн зохион байгуулах;

2/энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдаж бүртгэгдсэн бусад танхим нь өөрийн дүрэмдээ хуульд нийцүүлэн зохих нэмэлт, өөрчлөлт оруулж, 1996 оны 5 дугаар сарын 1-ний дотор улсын бүртгэлд бүртгүүлэх;

3/энэ тогтоолын 1 дэх хэсгийн 2-т заасан хугацааны дотор улсын бүртгэлд бүртгүүлээгүй танхимыг бүртгэх байгууллаага татан буулгаж, улсын бүртгэлээс хасна.

2. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд Засгийн газрын болон нам, тусгай газрын холбогдох шийдвэрийг нийцүүлэхийг Засгийн газарт даалгасугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1995 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар
хот

**Гадаад худалдааны арбитрын тухай
хууль батлагдсантай холбогдуулан
авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Гадаад худалдааны арбитрын тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) Гадаад худалдааны арбитрын тухай хуульд Засгийн газрын болон яам, тусгай газрын холбогдох шийдвэрийг нийцүүлэх;

2) Гадаад худалдааны арбитрын тухай хууль батлагдсантай холбогдуулан олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох асуудлыг судлан шийдвэрлүүлэх.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны II дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 76

Улаанбаатар
хот

Л. Ганбаатарыг төрийн хянан шалгах
хорооны гишүүнээр томилж тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Лигүүгийн Ганбаатарыг Төрийн хянан шалгах хорооны гишүүнээр томилсугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны II дүгээр
сарын 17-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн байгууллага болон төрийн захиргааны албан хаагч, түүнд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журмыг хавсралтын ёсоор баталсугай.

Дарга

Н. БАГАВАНДИ

УИХ-ын 77 дугаар тогтоолын
хавсралт

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
АЛБАН ХААГЧ, ТҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ХООРОНД
ТӨРИЙН АЛБАТАЙ ХОЛБОГДСОН АСУУДЛААР
ГАРСАН МАРГААНЫГ ХҮЛЭЭН АВЧ, ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн байгууллага болон төрийн захиргааны албан хаагч, түүнд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг Төрийн захиргааны албаны зөвлөл болон түүний салбар зөвлөлөөр хянан шийдвэрлэхэд энэхүү журмыг баримталаг.

2. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу Төрийн захиргааны албаны зөвлөл болон салбар зөвлөл нь төрийн захиргааны албан хаагчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг энэ журмаар тогтоосон харьяаллаар хянан шийдвэрлэнэ.

3. Төрийн захиргааны албаны зөвлөл нь төрийн захиргааны албан хаагчийн эрх зөрчигдсөн тухай дараахь маргааныг хянан шийдвэрлэнэ:

1/Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн албаны мэргэшлийн шалгалттай холбогдсон асуудлаар мэргэшлийн шалгалтын төв комисстой холбогдож гарсан маргаан;

2/Төрийн захиргааны тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг өлгөх асуудаатай холбогдож гарсан маргаан;

3/төрийн захиргааны салбар зөвлөлийн шийдвэртэй холбогдож гарсан маргаан;

4/ төрийн захиргааны албаны салбар зөвлөл байгуулагдаагүй төрийн байгууллагуудын захиргааны албан хаагчдаас гаргасан маргаан.

4. Төрийн захиргааны албаны салбар зөвлөл нь төрийн захиргааны албан хаагчийн эрх зөрчигдсөн тухай дараахь маргааныг хянан шийдвэрлэнэ:

1/ төрийн албаны мэргэшлийн шалгалтын талаар энэ журмын 3 дугаар зүйлийн 1-д зааснаас бусад байгууллага, албан тушаалтантай холбогдож гарсан маргаан;

2/ Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, зохих шатны сургалтад хамруулах, зэрэг дэв олгох, цалин хөлсийг өөрчлөх, албан тушаал бууруулах зэрэг асуудлаар гарсан шийдвэртэй холбогдсон маргаан;

3/ мөн хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу төрийн захиргааны албан хаагчийг захиргааны санаачилгаар албан тушаалаас бууруулсан, төрийн албанаас уг албанд эргэж орох эрхтэйгээр халсан, түр чөлөөлсөнтэй холбогдож гарсан маргаан;

4/ мөн хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсантай холбогдож гарсан маргаан;

5/ төрийн захиргааны албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнаал урамшил зэрэг асуудалтай холбогдож гарсан бусад маргаан;

5. Дор дурдсан этгээдийн гомдлоор төрийн албатай холбогдсон маргааныг үүсгэж болно:

1/ төрийн захиргааны албан хаагч

2/ Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу төрийн албаны мэргэшлийн шалгалтад орох эрх бүхий иргэн болон уг шалгалтад тэнцсэн иргэн.

Хоёр. Гомдлыг хүлээн авах, шалгах

6. Энэхүү журмын 5 дугаар зүйлд дурдсан этгээд нь төрийн албатай холбогдсон асуудлаар гаргасан гомдлоо журмын 3, 4 дүгээр зүйлд заасан харьяалма дагуу төрийн захиргааны албаны зөвлөлийн эсхүл салбар зөвлөлийн нэр дээр бичгээр ирүүлднэ.

Гомдолд маргаан үүсэх болсон үндэслэл, шалтгааныг тодорхой дурдаж өөрийнхөө тавьж буй шаардлагын талаархи нотолгоо, бусад бичиг баримтын хуулбарыг хавсаргаж болно.

7. Гомдлыг хүлээж авсан төрийн захиргааны албаны холбогдох зөвлөлийн удирдлага түүнийг шийдвэрлэх эрх зүйн үндэслэлтэй гэж үзвэл гомдлыг хянан шалгах комиссыг эрх бүхий албан тушаалтнаар удирдуулан ажлын 3 өдрийн дотор холбогдох зөвлөлийн даргын захирамжаар томилно.

8. Төрийн захиргааны албаны холбогдох зөвлөлийн удирдлага маргааны шинж байдлыг харгалзан гомдлыг хянан шалгаж эрх бүхий комисс /цаашид энэ журамд "комисс" гэх/-ыг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж даргыг нь томилон ажиллуулах бөгөөд гомдлыг хянан шалгах ажлыг комиссын дарга хариуцан зохион байгуулна.

9. Комиссын бүрэлдэхүүнд төрийн захиргааны албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн ажилтнууд, түүнчлэн төрийн захиргааны бусад байгууллагаас төрийн захиргааны албаны ажлын дадлага, туршлагатай мэргэшсэн албан хаагчийг оролцуулж болно. Харин комиссын бүрэлдэхүүнд гомдол гаргагчийн маргаанд холбогдох ажилтан болон гомдол гаргагчийн төрөл садангийн этгээдийг оруулахыг хориглоно.

10. Гомдол гаргагч нь маргаан шалгах комиссын бүрэлдэхүүнийг татгалзах эрхтэй бөгөөд энэ тухай тодорхой үндэслэл бүхий хүсэлтийг бичгээр гаргаж төрийн захиргааны албаны холбогдох зөвлөлийн удирдлагад өгнө. Хүсэлттэй холбогдсон асуудлыг зөвлөлийн даргын захирамжаар зохицуулна.

11. Комисс нь гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шалгалтыг явуулж дуусгах бөгөөд шаардлагатай бол холбогдох зөвлөлийн даргын захирамжаар хугацааг дахин 30 хүртэл хоногоор сунгаж болно.

12. Комисс нь маргаанд холбогдох материал, бичиг баримтыг шалгаж танилцах, шаардлагатай тохиолдолд гомдол гаргагч, түүнд холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтантай уулзах, тэдний тайлбар, санал дүгнэлтийг авах, улмаар зохих үндэслэл бүхий дүгнэлт гаргаж Төрийн захиргааны албаны холбогдох зөвлөлийн удирдлагад танилцуулан хуралдаанаар нь хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

13. Комисс нь маргааныг хянан шалгахдаа дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

1/маргааныг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтыг холбогдох байгууллага, албан тушаалтан, төрийн захиргааны албан хаагч

түүнчлэн гомдол гаргагч иргэнээс гаргуулан авах тэдний тайлбарыг сонсох;

2/ төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг үндэслэн маргааныг үнэн зөв шуурхай шалгах;

3/ гаргасан санал дүгнэлтээ Төрийн захиргааны албаны холбогдох зөвлөлийн хуралдаанаар танилцуулан шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг гомдол гаргагчид мэдэгдэж, тайлбарлах.

Гурав. Маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаа

14. Төрийн захиргааны албаны зөвлөл болон салбар зөвлөл нь төрийн албатай холбогдсон маргааныг хянан шалгасан комиссын дүгнэлтийг хуралдаанаараа хэлэлцэнэ.

Шаардлагатай гэж үзвэл Төрийн захиргааны албаны холбогдох зөвлөлийн даргын болон маргаан хянан шалгах комиссын гишүүдийн санал болгосноор маргагч талуудыг хуралдавд оролцуулж, тайлбар хийх, дүгнэлтийн талаар болон өөр хоорондоо мэтгэлзэх бололцоог тэдэнд олгоно.

15. Төрийн захиргааны албаны зөвлөлийн дүрэмд зааснаар зөвлөл нь асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж дүгнэлт, тогтоол гаргах, эсхүл дахин шалгуулахвар комисст буцаана.

16. Төрийн захиргааны албаны холбогдох зөвлөл нь маргааныг хуралдаанаараа хянан хэлэлцээд дараахь үндэслэлээр дахин шалгуулахаар комисст буцааж болно.

1/ эцсийн шийдвэр гаргах нотолгоо болох бичиг баримтын бүрдэл хангагдаагүй;

2/ маргаанд холбогдох чухал бичиг баримт, үйл явдлыг шалгаагүй.

17. Төрийн захиргааны албаны холбогдох Зөвлөл нь маргаан талаар гарсан шийдвэрээ ажлын 3 өдөрт багтаан маргагч талуудад мэдэгдэх бөгөөд зөвлөлөөс гарсан тогтоолыг төрийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

18. Төрийн албатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэсэн тухай төрийн захиргааны албаны салбар зөвлөлийн шийдвэрийг маргалдагч талууд үл зөвшөөрвөл гомдлоо Төрийн захиргаан албаны зөвлөлд, Төрийн захиргааны албаны зөвлөлөөс гарсан шийдвэрийг үл зөвшөөрвөл гомдлоо шүүхэд тус тус гаргаж болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны II дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 79

Улаанбаатар
хот

Төрөөс мөнгөний бодлогын талаар 1996 онд баримтлах чиглэлийг батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар туйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 1996 онд баримтлах чиглэлийг хэвсрэлтээр баталсугай.

2. Төрөөс мөнгөний бодлогын талаар 1996 онд баримтлах чиглэлийг шинээр батлагдсан Мөнгөн хадгалэмж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай болон Нөхсөлийн тухай хуулиудад заасан зэрчмуудыг хэрэгжүүлэх, урьд батлагдсан хуулиудын эвэлтг хэвшүүлэхэд чиглүүлсүгэй.

3. Монголбанкны эх үүсвэрээр бүрдэж, төрийн өмчид байвал зохих валютын гадаад нөөцийн доод хэмжээг 30,0 сая ам.доллараар тогтоосугай.

4. Төрийн мөнгөний бодлогын чиглэлд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газартай хамтран шуурхай зохион байгуулж, дүнг хагас, бүтэн жилээр Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанкны ерөнхийлөгч Д. Моломжамцад даалгасугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын 1995 оны
79 дугаар тогтоолын хэвсрэлт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 1996 ОНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Төрөөс 1996 онд баримтлах мөнгөний бодлогын үндсэн зорилт нь үнийн өсөлтийг бууруулж, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгахад чиглэнэ. Төгрөгийн худалдан авах чадварын тогтвортой байдлыг хангах нь үйлдвэрлэл, хөрөнгө

оруулалтын тааламжтай орчин бий болгож, гадаад төлбөрийн тэнцлийг сайжруулах, санхүүгийн системийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, банкны хоёр шатлаат тогтолцоог төлөвшүүлэх зэрэг эдийн засгийн зорилттой умдаж, тогтворжилтын хандлагыг бэхжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

Төгрөгийн худалдан авах чадварын харьцангуй тогтвортой байдлыг хангах үйл явцыг дотоодын үнэ, төгрөгийн гадаад валюттаар илэрхийлэгдэх ханшны үзүүлэлтүүдээр дүгнэх бөгөөд энэ нь Монголбанкны зохицуулалтын бие даасан үйл ажиллагаа, Засгийн газар, арилжааны банкуудын хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжинэ.

НЭГ. Мөнгөний нийлүүлэлтийн талаар

Төгрөгийн худалдан авах чадварын харьцангуй тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд мөнгөний нийлүүлэлтийн бодлогыг үнэ, ханшийн түвшин, бодит эдийн засгийн өсөлттэй уялдуулан хэрэгжүүлж нийт мөнгөний жилийн өсөлтийг 30 хувиас хэтрүүлэхгүй байна. Нийт мөнгөний өсөлтийн энэхүү хязгаарын хүрээнд мөнгөний нийлүүлэлтийн огцом хэлбэлзлийг бууруулах зохицуулалтын арга хэмжээ авч, түүний үнийн өсөлтөд нөлөөлөх нөлөөллийг хязгаарлах бодлого явуулана.

Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулахад ашиглаж эхэлсэн мөнгөний бодлогын шууд бус арга хэрэгслүүдийг улам боловсронгуй болгоно.

Төв банкнаас арилжааны банкинд олгох зээлийг тэдний санхүүтөлбөрийн хүчин чадлаас хамааруулан дахин санхүүжилтийн болон үнэт цаасаар баталгаажих хямдруулалтын хэлбэрээр олгож, зээл авах чадвар, эрсдэлийн түвшинд тавих хяналтыг өндөржүүлэн, хамаарах хүрээг нь өргөтгөнө.

Төсвийн санхүүжилтийн дотоод эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газар богино хугацаатай үнэт цаас гаргавал, түүнийг Монголбанк зуучлан мөнгөний зах дээр борлуулахад тусалцаа үзүүлнэ.

Монголбанк нь мөнгөний бодлого, мөрдөгдөж байгаа хууль, эрхийн актыг үндэслэн Засгийн газарт зээл олгож, төлөлтөд нь хяналт тавина.

Ноёд мөнгөний үзүүлэлтийг Төв банкнаас мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах завсрын зорилт болгон хэрэглэж, түүнийг тогтвортой байлгахад чиглэсэн зах зээлийн хошүүрэг, арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Төв банк нь заавал байх нөөцийн хэмжээг арилжааны банкууд умар ч нөхцөлд тогтмол биелүүдэх шаардлагад нийцүүлэн эдийн засгийн ба захиргааны аргыг хослуулан ашиглана.

Төв банкны үнэт цаасыг арилжааны банкуудын илүүдэл нөөцийг татах замаар мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах уян хатан хэрэгсэл болгож үргэлжлүүлэн гаргахын хамт түүний хоёр дахь зах зээлийг бий болгох, арилжааны банкуудаар зуучлуулан банкны бус харилцагчдыг арилжаанд оролцуулахад анхаарна.

Арилжааны банкууд болон харилцагчдын эрэлтийг харгалзан гүйлгээнд байх бэлэн мөнгөний дэвсгэртийн зохистой бүтцийг бүрдүүлэхийн хамт жижиг дэвсгэртүүдийг гүйлгээнээс аажмаар татах арга хэмжээ авна.

ХОЁР. Зээл, хүүгийн бодлогын талаар

Монголбанкнаас арилжааны банкинд олгох зээлийн болон гаргах үнэт цаасны хүү нь үнэ, ханшийн өөрчлөлт, зах зээлийн хүүний түвшинд үндэслэсэн, мөнгөний нийлүүлэлтийг удирдах зорилгод нийцсэн байна.

Арилжааны банкуудаас бизнесийн нэгжүүдэд олгох зээл нь эх үүсвэртээ багтсан байх, өмчийн аливаа хэлбэрийг харгалзахгүй, гагцхүү үр ашигтай арга хэмжээг санхүүжүүлэх, эргэж төлөгдөх баталгаатай байх зарчимд тулгуурлах бөгөөд зээлийн хүүгийн бодлого нь зээлийн эрсдэлээс хамаарахын зэрэгцээ үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжих, техник, технологийг шинэчлэхэд чиглэнэ. Урьд олгосон зээлээс хугацаа хэтэрсэн, найдваргүй зээл, түүний хүүгийн хэмжээг өмнөх жилээс бууруулж, зээл олголт, төлүүлэлтэд тавих урьдчилсан болон дэрвэлсэн хяналтыг өндөржүүлнэ.

Мөнгөний нийлүүлэлтийн зорилттой уялдуулан Засгийн газраас бодлогын хүрээнд дэмжиж хөгжүүлэхээр тодорхойлсон үйлдвэрлэл, үйлчилгээг дунд хугацааны зээлийн эх үүсвэрийн сан бий болгох замаар зээлжүүлэх арга хэмжээг арилжааны банк бүр өөрийн санхүү, төлбөрийн чадвар, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн хэрэгжүүлнэ.

Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд зориулан арилжааны банкнаас найдвартай аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгож, ердийн болон хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүг улсын төсвөөс арилжааны банкуудад нөхөж олгоно.

ГУРАВ. Валютын бодлогын талаар

Төгрөгийн гадаад валютаар илэрхийлэгдэх ханшийг бодитой бо-

гөөд харьцангуй, тогтвортой байлгах нь 1996 оны мөнгө ба валютын ханшийн бодлогын гол зорилт болно. Үүнийг хангахын тулд Монголбанкнаас мөнгөний нийлүүлэлтийг зохицуулахын зэрэгцээ, валютын зах зээл дээр худалдан авах, худалдах валютын хэмжээг оны дүнгээр тэнцүүлэх чиглэлийг баримтална.

Монголбанкны дотоод эх үүсвэрээр бүрдэх улсын гадаад валютын цэвэр нөөцийг нэмэгдүүлж, оны эцэст 60-аас доошгүй сая ам.долларт хүргэнэ. Улсын валютын нөөцийн бүтцийг валютын төрөл, санхүүгийн хэрэгсэл, хадгалуулах банкных нь хувьдооновчтой болгож, нөөцийн удирдлагыг сайжруулан, найдвартай байдлыг дээшлүүлнэ. Үүний тулд Монголбанкны валютын нөөцийн тодорхой хэсгийг зарим орны Төв банкинд байршуулж, эрсдэлээс чөлөөлөгдсөн санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх эхлэлийг тавина.

Төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсний дараа гадаад өр төлбөрийг гүйцэтгэдэг журмыг хатуу мөрдөнө.

Банк хоорондын валютын захын үйл ажиллагааг тогтворжуулж, валют солих цэгүүдийг нэмэгдүүлэн үйл ажиллагааг нь жигдрүүлнэ. Гадаад төлбөр тооцоо хийх эрх бүхий арилжааны банкууд валют худалдан авах, худалдах ханшаа тогтмол зарлаж байх журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

Монголбанкнаас банк хоорондын зах зээл дээрх өмнөх өдрийн арилжааны дүнд тогтоогдсон, валютын худалдан авах, худалдах дундаж ханшинд шууд үндэслэсэн албан ханшийг өдөр тутам мэдээлж байх журамд шилжинэ.

ДӨРӨВ. Банкны бүртгэл, төлбөр тооцооны талаар

Нийтээр даган мөрддөг бүртгэлийн зарчим, олон улсын жишигт тулгуурласан банкны үндэсний нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг 1996 оноос банкны системд мөрдүүлнэ. Монголбанк, арилжааны банкны нягтлан бодох бүртгэлийн дансны нэгдсэн төлөвлөгөө, санхүүгийн тайлан мэдээг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлнэ.

Монголбанкны дотоод үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг өндөржүүлж, бүртгэл, хяналтын шинэ аргачлалыг боловсруулж, салбар хоорондын тооцооны шинэ зарчмыг туршин нэвтрүүлнэ.

Төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх, өр авлагыг барагдуулах, мөнгөн хөрөнгийн эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор арилжааны банкуудыг Монголбанктэй холбосон цахим клирингийн

системийг бий болгож, мэдээллийг саадгүй түргэн солилцох арга замыг судлан турших, сүлжээний нууцлал, зохион байгуулалт, хяналтыг хамаарсан техникийн даалгаврыг боловсруулан мөрдөнө.

Бэлэн бус тооцооны дэвшилтэт хэлбэрүүдийг өргөнөөр ашиглаж, төлбөр тооцооны сахилга батыг дээшлүүлнэ.

ТАВ. Банкны тогтолцоо, бүтцийг сайжруулах эрх зүйн асуудлыг боловсронгуй болгох талаар

Арилжааны банк нь өөрийн хөрөнгийн шаардлага, төлбөрийн чадвар, зээлийн эрсдэл, төвлөрөл, нөөцийн сангийн хүрэлцээ, гадаад валютын акция-пассивын байршил, үйл ажиллагааны бусад үзүүлэлтэд тогтоосон харьцааг хангах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ.

Олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран санхүүгийн системд бүтцийн өөрчлөлт хийх арга хэмжээг авч, арилжааны банкуудын бүтэц, удирдлагыг боловсронгуй болгох, зээл олгохын үйл ажиллагаа, хяналтыг сайжруулах замаар чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, арилжааны банкуудын дотоод хяналт, банк хоорондын зээлийн мэдээллийн системийг хөгжүүлэх, зохих шаардлагыг хангасан арилжааны банкуудыг дахин хөрөнгөжүүлэх арга хэмжээ авч эхэлнэ.

Арилжааны банкны бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтын магадлан шинжилгээний тогтолцоо бий болгож, арилжааны банкны жилийн эцсийн тайлан тэнцэлд дүгнэлт гаргуулж байна.

Арилжааны банкны төлөөлөн удирдах зөвлөл, болон дүрмийн санд хөрөнгө нийлүүдсэн хувь нийлүүлэгчдийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагын эрх зүйн үндэслэлийг зохих журмын дагуу бий болгож, түүний биелэлтэд Засгийн газар, Монголбанкнаас тавих хяналтыг хүчтэй болгоно.

Үйлдвэрлэл, экспортыг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын болон хөгжлийн чиглэлтэй банкны бус санхүүгийн байгууллагыг хөгжүүлэх эрх зүйн үндсийг бий болгоно.

Банкны ажилтын мэргэжлийн түвшинг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалтыг өргөтгөн чанар, үр нөлөөг сайжруулна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1995 оны 12 дугаар
сарын II-ний өдөр

Дугаар 86

Улаанбаатар
хот

Харилцаа холбооны тухай хуулийг
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний
тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Харилцаа холбооны тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ эвч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасгай:

1/харилцаа холбооны салбарын бүтэц, зохион байгуулалтыг 1996 оны I улиралд багтаан Харилцаа холбооны тухай хуульд нийцүүлэх;

2/харилцаа холбооны талаар хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөж байгаа хууль тогтоомийг хуульд нийцүүлэх, холбогдох журмуудыг 1996 оны II улиралд багтаан гаргах.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 7 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 155

Улаанбаатар
хот

**Сэрсэнжавын Дашцэрэнд
Монгол Улсын Хөдөлмөрийн
баатар цол олгох тухай**

Нийслэлийн зорчигч тээврийн шугамын үйлчилгээнд он удаан жил үр бүтээлтэй ажиллаж автобусаа ариг гамтай эзэмшин эдэлгээний нормыг давуулан улсад үлэмж хэмжээний ариулан хэмнэлт оруулсны зэрэгцээ Яармагийн чиглэлийн бригадыг олон жил ахлан удирдаж бригадаараа улсын гурван удвагийн аварга болж, зорчигчдод хөнгөн шуурхай үйлчлэх ариун үйлст оруулж байгаа гарамгай хувь нэмрийг нь үнэлж нийслэлийн зорчигч тээврийн Автобусны II компанийн жолооч Сэрсэнжавын Дашцэрэнд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол олгож Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1995 оны 7 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 160

Улаанбаатар
хот

**Ш. Гунгаадоржийг элчин сайдаар
томилох тухай**

Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Шаравын Гунгаадоржийг томилуулагугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны II дүгээр
сарын 7-ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

1. Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг үндэслэн "Цагдаагийн цол олгох журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ зарлигийг 1995 оны II дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995
оны 222 дугаар зарлигийн хавсралт

ЦАГДААГИЙН ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг үндэслэн цагдаагийн албан хаагчид цагдаагийн цол олгоход энэ журмыг баримтална.

2. Цагдаагийн албан хаагч цагдаагийн цолыг өдөр тутам хэрэглэнэ.

Хоёр. Цагдаагийн цол олгох

3. Цагдаагийн албан хаагчид албан тушлал, алба хаасан хугацаа, ажлын бүтээлийг харгалзан цагдаагийн цол олгоно.

4. Цагдаагийн алба хаагчид цагдаагийн цол олгоход дор дурдсан хугацааг баримтална:

1/цагдаагийн дэд ахлагчаас цагдаагийн ахлагч	5 жил
2/цагдаагийн ахлагчаас цагдаагийн ахлах ахлагч	5 жил
3/цагдаагийн дэслэгчээс цагдаагийн ахлах дэслэгч	3 жил
4/ цагдаагийн ахлах дэслэгчээс цагдаагийн ахмад	3 жил
5/цагдаагийн ахмадаас цагдаагийн хошууч	4 жил

6/цагдаагийн хошуучаас цагдаагийн дэд хурандаа 5 жил

7/цагдаагийн дэд хурандаагаас цагдаагийн хурандаа 6 жил

5. Цагдаагийн албан хаагчид цол олгох хугацааг тооцохдоо сахилгын шийтгэл хүлээх цол буурсан, хасагдсан, ажлаас халагдсан, тахир дутуугийн группэд байсан хугацааг хасаж тооцно.

6. Цагдаагийн офицер, ахлагчийн албан тушаалд анх томилогдож байгаа хүнд офицер ахлагчийн анхны цолыг олгоно. Энэ тохиолдолд томилогдож буй албан тушаалын цолны тэрэглэл нь цагдаагийн офицер, ахлагчийн анхны цолоос дээгүүр байвал мэргэжил, туршлагыг харгалзан дараагийн нь цолыг олгож болно. Гэхдээ цэрэг, цагдаагийн академи, их, дээд сургууль төгсөөгүй хүнд ахмадаас дээгүүр цол олгохгүй.

7. Цагдаагийн офицерын цолыг цагдаагийн төв байгууллагын даргын, ахлагчийн болон сонсогчийн цолыг тэднийг томилох эрх бүхий даргын тушаалаар олгоно.

8. Цагдаагийн офицер, ахлагчид дор дурдсан тохиолдолд энэ журмын 5 дугаар зүйлд заасан хугацаанаас өмнө цол олгож болно:

а/гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах ажилд онцгой амжилт гаргасан;

б/нийгмийн болон цагдаагийн байгууллагын ажилд чухал ач холбогдол бүхий бүтээл, санаачилга гаргаж хэрэгжүүлсэн;

в/гэнэтийн осол, байгалийн гамшгаас хүний амь нас, их хэмжээний өмч хөрөнгө эвэрэн хамгаалсан;

г/ажиллаж байгаагаас дээгүүр ангиллын албан тушаалд томилогдсон.

9. Эрхэлсэн ажилдаа тогтвортой сайн амжилт үзүүлж байгаа Монгол Улсын цагдаагийн байгууллагын болон Цагдаагийн төв байгууллагын харьяа албаны хөдөлмөрийн ба ажил мэргэжлийн аваргаар 2-оос доошгүй удаа шалгарсан алба хаагчид албан тушаалын нь цолны тэрэглэлээс нэг шат дээгүүр цол олгож болно.

10. Хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчаар 10-аас доошгүй жил тасралтгүй, үр бүтээлтэй ажиллаж ахмад цолыг 5, хошууч цолыг 6-гаас дээш жил эдэж байгаа алба хаагчид дараагийн нь цолыг олгож болно.

**Гурав. Цагдаагийн цол олгохыг хойшлуулах,
цолыг бууруулах, хасах, хураах**

11. Цагдаагийн офицер, ахлагчийн ажлын үр бүтээлийг харгалзан ээлжит цолыг дараах тохиолдолд энэ журмын 4 дүгээр зүйлд заасан хугацаанд олгохгүй хойшлуулж болно:

в/эрхэлсэн ажлын үр дүн хангалтгүй байгаа;

б/хууль, цагдаагийн тангараг, төрийн тусгай албан тушаалд та-
них тусгай шаардлага болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн;

в/Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийн 32 дү-
гээр зүйлд зөвхөн дагуу сахилгын шийтгэл хүлээж сахилгын шийт-
гэлгүйд тооцогдох хугацаа болоогүй байгаа;

г/захиргааны шийтгэл хүлээж захиргааны шийтгэлгүйд тооцог-
дох хугацаа болоогүй, ил шийтгүүлж ил шийтгэлгүйд тооцогдох
хугацаа болоогүй байгаа;

д/эрүүгийн ба захиргааны хэргийн учир шалгагдаж байгаа.

12. Дор дурдсан тохиолдолд цагдаагийн алба хаагчийн цолыг нэг
шат бууруулж буюу хэсч болно:

а/хууль, цагдаагийн тангараг, төрийн тусгай албан тушаалд та-
них тусгай шаардлага болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн;

б/сахилгын зөрчил гаргасан.

13. Цагдаагийн цолыг бууруулах сахилгын шийтгэл хүлээсэн ал-
бан хаагч дутагдлаа бүрэн арилгасан бол цол бууруулснаас хойш 6
сараас доошгүй хугацаа өнгөрсний дараа түүнд цолыг нь эргүүлэн
олгож болно.

14. Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийн 29
дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт зөвхөн үндэслэлээр цагдаагийн ал-
бан хаагчийг чөлөөнд гаргалгүй албанаас халж байгаа тохиолдолд
цагдаагийн цолыг хураана.

15. Цагдаагийн цолоо хураалгасан хүн офицер, ахлагчийн албан
тушаалд дахин томилогдвол түүнд офицер ахлагчийн анхим цолыг
олгоно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 96

Улаанбаатар
хот

Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай

Төрийн албаны тухай Монгол Улсын хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 4-т болон 7, 8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн захиргааны албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам"-ыг 1 дүгээр хавсралтын, "Төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ыг 2 дугаар хавсралтын, "Төрийн албан хаагчид эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгох журам"-ыг 3 дугаар хавсралтын, "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ыг 4 дүгээр хавсралтын, "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам"-ыг 5 дугаар хавсралтын, "Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам"-ыг 6 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Төрийн үйлчилгээний албаны зарим албан хаагчид олгох нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээг 7 дугаар хавсралтын ёсоор баталсугай.

3. Төрийн албан хаагчид олгох бүх төрлийн нэмэгдлийн нийт хэмжээ нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалин болон нэмэгдэл хөлсний дүнгийн 40 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосугай.

4. Төрийн албан хаагчид олгосон нэмэгдлүүдийг тэдний ээлжийн амралтын цалин, жирэмсний ба амаржсаны болон хөдөлмөрийн чадвараа түр алдсан хугацааны тэтгэмж олгоход баримтлах сарын хөдөлмөрийн хөлсний бүрэлдэхүүнд оруулан тооцож байсугай.

5. Төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулсны үндсэн дээр тэдэнд нэмэгдэл олгох тухай журмуудыг мөрдөж ажиллахыг сайд, тусгай газрын дарга, бүх шатны Засаг дарга, төрийн өмчийн болон

төсөвт байгууллагын эрх баригч нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хүн амын бодлого,
хөдөлмөрийн сайд

Э. ГОМБОЖАВ

Сангийн сайд

Э. ВЯМБАЖАВ

Засгийн газрын 1995 оны 96 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИД АЛБАН
АЖЛЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ
ЖУРАМ**

1. Төрийн захиргааны албан хаагчид төрийн бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих нэн хариуцлагатай үүргийг гүйцэтгэснийх нь төлөө тухайн албан тушаалыг хашиж байх хугацаанд нь албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийн тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэлд хамаарагдах албан тушаалтанд онцгой нөхцөлийн нэмэгдлийг олгоно.

3. Төрийн захиргааны албан хаагчид олгох албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 10 хувиар бодож олгоно.

4. Төрийн захиргааны албан хаагчид олгох албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн байгууллагын төсвөөс олгоно.

5. Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох бэлтгэлийг хангасны үндсэн дээр энэ журмыг 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөнө.

Засгийн газрын 1995 оны 96 дугаар
тогтоолны 2 дугаар хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИД ТӨРИЙН АЛБА ХААСАН ХУГАЦААНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Төрийн захиргааны албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх зорилгоор төрийн албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн ажилтны төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалин сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

Төрийн алба хаасан хугацаа (жилээр)	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ (хувиар)
5-10	5
11-15	10
16-20	15
21-25	20
26 ба түүнээс дээш	25

3. Төрийн захиргааны албан хаагчийн төрийн алба хаасан хугацаанд дарлах хугацааг оруулж тооцно. Үүнд:

а) төрийн албанд ажилласан

б) төрийн албанд ажиллаж байх хугацааныхаа дундуур мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх, дахин мэргэшэх, шинээр мэргэжил эзэмших дамжаа болон магистрантур, аспирантур, докторантурт суралцсан;

в) төрийн албанд ажиллах хугацаандаа жирэмсэн, амаржсан болон хууль тогтоомжийн дагуу нэмэгдэл чөлөөтэй байсан;

г) төрийн байгууллагын дотоод дүрэмд заасны дагуу чөлөөтэй байсан;

д) төрийн албанд ажиллах үедээ ажлаас үндэслэлгүйгээр халагдсаны улмаас ажилгүй байсан болон энэ тухай хэргийг нь шүүхээс хэрэгсэхгүй болгосон, цагватгагдсан хүмүүсийн мөрдөгдсөн ба ял эдэлсэн (оршоолоор суллагдсан хүмүүс үүнд хамаарахгүй).

4. Төрийн алба хаасан хугацааг байгууллагын боловсон хүчний асуудал эрхэлсэн нэгж буюу ажилтан тодорхойлж, тухайн байгууллагын эрх баригчийн тушаалаар нэмэгдэл олгох хувийг тогтоож байна.

5. Төрийн албанд ажилласан хугацааг тогтоох үндсэн баримт нь хөдөлмөрийн буюу нийгмийн даатгалын дэвтэр болно.

6. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд шаардагдах зардлыг байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.

7. Энэ журмыг төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг нарийвчлан тогтоож, нэмэгдэл олгох бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр 1996 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөнө.

oOo

Засгийн газрын 1995 оны 96 дугаар
тогтоолны 3 дугаар хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ЭРДМИЙН ЗЭРЭГ, ЦОЛНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Төрийн албыг оюуны өндөр мэдлэгтэй, ажлын баялаг туршлагатай боловсон хүчнээр бэхжүүлэх, төрийн албан хаагчид эрдэм боловсролоо ямагт дээшлүүлж байх сонирхлыг хөхүүлэн дэмжих зорилгоор төрийн албан хаагчид эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн дунд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд сургалт, эрдэм шинжилгээ, туршилтын ажил эрхэлдэг, эрдэм шинжилгээний байгууллагад болон судалгаа шинжилгээ, туршилтын үндсэн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа эрдмийн зэрэг, цолтой төрийн албан хаагчид албан тушаалын сарын цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр нэмэгдэл олгож байна:

Эрдмийн зэрэг, цол	Албан тушаалын сарын цалингаас бодох хувь
Доктор зэрэгтэй бол	20
Профессор цолтой бол	10
Дэд доктор зэрэгтэй бол	15
Дэд профессор цолтой бол	5

3. Эрдмийн зэрэг, цолны нэмэгдлийг нэг хүнд давхардуулан олгож болно.

4. Энэ журмын 2-т зааснаас бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа докторын зэрэгтэй төрийн албан хаагчид албан тушаалын сарын цалингийн 15 хувиар, дэд докторын зэрэгтэй төрийн албан хаагчид албан тушаалын сарын цалингийн 10 хувиар тус тус тооцож нэмэгдэл олгоно.

Харин профессор, дэд профессор цолны нэмэгдлийг зөвхөн энэ журмын 2-т дурдсан ажил, үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид олгоно.

5. Эрдмийн зэрэг, цолны нэмэгдлийг тухайн албан хаагчийн албан тушаалын үндсэн ажил үүрэг эрхлэн гүйцэтгэсэн хугацаанд нь бодож олгоно.

6. Эрдмийн зэрэг, цолны нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.

Засгийн газрын 1995 оны 96 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ АЛБАН ХААГЧИД УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ НИЙТЛЭГ ЖУРАМ

1. Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгоход энэхүү нийтлэг журмыг мөрдөнө.

2. Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэт арга барилаар ажиллаж өндөр амжилт гаргасан эсвэл гоц авьяастай ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоно.

3. Ур чадварын нэмэгдлийн доод хэмжээ нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 10 хувь байна.

4. Ур чадварын нэмэгдлийг олгох, олгож байгаа нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах, хасах асуудлыг энэ журмын 2; 8-д заасан шалгуурыг үндэслэн тухайн байгууллагын эрх баригчийн тушаалдар шийдвэрлэнэ.

5. Ур чадварын нэмэгдлийг зөвхөн тухайн албан тушаалыг эрхэлж буй хугацаанд, жинхэнэ ажилласан цагт ноогдох албан тушаалын цалингаас тооцож сар тутам олгоно. Ажлын үр дүн буурсан нөхцөлд ур чадварын нэмэгдлийг олгохгүй.

6. Ур чадварын нэмэгдлийг тухайн салбар, байгууллагын үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг мэргэжлийн албан хаагчид олгоно.

7. Ур чадварын нэмэгдэл шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсвөөс санхүүжүүлэх бөгөөд хэмжээ нь тухайн байгууллагын нийт цалингийн сангийн 0,2 хувьас хэтрэхгүй байна.

8. Ур чадварын нэмэгдэл олгох салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан шалгуур үзүүлэлтийг Сангийн яам, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамтай хамтран төрийн захиргааны тухайн төв байгууллага баталж мөрдүүлнэ.

9. Энэ журмыг бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр 1995 оны 10 дугаар сарын 1-нээс мөрдөнө.

oOo

Засгийн газрын 1995 оны 96 дугаар
тогтоолын 5 дугаар хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ АЛБАН ХААГЧИД МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ НИЙТЛЭГ ЖУРАМ

1. Төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн ажил гүйцэтгэх чадвар, мэргэшлийн түвшинг дээшлүүлэх зорилгоор мэргэшлийн зэргийн нэмэгдлийг олгоход энэ нийтлэг журмыг баримтална.

2. Энэ журмыг үндэслэн төрийн үйлчилгээний албаны тухайн салбарын ажлын онцлогийг харгалзан мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг тогтоосон журмыг харьяалах төрийн захиргааны төв байгууллага Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам, Сангийн яамтай хамтран батална. Энэ журмыг

баримтлан төрийн албан хаагчид мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын эрх баригчийн тушаалаар шийдвэрлэнэ.

3. Мэргэшлийн зэргийн сарын нэмэгдлийн доод хэмжээг төрийн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээнээс дор дурдсан хувиар тогтооно:

Мэргэшлийн зэрэг	Мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хэмжээ /хувиар/
I	15
II	10
III	5

4. Төрийн үйлчилгээний албан а албан хаагчийн мэргэшлийн зэргийг 5 жил тутам шинэчлэн тогтоож байна.

5. Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг зөвхөн тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа хугацаанд нь олгоно.

6. Мэргэшлийн зэргийн нэмэгдэлд зарцуулах хөрөнгийн хэмжээ нь тухайн байгууллагын нийт цалингийн сангийн 3, 5 хувиас хэтрэхгүй байна.

7. Эрдмийн зэрэг, цолын нэмэгдэл авдаг төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй.

8. Энэ журмыг шинээр нэвтрүүлэх салбарт бэлтгэл хангах ажлыг 1995 оны 10 дугаар сард багтаан зохион байгуулж, мөн оны 11 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөнө.

Засгийн газрын 1995 оны 96 дугаар
тогтоолын 6 дугаар хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ШАГНАЛ, УРАМШИЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Төрийн албан хаагчийн ажлын үр дүн, бүтээлч байдлыг тогтмол дүгнэж, сайн ажилласан хүмүүсийг хөхүүлэн дэмжих зорилгоор "Төрийн албаны тухай хууль"-ийн 31 дүгээр зүйлд заасан шагнал, урамшлыг олгоход энэхүү журмыг баримтална.

2. Албан тушаалын үүргээ бүрэн биелүүлж, өндөр амжилт гаргасан төрийн албан хаагчидажлын үр дүнг нь үнэлж төрийн байгууллагын захиргаа, эрх бүхий албан тушаалтан дараахь шагналаар шагнаж урамшуулна:

а) мөнгөн шагналаар шагнах;

б) эд зүйл болон үнэ бүхий зүйл дурсгах;

в) улирлын ажлын дүнгээр болон онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлдсний төлөө мөнгөн урамшил олгох;

г) ажлын үр дүн, гаргасан амжилтыг нь нийтэд мэдээлж алдаршуулах, хүндэт дэвтэрт бичих, жуух, баярын бичгээр шагнах, тэргүүний ажилтан цол олгох;

д) дээд шатны байгууллагын шагналд тодорхойлох.

3. Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын үндсэн болон дэд бүтцэд ордог тусгай газрын дарга, сайд нар эрхэлсэн ажилдаа онцгой идэвх, санавчилгаа гаргаж бусдаас илүү үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан төрийн албан хаагчийг мөнгөн шагналаар шагнаж болно.

4. Энэ журмын 3 дугаар зүйлд заасан албан тушаалтны олгох мөнгөн шагнал дор дурдсан хэмжээтэй байна:

а) сум, дүүргийн Засаг дарга 15 хүртэл албан хаагчийг тус бүр 25000 хүртэл төгрөгөөр;

б) аймгийн Засаг дарга 12 хүртэл албан хаагчийг тус бүр 50000 хүртэл төгрөгөөр;

в) нийслэлийн Засаг дарга 12 хүртэл албан хаагчийг тус бүр 75000 хүртэл төгрөгөөр;

г) Засгийн газрын үндсэн болон дэд бүтцэд ордог тусгай газрын дарга нар 10 хүртэл албан хаагчийг 100000 хүртэл төгрөгөөр;

д) Монгол Улсын сайд 10 хүртэл албан хаагчийг тус бүр 150000 хүртэл төгрөгөөр.

5. Төрийн байгууллагын захиргаа нь мэргэжлийн өндөр ур чадвар, идэвх сэнэвчилгээ гарган албан үүргээ тогтмол чанартай сайн биедүүлж, ажлын өндөр амжилт гаргасан, албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахих, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж байгаа төрийн албан хаагчид уларлын ажлын нь үр дүнгээр албан тушаалын сарын цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналолгож болно. Албан хаагчийг тайнхүү шагнаж урамшуулах үзүүлэлт, журмыг төрийн тухайн байгууллага боловсруулж хэрэгжүүлнэ.

6. Төрийн байгууллагад тогтвор суурьшаа үр бүтээлтэй, олон жил (10-ээс доошгүй жил) ажилласан төрийн албан хаагчид насны ой тэмдэглэлт үйл явдлыг тохкоолдуулан болон гэр бүл болоход нь байгууллагын захиргаанаас 50000 хүртэл төгрөгийн үнэ бүхий эд зүйлийг дурсгаж болно.

7. Төрийн албан хаагчийн ажлын амжилтыг үнэлж төрийн захиргааны төв болон лутгийн захиргааны байгууллагын хүндэт дэвтэрт бичих буюу жуух болон баврын бичгээр шагнаан урамшуулж, салбарын тэргүүний ажилтан цол олгоно. Хүндэт дэвтэрт бичигдсэн, жуух, баврын бичгээр шагнагдсан болон салбарын тэргүүний ажилтан цол авсан хүмүүст олгох мөнгөн шагналын хэмжээг Засгийн газрын 1994 оны 123 дугаар тогтоолоор батлагдсан журмыг баримтлан тогтооно.

8. Байгалийн гамшиг (газар хөдлөх, усны үер болох зэрэг) болсон, үйлдвэрлэлийн осол, техникийн ноцтой аазаар сүйрэл гарсан, халдварт өвчин тахал хэлбэрээр гарсан үед хөр уршгийг нь арилгах зэрэг нэн түвэгтэй албан даалгаврыг иргэний эр зориг гарган гүйцэтгэсэн, түүнчлэн улс орны болон салбарын хэмжээний тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой төсөл, хөтөлбөр, эрдэм шинжилгээний бүтээл боловсруулж түүнийг гардан хэрэгжүүлж бодитой үр дүн гаргасан, урлаг, соёлын гарамгай бүтээл туурвисан төрийн албан хаагчдад 250000 хүртэл төгрөгийн урамшлыг төрийн төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн Засгийн газрын шийдвэрээр олгоно.

9. Энэ журмын 4, 8 дугаар зүйлд заасан шагналд зарцуулах хөрөнгийг улсын төсвөөс, 5, 6, 7 дугаар зүйлд заасан шагналд зарцуулах хөрөнгийг тухайн байгууллагын төсвийн хэмнэлт, өөрийн орлогоос тус тус гаргана.

Засгийн газрын 1995 оны 96 дугаар
тогтоолын 7 дугаар хэвсрэлт

**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ЗАРИМ АЛБАН
ХААГЧИД ӨЛГӨХ НЭМЭГДЭЛ ХӨЛС, НЭМЭГДЛИЙН
ХЭМЖЭЭ**

№	Салбар	Албан тушаал	Сар тутам олгох нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэм- жээ (тогрөг)
Нэг. Нэмэгдэл хөлс			
1.	Боловсрол, шинжлэх ухаан	-докан -тэнхимийн эрхлэгч -салбарын эрхлэгч -секторын товчооны эрхлэгч -лабораторийн эрх- лэгч	1500 1300 1100 1100 1000
2.	Эрүүл мэнд	-эмнэлгийн тасгийн эрхлэгч	800
1.	Боловсрол	Хоёр. Нэмэгдэл -оюун ухаан, бие эрхтэний согогтой хүүхдийн ерөнхий боловсролын тусгай сургуулийн захирал, дэд захирал, багш	1200
2.	Эрүүл мэнд	-гоц халдварт, шүүх эмнэлэг, эмгэг анатомин их эмч -мэс тасал, гэмтэл согог, сэхээн амьд- руулах, мэдээгүй- жүүлэх, эх барих эмэгтэйчүүдийн их эмч, хөдөөгийн сум, орхийн их эмч, ба- гийн бага эмч	1200 1000
3.	Соёлол	-гоцлол жүжигчин	1000

- ТАЙЛВАР:** 1. Энэхүү хавсралтын "Хоёр"-ын 2-т заасан нэмэгдэл авч байгаа эмч нар тасгийн эрхлэгчийн үүргийг давхар гүйцэтгэж байгаа бол тэдэнд нэмэгдэл хөлс, нэмэгдлийг давхардуулан олгоно.
2. Холбогдох салбарын ахлах албан хаагчид 700 төгрөгийн нэмэгдэл хөлс /мэргэшлийн тэргийн нэмэгдэлтэй давхардуулахгүйгээр/-ийг олгоно.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1995 оны 6 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 97

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

"Төрийн албаны тухай Монгол Улсын хууль"-ийн 26 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

"Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хууль зүйн сайд

Н. ЛУВСАНЖАВ

Засгийн газрын 1995 оны 97 дугаар
тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИД САХИЛГЫН
ШИЙТГЭЛ НОГДУУЛАХ, ЭНЭ ТАЛААР ТӨРИЙН ДЭЭД
ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ГОМДОЛ ГАРГАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, тэдгээрээс сахилгын шийтгэлтэй холбогдуулан төрийн дээд

шатны байгууллагад гомдол гаргахад энэ журмыг мөрдөнө.

2. Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

Хоёр. Сахилгын шийтгэл ногдуулах

3. Сахилгын шийтгэлийг тухайн албан хаагчийг харьяалсан нэгжийн удирдлагын саналыг үндэслэн түүнийг ажилд томилсон албан тушаалтны шийдвэрээр ногдуулна.

4. Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийг заавал шалгаж тогтоон, энэ тухай баримт, үндэслэлийг зөрчил гаргасан албан хаагчид урьдчилан танилцуулсан байна. Зөрчил гаргасан албан хаагч уг баримт материалтай танилцаад нэмэлт тайлбар хийх, дахин шалгалт явуулахыг шаардах эрхтэй.

5. Сахилгын шийтгэл ногдуулах тухай санал, баримт материалтай танилцаад сахилгын шийтгэл ногдуулах эрх бүхий албан тушаалтан дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

а/ зөрчлийн шинж байдал, зөрчил гаргасан шалтгаан болон зөрчил гаргагчийн хувийн байдлыг харгалзан төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3-т заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулах;

б/ дахин шалгалт хийлгэх, нэмэлт баримт материал шаардан авах;

в/ төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах тухай саналыг үндэслэлгүй гэж үзвэл хэрэгсэхгүй болгох.

6. Сахилгын шийтгэл ногдуулах эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл ногдуулах нь зүйтэй гэж үзвэл энэ тухай тушаал гаргана.

Тушаалыг сахилгын шийтгэл хүлээсэн төрийн захиргааны албан хаагчид танилцуулж, хувийн хэрэгт нь хавсаргах бөгөөд шаардлагатай гэж үзвэл сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг байгууллагын хамт олонд мэдээлнэ.

7. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар /өвчтэй, ээлжийн амралт, чөлөөтэй байсан, түүнчлэн зөрчил гаргасан байдлыг шалгасан хугацааг энэ хугацаанд оруулахгүй/, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй.

Сахилгын нэг зөрчилд нэг төрлийн шийтгэлийг ногдуулах ба сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулж болохгүй.

8. Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жилийн хугацаа өнгөрсөн энэ хугацаанд дахин зөрчил гаргаагүй бол сахилгын шийтгэлгүйд тосцо.

Гурав. Сахилгын шийтгэлтэй холбогдсон гомдлыг хянаж шийдвэрлэх

9. Сахилгын шийтгэл хүлээсэн төрийн захиргааны албан хаагч уг шийтгэлийг үндэслэлгүй буюу буруу ногдуулсан гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэнээс хойш 1 сарын дотор харьяалах дээд шатны төрийн байгууллагадаа бичгээр гаргана.

Гомдолд сахилгын шийтгэл ногдуулах болсон шалтгаан, түүнийг үндэслэлгүй буюу буруу ногдуулсан гэж үзэж байгаа тухай үндэслэлийг товч, тодорхой дурдсан байна. Шаардлагатай гэж үзвэл түүнд холбогдох бусад бичиг, баримтыг хавсаргаж болно.

10. Харьвалах дээд шатны төрийн байгууллага гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

11. Харьвалах дээд шатны төрийн байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтан гомдлыг хянаж шийдвэрлэхдээ дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

а/ Төрийн албаны тухай Монгол Улсын хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг үндэслэн гомдлыг үнэн зөв, шуурхай шийдвэрлэх;

б/ гомдлыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай бичиг, баримтыг холбогдох байгууллага, албан тушаалтан, түүнчлэн гомдол гаргагчаас гаргуулан авах, тэдний тайлбарыг сонсох;

в/ гомдлыг хянаж үзээд гаргасан шийдвэрийг гомдол гаргагчид болон түүний ажилладаг үндсэн байгууллагад нь мэдэгдэх, шаардлагатай тохиолдолд тайлбар өгөх.

12. Гомдол гаргагч харьвалах дээд шатны төрийн байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор Төрийн захиргааны албаны зөвлөлд, эсхүл шүүхэд гаргаж болно.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

1995 оны 6 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 98

Улханбаатар
хот

**Зарим тогтоол, тогтоолын заалтыг
хүчингүй болсонд тооцох тухай**

Монгол Улсын Төрийн албаны тухай зууль батлагдсантай холбогдуулан хавсралтад дурдсан Засгийн газар, Сайд нарын Зөвлөлийн тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хууль зүйн сайд

Н. ЛУВСАНЖАВ

Засгийн газрын 1995 оны 98 дугаар
тогтоолын хавсралт

**ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ЗАСГИЙН
ГАЗАР /САЙД НАРЫН ЗӨВЛӨЛИЙН/-ЫН
ТОГТООЛ, ТОГТООЛЫН ЗААЛТЫН
ЖАГСААЛТ**

1. "Сумын гүйцэтгэх захиргааны даргын үүргийг сангийн аж ахуйн даргад хавсруулах тухай" 1960 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 152 дугаар тогтоол.

2. "Эм хангамжийн ажлыг сайжруулах арга хэмжээний тухай" 1962 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 311 дүгээр тогтоол.

3. "Ажилчдыг зохион байгуулалттай элсүүлэх журмын тухай" 1966 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 299 дүгээр тогтоол.

4. "Сүрьеэ өвчтэй хоригдол хүмүүсийг тусгаарлан эмчлэх тухай" 1973 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 121 дүгээр тогтоол.

5. "Сум, бригадын төвийг тохижуулах ажлын явцны тухай" 1975 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 484 дүгээр тогтоол.

6. "Гадаадад цэргийн сургууль, хурст суралцагчдын зардал, хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 1976 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 99 дүгээр тогтоол.

7. "Ойн хамгаалалт, ашиглалтыг сайжруулах, ой жуулалтын ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" 1981 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 396 дугаар тогтоол.

8. "Телеологч томилж тухай" 1985 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 162 дугаар тогтоол.

9. "Заавар батлах тухай" 1985 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 296 дугаар тогтоол.

10. "Хөдөлмөрийн сахилга бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөл, Монголын Үйлдвэрчний эвлэлийн төв зөвлөлийн 1986 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 11/7 дугаар тогтоол.

11. "Төрхурахын үслэг ангийн сангийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай" 1986 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 262 дугаар тогтоол.

12. "Ой, ан хамгаалах ажлыг сайжруулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 1986 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 320 дугаар тогтоолын 2 дугаар зүйл.

13. "Хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйн хөдөлмөрийн зохион байгуулалт, нормчлол, хөлсний шинэ системийг нэвтрүүлэх арга хэмжээний тухай" 1986 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 327 дугаар тогтоол.

14. "Удирдлагын зохион байгуулалтын өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн хүмүүсийг ажлаар хангах, тэдэнд тэтгэмж олгож, хөнгөлөлт эдлүүлэх тухай" 1990 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 146 дугаар тогтоол.

15. "Орон нутгийн хотын болон хэсгийн шүүгч, прокурор нарын цалинг нэмэгдүүлэх тухай" 1990 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 414 дүгээр тогтоол.

16. "Багш нарын цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох тухай" 1991 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 100 дугаар тогтоол.

17. "Сахилга, дэг журмыг бэхжүүлэх, ажлын хариуцлагыг дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 248 дугаар тогтоолын "Гурав"-ын 1, 2, 3, 4, 6, 11, 13 дугаар зүйл.

18. "Төрийн захиргааны байгууллагын боловсон хүчний ажлын зохион байгуулалтын тухай" 1991 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 293 дугаар тогтоол.

19. "Төрийн өмчийн төсөвт байгууллагын ажилтны амьдралын нийгмийн баталгааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 1992 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоол.

20. "Албан хэргийг монгол бичгээр хотлон явуулах бэлтгэлийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай" 1992 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 63 дугаар тогтоолын 8 дугаар зүйл.

21. "Хүн амын нийгмийн баталгааг хангах зарим арга хэмжээний тухай" 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 69 дүгээр тогтоолын "Хоёр"-ын 3 дугаар зүйл.

22. "Хүн амын нийгмийн баталгааг хангах ээлжит арга хэмжээний тухай" 1993 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 184 дүгээр тогтоолын 3, 4, 5 дугаар зүйл.

oOo

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 6 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 100

Улаанбаатар
хот

**Стандартчилал, чанарын баталгаа-
жуулалтын тухай хуулийг хэрэг-
жүүлэх зарим арга хэмжээний
тухай**

Монгол Улсын Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу заавал мөрдөх улсын стандарт, улсын зохих стандартын заавал мөрдөх үзүүлэлт, шаардлагыг тогтоох объектын дэлгэрэнгүй жагсаалтыг 1 дүгээр хавсралтын ёсоор баталсугай.

2. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу чанарын баталгаажуулалтад заавал хамрагдах импорт, экспортын бүтээгдэхүүний жагсаалтыг 2 дугаар хавсралтын ёсоор, тэдгээр бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, шалгах журмыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Үндэсний хөгжлийн газар /Ч. УЛААН/-т даалгах нь:

а/ энэхүү тогтоолын I дүгээр хавсралтад дурдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл бүрэлдэж, чанарын өрсөлдөөн өргөжихийн хэрээр заавал мөрдөх улсын стандарт тогтоолгох объектыг цөөрүүлж, тэдгээрт зөвлөмжийн стандарт гаргаж байх чиглэл баримтласугай;

б/ стандартын бүтэц, бичлэг болон стандарт боловсруулахад хэрэглэгдэх суурь стандартуудыг олон улсын хэмжээнд танигдах шаардлагад нийцүүлэн байнга шилэчилж мөрдүүлэх арга хэмжээ авч ажилласугай;

в/ Үндэсний стандартчилал, хэмжил түүн төвийн болон түүнээс эрх авсан орон нутгийн стандартчиллын албадмын сургалтын баазыг сайжруулах, стандарт, мэдээллийг хэвлэн олшруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг энэ онд багтаан хэлбэгдох зам, газартай хамтран авсугай.

4. Стандартчилал, чанарын баталгаажуулалтын ажлыг сайжруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг сайд, тусгай газрын дарга, нийслэл, аймгийн Засаг дарга, төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын дарга нэрт дөвлөсугай:

а/ тухайн салбар, орон нутгийн хэмжээнд болон байгууллагад мөрдүүлэхээр стандартчилал, чанарын баталгаажуулалт, сорилт туршиатны талаар болон бүтээгдэхүүний бүртгэл зөвшөөрлийн асуудлаар гаргасан шийдвэрүүдээ энэ оны 9 дүгээр сарын 1-ний дотор Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуульд нийцүүлэх;

б/ энэ тогтоолын I дүгээр хавсралтад өрсөн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаархи улсын стандартад эрүүл ахуй, чанарын хийгээд аюулгүй байдал, хэрэглээний зохих шаардлагыг хэлбэгдэхэд заавал мөрдсөн байх үзүүлэлт, шаардлагыг бүрэн тусгах чиглэлээр тэдгээрийг хянаж шинэчлэх ажлыг 1995-1997 онд багтаан гүйцэтгэх арга хэмжээ авах;

в/ Монгол Улсад стандартыг "улсын" хийгээд "байгууллагын" гэж ангилах болсонтой холбогдуулан одоо хүчинтэй байгаа техникийн нөхцөл /"ТН"/-ийг энэ оны 8 дугаар сарын 1-ний дотор хүчингүй болгох, шаардлагатай гэж үзвэл түүний оронд улсын стандарт боловсруулж энэ онд багтаан зохих журмын дагуу батлуулах мөрдүүлэх.

5. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хөнгөн шуурхай үйлчлэх боломж, экспорт, импортын бүтээгдэхүүний чанар, аюулгүй

байдлын талвархи үзүүлэлтүүдийг үнэн зөв тодорхойлох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон нутагт байгаа чанарын сорилтын материаллаг баяз, мэргэжлийн боловсон хүчний нөөцийг зүй зохистой ашиглаж, стандартчилал, хэмжил зүйн болон эрүүл ахуй, мал эмнэлэг, ариун цэвэр, ургамал хорго цээрийн сорилтын лабораториудын үйл ажиллагааг төрөлжүүлэн зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах арга хэмжээг холбогдох хам, газар, мэргэжлийн байгууллагуудтай хамтран энэ онд багтаан авахыг нийслэл, аймгийн Засаг дарга нурт даалгасугай.

6. Эрүүл мэндийн хам /П.НЯМДАВАА/, Хүнс, хөдөө аж ахуйн хам /Ц.ӨӨЛД/-д даалгаа нь:

а/ Стандартчилал, чанарын баталгаа жуулалтын тухай хууль гарсантай холбогдуулан эрүүл мэндийн болон хөдөө аж ахуй, хүнсний салбарын чиглэлээр улсын стандартыг боловсруулах, батлуулах, өөрчлөх, хүчингүй болгох ажлыг эрхлэх орон тооны бус стандартчилалын техникийн хороо байгуулах ажлыг зохих журмаар шийдвэрлүүлж жил бүрийн хөтөлбөртэй ажиллуулахын хамт, ажлыг нь улсын стандартчиллын жил бүрийн нэгдсэн хөтөлбөртэй уялдуулж, гүйцэтгэлд нь хиналт тавьж ажилласугай;

б/ Стандартчилал, чанарын баталгаа жуулалтын тухай хууль гархаас өмнө тус тусын салбарын чиглэлээр баталсан улсын стандартын эх материалыг Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн Улсын стандарт, баримт бичгийн төв санд энэ оны 8 дугаар сард багтаан шилжүүлсүгэй.

7. Стандартчилал, чанарын баталгаа жуулалтын тухай хууль гарсантай холбогдуулан "Журам, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1991 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 260 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл олгох журам"-ын хансалт-" Аж ахуйн нэгжээс зөвшөөрөлтэйгээр эрхлэх гүйцэтгэж болох үйлдвэрлэл, үйлчилгээний жагсаалт"-ын 11, 13 дугаарт заасан ажил, үйлчилгээ эрхлэх байгууллагад "стандартчилал, хэмжил зүйн төв, орон нутгийн байгууллага"-ыг нэмж оруулахын хамт "Стандартчиллын дүрэм батлах тухай" Засгийн газрын 1988 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 308 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Монгол Улсын сайд бөгөөд
Үндэсний хөгжлийн газрын
дарга

Ч. УЛААН

Засгийн газрын 1995 оны 100 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ЗААВАЛ МӨРДӨХ УЛСЫН СТАНДАРТ, УЛСЫН
ЗОХИХ СТАНДАРТЫН ЗААВАЛ МӨРДӨХ ҮЗҮҮ-
ЛЭЛТ ШААРДЛАГЫГ ТОГТООХ ОБЪЕКТ
(ЗҮЙЛ)-ЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ЖАГСААЛТ**

**Нэг. Салбар хоорондын шинжтэй дараахь объектын
нийтлэг шаардлагын тухай улсын стандарт:**

1. Улсын стандартчиллын тогтолцоо
2. Зураг төсөл, зохион бүтээх баримт бичгийн нэгдсэн тогтолцоо
3. Технологийн баримт бичгийн нэгдсэн тогтолцоо
4. Удирдлагын баримт бичгийн ижилтгэсэн тогтолцоо
5. Мэдээлэл, ном зүйн болон бусад баримт бичгийн тогтолцоо
6. Хөдөлмөрийн нөхцөлийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагын стандартчиллын тогтолцоо
7. Байгаль орчныг хамгаалах стандартчиллын тогтолцоо
8. Хүлцэл, суултын тогтолцоо
9. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тогтолцоо
10. Чанарын статистик хяналтын арга
11. Нэр томъёо, тодорхойлолт
12. Зохион байгуулалт, арга-зүйн болон ерөнхий техникийн хэм хэмжээ, шаардлага

**Хоёр. Хяналт, шинжилгээ, сорилтын аргын тухай
улсын стандарт:**

1. Дээж авах
2. Шалгах
3. Турших, сорих
4. Хэмжих
5. Шинжлэх
6. Стандартчилсан загвар

**Гурав. Дараахь төрлийн бүтээгдэхүүн, түүхий эд, материалын
чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагын
тухай улсын стандарт:**

1. Хүнсний зориулалт бүхий түүхий эд, материал бүтээгдэхүүн
2. Мал, амьтны гаралтай төрөл бүрийн түүхий эд, бэлтгэлийн зүйл, түүгээр хийсэн бүтээгдэхүүн

3. Хүн, малын төрөл бүрийн эмийн зүйл
4. Хүн, малын эмийн материал, түүхий эд
5. Хүнсний бүтээгдэхүүний зориулалттай сав, баглаа боодол, үүний дотор анхан шатны боодол, савлалт
6. Ахуйн зориулалттай химийн төрөл бүрийн бүтээгдэхүүн, тэдгээрийн органик нэгдлүүд
7. Үнэртэн, гоо сайхны болон ариун цэврийн бүтээгдэхүүн, тэдгээрийн түүхий эд, материал
8. Лак, түүний бүтэц найрлагад орох бодис, материал, шүүс, ханд
9. Будаг, түүний найрлагад орох түүхий эд, материал
10. Төрөл бүрийн цавуу, түүний найрлагад орох түүхий эд, материал
11. Төрөл бүрийн зориулалт бүхий саван, гадаргуугийн идэвхит бодис, материал
12. Цэвэрлэгээ, өнгөлгөөний төрөл бүрийн бодис
13. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалт бүхий төрөл бүрийн химийн бодис, материал, бүтээгдэхүүн
14. Шохой, гөлтгөнө
15. Резин, түүгээр хийсэн эдлэл
16. Каучук, түүгээр хийсэн эдлэл
17. Эмчилгээ, оношилгооны аппарат, багаж хэрэгсэл
18. Үр тогтоохгүй эмнэлгийн хэрэгсэл
19. Зүү, тариур
20. Шүдний болон мэс заслын зориулалт бүхий багаж хэрэгсэл, аппарат, материал, түүхий эд
21. Хиймэл эрхтэний төрөл бүрийн материал, түүхий эд
22. Ган хийц, эдэлхүүн
23. Ширэм, ширмэн хийц, эдэлхүүн
24. Өнгөт болон ховор металл, түүгээр хийсэн бүтээгдэхүүн
25. Гал түймрийн техник хэрэгсэл
26. Цөмийн энергийн технологи, хөдөлгүүр машин, цацраг идэвхит бодис, изотопын багаж, үүнд холбогдох багаж, тоног төхөөрөмж, хамгаалалтын тусгай хэрэгсэл
27. Шатамхай, дэгдэмхий бодис, хий
28. Керамик, түүгээр хийсэн эдлэл
29. Хараа зүйн техник хэрэгсэл
30. Бүх төрлийн тээврийн хэрэгсэл, тэдгээрийн агрегат, эд анги, холбогдох аппарат, багаж хэрэгсэл

31. Эрчим хүч, геологи, уул уурхайн болон геодезийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, шалгах, хянах зориулалтын зэрэг бусад суурь машин, түүний эд анги, багаж хэрэгсэл, холбогдох тоноглол
32. Төрөл бүрийн зориулалттай өргөх, тээвэрлэх машин тоног төхөөрөмж, эд анги, бэхэлгээ, холболтын материал
33. Шахилгаан, уур, даралтаар ажиллах төрөл бүрийн зориулалт бүхий тогоо, машин техник, тэдгээрийн тоног төхөөрөмж болон шаардагдах сэлбэг, тоноглол
34. Мод, метала, резин, каучук боловсруулах, зүсэх, зорох, хөрсөөдөх зэрэг зориулалтын машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги, жолоодлогын аппарат тохируулах бусад хэрэгсэл
35. Ахуйн төрөл бүрийн багаж хэрэгсэл
36. Хэмжих, шалгах сорих, турших, хянах төрөл бүрийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги
37. Төрөл бүрийн машин механизм, үйлдвэрлэлийн технологийн тоноглол
38. Төрөл бүрийн гагнуур, түүний багаж хэрэгсэл, материал
39. Бэхэлгээ, холбоос, түгжээс, давцны эд анги, материал
40. Хөдөө аж ахуй, ой, замын зориулалт бүхий төрөл бүрийн машин механизм, тэдгээрийн агрегат, эд анги, сэлбэг, тоноглол
41. Цаг, түүний эд анги
42. Барилга, зам, гүүрийн барилга засварын ажилд хэрэглэгдэх машин механизм, тэдгээрийн агрегат эд анги, сэлбэг, тоноглол, бусад хэрэгсэл
43. Хүнд, хөнгөн ба хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмж, аппарат
44. Замын хөдөлгөөн зохицуулалтын таних тэмдэг
45. Шуудан, цахилгаан холбооны зориулалттай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл
46. Барилга, байгууламжийн болон бусад объектын найдваршил, бөх бат, удаан эдэлгээ шаардах хэсэгт хэрэглэгдэх төмөр, бетон, керамик, мод, бусад материалаар хийсэн хайц, бүтэц
47. Нясдэг аппарат, түүний эд анги
48. Агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, үүний дотор хөлөг онгоц, завь, хөвөгч хэрэгсэл, тэдгээрийн эд анги
49. Ерөнхий машин үйлдвэрлэлийн хэрэгдэлийн бүтээгдэхүүн
50. Кино болон гэрэл зургийн зориулалттай хэрэгсэл
51. Зүтгүүр, трамвай троллейбус, хөдлөх бүрэлдэхүүн, түүний агрегат, эд анги, тоног төхөөрөмж, сэлбэг, тоноглол

52. Төрөл бүрийн зориулалтын цаас, хатуулаг цаас, (картон)
53. Радио болон цахилгаан техник, холбооны хэрэгсэл, холбогдох материал
54. Ахуйн болон техникийн зориулалттай шил, шилэн эдлэл
55. Ахуйн, цахилгааны болон барилгын зориулалттай шалзан, нааран эдлэл
56. Лабораторийн зориулалттай ашнارات, хэрэгсэл, бусад шаардлагатай материал, урвалж
57. Төрөл бүрийн зориулалт бүхий гутал, ботник
58. Хивс, хивсэнцэр болон бусад дэвсгэр
59. Төрөл бүрийн шүхэр, халхавч, тавг, тулуур
60. Ор, дэрний хэрэглэл
61. Хувцас, түүний төрөл бүрийн материал
62. Гэр ахуйн, сургууль, цэцэрлэгийн, конторин, амралт, сувилал, зочидбуудал, олон нийтийн бусад үйлчилгээний зориулалттай гавилга
63. Эсгий, ихээхэнгүй материал, тусгай зориулалтын ээрмээ, оос, тээс, тэдгээрээр хийсэн гэр ахуйн зүйл
64. Хүнсний болон ахуйн зориулалттай цахилгаан хэрэгсэл
65. Хүнсний болон ахуйн зориулалттай, ихэ бүрийн материалаар хийсэн төрөл бүрийн сав суулга, аяга, таваг, халбага, сэрээ, хутга
66. Гэр ахуйн зориулалттай багаж хэрэгсэл, материал
67. Галд тэсвэртэй материал
68. Төрөл бүрийн тэжээл
69. Тэжээлийн төрөл бүрийн ургамал, ногооны үр
70. Үр, тариа, төрөл бүрийн хүнсний ногоо
71. Төрөл бүрийн бордоо
72. Үйс, үйсэн эдлэл
73. Суулгац
74. Нүүрс, кокс, бусад эрдэс, тэсрэх бодис, бүтээгдэхүүн, шахагч элдмэл
75. Төрөл бүрийн хүдэр, шаврга ба үнсний цацраг идэвхжлийн эмжээ
76. Төрөл бүрийн баяжмал бүтээгдэхүүн
77. Нефть, түүгээр хийсэн бүтээгдэхүүн
78. Бүх төрлийн анхдагч болон хоёрдогч түүхий эд
79. Давс
80. Хүдэр
81. Элс

82. Цемент
83. Хангн материал (бүх төрлийн тоосго, хүрмэн, бетон, хөнгөн бетон болон үнсэн блок г. м.)
84. Барилгын зориулалттай холбогч, дүүргэгч бусад материал, түүхий эд
85. Бетон, түүгээр хийсэн хийц, эдлэл
86. Дулаан, цахилгаан тусгаарлагч материал, түүхий эд
87. Барилга, байгууламжийн зориулалттай чулуу, гипс, гөлтгөнө, шил, вааран эдлэл, тэдгээртэй төсөөтэй бүтээгдэхүүн
88. Барилгын зориулалттай дулаан тусгаарлах материал
89. Барилгын дээврийн материал
90. Ахуйн болон техникийн зориулалттай хуванцар эдлэл
91. Тусгай зориулалтын болон унадаг дугуй
92. Буу, зэр зэвсэг, байлдааны хэрэгсэл, тэдгээрийн эд анги, сэлбэг, тоног хэрэгсэл
93. Хүүхдэд зориулсан тоног төхөөрөмж, хэрэгсэл
94. Хүүхдийн бүх төрлийн тоглоом, наадгай
95. Хөдөлмөрийн чадваргүй (тахир дутуу) хүмүүст зориулсан багаж хэрэгсэл
96. Спорт, биеийн тамирын хэрэгсэл, төхөөрөмж
97. Сүлжмэл, нэхмэл хувцас, тэдгээрийн материал
98. Дуу шуугиан, доргио намжаах материал, техник, хэрэгсэл
99. Машин, техникийн зориулалттай төрөл бүрийн дугуй
100. Нийлэг эдлэл, материал
101. Рашаан, ундны болон ахуйн ус, түүнчлэн бохир ус цэвэрлэх, халдваргүйжүүлэх, төмөргүйжүүлэх зэрэг усны чанар сайжруулахад хэрэглэгдэх тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, материал

**Дөрөв. Дараахь төрлийн үйлчилгээнд тавих
нийтлэг шаардлага**

1. Зочид буудал, аялал жуулчлалын бааз, ангийн отог, рестораны бар
2. Оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, нөхөн сэргээгчийн үйлчилгээ
3. Боловсрол
4. Банк
5. Нийтийн тээврийн (авто, агвар, төмөр зам, усан тээврийн) үйлчилгээ
6. Даатгал
7. Шуудан, холбоо

8. Олон нийтийн мэдээлэл
9. Худалдаа
10. Нийтийн хоол
11. Санхүү
12. Номин сви

oOo

Засгийн газрын 1995 оны 100 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТАД ЗААВАЛ ХАМРАГДАХ ИМПОРТ, ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

Барууны бүлэг ("БТКУС"-ийн кодны дагуу)

Бүлгийн код	Барууны бөсөгчлэл
	I Экспорт, импортын бараа
01	Мал, амьтан
02	Мал, амьтны мах, дайвар бүтээгдэхүүн
03	Жагас ба усны сээр нуруутуу амьтан
04	Сүү, цагаан идээ, цусартай өндөг, эсвэл эсвэр баг
05	Өдөн тэжээл, элэр, түүхий, но, усны гурил
07	Хүнсний ногоо, хүнсний зэргэмэл
10	Үр тариа
11	Гурилын үйлдвэрийн бүтээгдэхүүн
12	Тослог үр жимс ба бусад үр жимс, үйлдвэрлэлийн буюу эмчилгээний зориулалттай ургамал
15	Мал, амьтны таралтай тос, тос
16	Махны бүтээгдэхүүн
17	Салар, саяаран бүтээгдэхүүн
18	Какао, какаосний бэлдэг
19	Хүүдлийн моол тэжээл, будаа, гурил, шардуу ба сүүний бэлдмэл
20	Ногоо, жимс, саяар буюу ургамлын ад хэсгийн бэлдмэл
21	Кофе, чай, халуун ногоо болон элээр элэр тулгуурлан бэлдэгдэн ханд, концентрат
22	Уцдаа, спирт, араа, дарс, шинг
23	Мал, амьтны тэжээл
24	Тамхи, тамхныг орлох бүтээгдэхүүн
25	Эрдэс бүтээгдэхүүн
26	Хүдрийн баяжмал
27	Эрдэс түүш, нефть ба нефть бүтээгдэхүүн
28	Органик биш химийн бүтээгдэхүүн, радио идэвхит элемент
29	Органик химийн идэвхүүн
30	Эмийн хүйлс
31	Борноо
32	Будаа, дах

33	Эфирийн тос ба давирхай, үнэрт эссенци, үнэртэн, гоо сайхан, арвун цэврийн балдмал
34	Саван, угаалгын нунтаг, түрхлэг, тосолгооны материал
35	Энцэмүүд
36	Тэсрэх бодис
40	Каучук, каучукан эдлэл
41	Арьс ширэн түүхий эд, боловсруулсан арьс шир
42	Арьс ширэн эдлэл, хувиас
43	Үслэг арьс ба хиймэл үслэг арьс, тэдгээрээр хийсэн эдлэл
44	Мод, молон эдлэл
51	Ноос, ноолуур, үс хялгас
57	Хивс болон нэхмэл дэвсгэрийн зүйлс
61	Сүлжмэл дотуур хувиас
62	Оёмол дотуур хувиас
68	Цемент, барилгын болон замын зориулалттай хавтан, тоосго
69	Керамик эдлэл
73	Шахсан буюу шингэрүүлсэн хий хадгалах төмөр болон ган торх
84	Уурьт тогоо, дотоод шаталтын дөлт хөдөлгүүр, хөргөх, хөлдөх төхөөрөмжүүд, бүх зориулалтын жон, туухай
85	Ахуйн шалтгаан хэрэгсэл, төхөөрөмж, тэдгээрийн эд анги
87	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, трамвайнаас бусад авто тээврийн хэрэгсэл
90	Хий, шингэний болон шалтгааны гүйдлийн нарийн хэмжүүр, түгээмэл хэмжилтийн бусад хэмжих хэрэгсэл
93	Ангийн болон спортын буу
95	Хүүхдийн дугуй болон шалтгаан, автомат ажиглалтаар тоглоом, хялбар шатах резин ба пластмасс тоглоом

Тайлбар: Энэ жагсаалтад барааг бүтгээр нь нэрлэсэн болно. Тухайн бүтэцт хамарах тодорхой нэрийн бүтээгдэхүүнийг "Барааг тодорхойлох, хөдлөх уялдуулсан систем"-ийн кодын дагуу тодорсон хэрэглэнэ.

Засгийн газрын 1995 оны 100 дугаар
тогтоолны 3 дугаар хэвсрэлт

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААГ ХИЛЭЭР НЭВТ- РҮҮЛЭХ, ШАЛГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журам нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Стандартчилал чанарын баталгаажуулалтын болон эрүүд мөнд, хүнсний тухай хуулиудад нийцүүлэн харилцан нийлүүлж байгаа барааны чанарыг баталгаажуулах, сорилтын дүнг харилцан хүлээн зөвшөөрөх талаар гадаад орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээр, протоколыг хэрэгжүүлж экспорт, импортын барааны чанарыг шалгаж хэрэглээний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдэнэ.

2. Гадаад худалдаа эрхлэн явуулж байгаа өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, эргэд чанарын баталгаажуулалтад хамрагдах барааг экспортлох, импортлох үйл ажиллагааг явуулахад энэхүү журмыг мөрдөнө.

3. Экспорт, импортын бараанд чанарын баталгаажуулалт хийж чанарын гэрчилгээ болон дотоодын зах зээлд худалдах зөвшөөрөл олгохтой холбогдсон ажлыг зохицуулан зохион байгуулах, гүйцэтгэлд нь төрийн хяналт тавих үүргийг улсын хэмжээнд Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв, орон нутагт нийслэл, аймгийн стандартчилал, хэмжил зүйн төв гүйцэтгэнэ.

4. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв нь экспорт, импортын бараанд чанарын баталгаажуулалт хийхтэй холбогдсон дараахь үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

а) Засгийн газраас баталсан чанарын баталгаажуулалтад зөвөөр хамрагдах экспорт, импортын бүтээгдэхүүний жагсаалт (цаашид жагсаалт гэнэ)- диймэлт, өөрчлөлт оруулах саналыг "Барааг тодорхой нэр төрлөөр тодорхойлох, кодлох, уялдуулсан систем"-ийн дагуу холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж Засгийн азарт оруулж батлуулах;

б) чанар, стандарт, хэмжил зүй, эрүүдлахуй, халдвар, ний судлал, шал эмнэлэг, ариун цэвэр, ургамал хорго цээрийн зэрэг мэргэжлийн хяналтын албад болон их, дээд сургууль, эрдэм шинжилгээ-

ний байгууллагын сорилтын лабораториуд зохих түвшинд шинжилгээ хийж дүнг үнэн зөв гаргаж чадах чиглэлийг нь зохих журмын дагуу шалган тогтоож итгэмжлэл хүлээлгэн (тийнхүү итгэмжлэл хүлээлгэсэн лабораторийг цаашид итгэмжлэгдсэн лабораторигэнэ) чанарын баталгаажуулалтын сорилт хийх эрх олгож, тэдэнтэй гэрээ байгуулж ажиллуулах;

в/ тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн (эм, биобээлдмэл, малмы гаралтай түүхийэд, хүнсний бүтээгдэхүүн зэрэг)-д чанарын баталгаажуулалт хийх чадвар бүхий итгэмжлэгдсэн лабораторитай мэргэжлийн байгууллагуудад экспортын бүтээгдэхүүнд чанарын гэрчилгээ олгох болон импортын бүтээгдэхүүнийг худалдах зөвшөөрөл өгөх эрх олгож, гэрээ байгуулан гүйцэтгүүлж, үйлэжиллагаанд нь хяналт тавих;

г) чанарын гэрчилгээтэйгээр харилцан нийлүүлэхээр гадаад орнуудтай тохиролцсон барааны жагсаалт, чанарын гэрчилгээ олгох эрх бүхий байгууллага, итгэмжлэгдсэн лабораторийн жагсаалт, чанарын баталгаажуулалтын баримт бичгийн болон барааны тэмдгийн загвар, тэдгээрт гарсан өөрчлөлт, энэхүү журмын хэрэгжилтийн тухай тодорхой мэдээллийг Улсын гаалийн ерөнхий газар, Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төвд тухай бүр өгч байхавс гадна хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлж байх;

д) шаардлагатай гэж үзсэн хилийн боомт, гүний гаалийн газарт энэхүү журмыг хэрэгжүүлэх зорилгоор чанарын баталгаажуулалтын албыг байгуулан ажиллуулах.

5. Улсын гаалийн ерөнхий газар, хилийн боомтын болон гүний гаалийн хяналтын байгууллага (цаашид гаалийн байгууллага гэнэ) нь чанарын баталгаажуулалтад дараахь эрх, үүрэгтэйгээр оролцоно:

а) жагсаалтад орсон экспортын барааг стандартчилал, хэмжил зүйн төв болон эрх бүхий байгууллагаас олгосон чанарын гэрчилгээгүйгээр улсын хилээр гаргахгүй байх;

б) жагсаалтад орсон импортын барааг худалдан борлуулах зөвшөөрөлгүйгээр хүлээн авагчид нь олгохгүй байх;

в) Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвтэй хамтран гаргасан журмын дагуу чанарын баталгаажуулалтын үздэг шалгалт хийх;

г) чанарын баталгаажуулалтын ажил эрхэлсэн ажилтны тогтоосон экспорт, импортын барааны тоо, чанарын байдалыг үндэслэн

гаалийн татварыг зохих тарифын дагуу ногдуулах.

6. Хилийн боомт болон гүний гаалийн байгууллагад чанарын баталгаажуулалт хийж байгаа чанарын баталгаажуулалтыг гүйцэтгэх эрх бүхий байгууллагын ажилтан дараахь үүрэг хүлээнэ:

а) хил нэвтрэх бараа нь чанарын баталгаажуулалтад заавал хамрагдах импорт, экспортын бүтээгдэхүүний жагсаалтад орсон байвал түүний чанар, хэрэглээний аюулгүй байдал болон чанарын гэрчилгээнд үзлэг шалгалт хийх;

б) барааны тоо, чанар, хэрэглээний аюулгүй байдлын үзүүлэлтэд болон чанарын гэрчилгээнд ямар нэгэн зөрчил илрээгүй, чанарын баталгаажуулалтыг дахин явуулахад тэнцсэн экспортын барааг хилээр гаргаж, импортын барааг худалдах зөвшөөрөл олгох;

в) үзлэг шалгалтаар чанарын гэрчилгээг хуурамчаар үйлдсэн, засварласан зэрэг зөрчил илэрсэн болон энэхүү журмын шаардлага хангаагүй барааг гаалийн баталгаат агуулахад шилжүүлэх;

г) гаалийн баталгаат агуулахад байгаа бараанд эрх бүхий байгууллагаар чанарын баталгаажуулалт хийлгүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

д) үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил нь чанарын баталгаажуулалтыг дахин хийх үед нотлогдвол энэ талаар дүгнэлтийг албан ёсоор гарган холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад өгөхөөс гадна чанарын зөрчилтэй бүтээгдэхүүнийг хэрхэн ашиглах буюу устгах тухай асуудлыг мэргэжлийн хяналтын албадтай хамтран шийдвэрлэх.

7. Чанарын баталгаажуулалтын ажилтан дүгнэлт бичих хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэж болно.

8. Чанарын гэрчилгээ олгох, чанарын баталгаажуулалт хийхтэй холбогдон гарах зардлыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хариуцна.

9. Экспорт, импортын бараанд олгосон чанарын гэрчилгээний нэг хувийг уг барааг ачсан тээврийн хэрэгслийн ачаа тээвэрлэсэн тухай баримт бичигт хавсаргасан байна. Энэхүү гэрчилгээнд мал, амьтан, тэдгээрийн гэрэлтэй түүхий эд, бүтээгдэхүүнд эрх бүхий байгууллагаас хийсэн мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний бичгийг хавсаргасан байна.

10. Чанарын баталгаажуулалтын ажилтын албан ёсоор гаргасан дүгнэлт нь экспорт, импортын барааны тоо, чанарын талаар гарсан маргааныг шийдвэрлэх үндсэн баримт болно.

Хоёр. Экспортын барааны чанарын баталгаажуулалт

1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь жагсаалтад орсон барааг экспортлоходоо чанарын баталгаажуулалтад зайв ал хамруулсан байх үүрэгтэй.

2. Аж ахуйн нэгж, байгууллага жагсаалтад орсон бараанд чанарын гэрчилгээ авахын тулд хилээр гаргахаас 10-аас доошгүй хоногийн өмнө дараахь материалыг бүрдүүлэн Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв буюу түүнээс чанарын баталгаажуулалт хийх эрх авсан байгууллагад хүсэлт гаргана. Үүнд дараахь баримт бичгийг хавсаргана:

-байгуулсан гэрээ хэлэлцээрийн хуулбар;

-хилийн боомт, хилээр гарах хугацаа, тээврийн хэрэгслийн тухай мэдүүлэг;

-экспортын зориулалттай бараа үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж, байгууллага бүтээгдэхүүнийхээ чанарыг байнга дээшлүүлэх, тогтвортой байлгах талаар олон улсын хэмжээнд тогтсон нийтлэг арга зүй, зарчим, олон улсын стандарт (ИСО 9000 цуврал стандарт)-ыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар мэргэжлийн холбогдох байгууллагаас гаргасан үнэлэлт дүгнэлт;

-завчлал мөрдөх улсын стандарт хэрхэн хангаж байгаа (иллигуиа түүхий эдийг стандартад заасны дагуу ангилан илгаж зэрэглэж дугаарласан, савлаж боосон байдал гэх мэт) байдал.

3. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв буюу түүнээс чанарын баталгаажуулалт хийх эрх авсан байгууллага нь чанарын гэрчилгээ авах тухай аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, холбогдох материалыг хүлээн авч, шийдвэрлэхдээ дараахь журмыг баримтална:

а) түргэн гэмтэж муудах бараанд 3 хоногийн дотор, бусад бараанд 5 хоногт багтсан чанарын баталгаажуулалтын ажилтанг газар дээр нь очуулж шалгалт хийлгэх бөгөөд сорилт хийлгэх шаардлагатай гэж үзвэл хяналтын сорьцыг зохих журмын дагуу авч, шинжлэх шаардлагатай үзүүлэлтийн дагуу холбогдох итгэмжлэгдсэн лабораториудад протоколын хамт хүргүүлэх;

б) сорилт шинжилгээ шаардагдахгүй бараанд мэргэжлийн хүчээр газар дээр нь үзлэг шалгалт хийлгүүлж, чанарын гэрчилгээ олгох;

в) баталгаажуулалтад хамрагдсан барааг эцсийн шийдвэр гэрч ачуулч хүртэл битүүмжлэх.

4. Итгэмжлэгдсэн лаборатори нь хүлээн авсан сорьцод шинжилгээ хийх цаг хугацаанаас хамааруулан 3-10 хоногт багтаан сорилт, шинжилгээ хийж гарсан дүнг энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу бичиж албан ёсны харнуг дээж өгсөн байгууллагад хүргэнэ.

5. Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын болон чанарын баталгаажуулалтын дүн нь зохих стандарт, норматив-техникийн баримт бичиг, гэрээ, хэлэлцээрт, заасан чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангаж байвал Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв буюу түүнээс чанарын баталгаажуулалт хийх эрх авсан байгууллага энэхүү журмын 2 дугаар хавсралтад харуулсан загвар бүхий чанарын гэрчилгээг экспортлогчид өгнө.

6. Чанарын гэрчилгээ нь зөвхөн экспортлохоор бэдэн болсон, чанарын баталгаажуулалтад хамрагдсан тухайн нэр төрөл, тоо хэмжээ бүхий бараанд хамаарах бөгөөд чанарын гэрчилгээнд заасан хугацааны дотор хүчин төгөлдөр байна.

Гурав. Импортын барааны чанарын баталгаажуулалт

1. Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв нь гадаад орны холбогдох байгууллагатай импортын барааны чанарын баталгаажуулалтын талаар хамтран ажиллах хэлэлцээр байгуулахдаа чанарын баталгаажуулалтад хамрагдах барааны нэр төрөл, холбогдох стандарт, норматив техникийн баримт бичиг, Олон улсын хүнсний сууль зүйн комиссоос баталсан стандарт, чанарын гэрчилгээ, соёлтын дүнгийн маягт, тохирлын тэмдэг, загвар, итгэмжлэгдсэн лаборатори, чанарын баталгаажуулалт хийх эрх бүхий байгууллагын талаар харилцан тохиролцож тусгасан байвал зохино.

2. Аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн худалдааны гэрээний гэрээнд энэхүү журмын гурмын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэх талаар тодорхой тусгасан байна.

3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд явгсаалтад орсон импортын бараанд энэхүү журмын гурмын 2 дахь хэсэгт заасны дагуу олон тухайн экспортлогч орны чанарын баталгаажуулалтын эрх үхий байгууллагаас олгосон чанарын гэрчилгээ (тохирлын гэрчилгээ, хяналтын гэрчилгээ), итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнг заавал авсан байна.

4. Импортын барааг хил, гүний гаальд ирмэгц чанарын баталгаажуулалтын байгууллагын ажилтан энэхүү журмын нэгийг 6 дахь хэсэгт заасны дагуу чанарын баталгаажуулалтын шалгалт хийнэ. Чанарын баталгаажуулалтад тэнцсэн импортын барааны хувьд энэ

журмын 3 дугаар хавсралтад үзүүлсэн загвар бүхий "худалдах зөвшөөрөл"-ийн бичгийг импортлогчид олгоно.

5. Чанарын баталгаажуулалт хийх эрх бүхий байгууллага нь чанар, хэрэглээний аюулгүй байдлын шаардлага хангаагүй болон чанарын гэрчилгээ нь зөрчилтэй импортын барааг гаалийн баталгаат агуулахад буюу зохих шаардлага хангасан импортлогчийн өөрийнх нь агуулахад хадгалуулж чанарын баталгаажуулалт хийх бөгөөд түүний дүгнэлт гарах хүртэл хугацаанд бараа борлуулахыг түр зогсооно.

6. Чанарын баталгаажуулалт хийсэн байгууллага нь чанарын баталгаажуулалтад тэнцээгүй импортын барааг хэрхэн ашиглах буюу устгах талаар холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэр гаргаж цаг тухайд нь олон нийтэд дэлгэрэнгүй зарлан мэдээлж байна.

7. Олгосон худалдах зөвшөөрөл нь зөвхөн чанарын баталгаажуулалтад хамрагдсан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээнд хамаарах бөгөөд түүнд заасан хугацааны дотор хүчин төгөлдөр байна.

8. Чанарын баталгаажуулалтад хийх эрх бүхий байгууллагаас худалдах зөвшөөрөл аваагүй импортын барааг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд аливаа хэлбэрээр худалдан борлуулахыг хориглоно.

9. Хилийн боомтын болон гүний гаалийн газарт баталгаажуулалтын алба, албан тушаалтан байхгүй бол чанарын баталгаажуулалтын тухай шуурхай мэдээллийг нийслэл, аймгийн стандартчилал, хэмжил зүйн төвд хүргүүлнэ.

Дөрөв. Экспорт, импортын барааны чанарын төрийн хяналт

1. Экспорт, импортын барааны чанарын талаархи энэхүү журмын биелэлтэд стандарт, чанарын улсын байцаагчид төрийн хяналт тавина.

2. Экспорт, импортын барааны чанарт стандарт, чанарын улсын байцаагчдаас тавих төрийн хяналтад дараах зүйлийг хамруулна:

а) худалдааны цэгүүдэд борлуулж байгаа импортын бараа нь чанарын баталгаажуулалтад хамрагдсан эсэх, хүчин төгөлдөр худалдах зөвшөөрөлтэй эсэхийг магадлах;

б) жагсаалтад орсон боловч худалдах зөвшөөрөл аваагүй импортын бараанаас дээж авч, протокол үйлдэн итгэмжлэгдсэн лабораторид хүргүүлж түүний дүн гарч, худалдах зөвшөөрөл авах хүртэл уг барааг борлуулахыг хориглож битүүмжлэх;

в) шаардлагатай гэж үзсэн тохиолдолд худалдах зөвшөөрөл нь хүчин төгөлдөр барааны нэр төрөл, чанарын үзүүлэлтийг итгэмжлэгдсэн лабораторийн тусламжтайгаар дахин шалгуулах;

г) экспортын бараанд чанарын гэрчилгээ, импортын бараанд худалдах зөвшөөрлийг зохих журмын дагуу өгч байгаа байдлыг шалгаж, илэрсэн дутагдлыг арилгах талаар санал боловсруулж холбогдох удирдлага, байгууллагад танилцуулах;

д) стандартчилал чанарын баталгаажуулалтын тухай болон бусад хууль тогтоомжийн экспорт, импортын барааны чанартай холбогдсон заалтыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хэрхэн хэрэгжүүлж байгаа байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай арга хэмжээг авах.

3. Стандарт, чанарын улсын байцаагчид экспорт, импортын барааны чанарын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байх талаар холбогдох албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрхийн дагуу хариуцлага хүлээлгэж, зохих арга хэмжээ авна.

4. Импорт, экспортын барааны чанарын хяналтыг сонирхогч олон нийтийн байгууллага өөрийн зардлаар мэргэжлийн хяналтын албадтай хамтран шалгалт явуулж санал, дүгнэлтээ Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төв буюу орон нутгийн эрх бүхий стандартчилал, хэмжил зүйн төвд мэдэгдэж болно.

Чанарын баталгаажуулалтад хамрагдах
экспорт, импортын барааг хилээр
нэвтрүүлэх, шилгах журмын I дүгээр
хавсралт

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

19.... оны сарын
.... өдөр

N

Улаанбаатар
хот

1. Улсын экспертиз лабораторийн нэр
2. Дээжийг ирүүлсэн үйлдвэр, худалдаа, үйлчилгээний байгууллагын нэр ба протоколын дугаар
3. Магадлан шинжилгээнд хамрагдсан бүтээгдэхүүний нэр төрөл
4. Тоо хэмжээ
5. Шинжилгээ хийсэн хугацаа (он, сар, өдрөөр)
6. УСТ-ын дугаар
7. Стандарт техникийн нөхцөлд заасан шинжлэгдвэл зохих бүх үзүүлэлтийн тоо.....
8. Шинжилсэн үзүүлэлтийн тоо

ШИНЖИЛСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХҮСНЭГТЭЭР ХАРУУЛВАЛ

№	Үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Стандертэд зөвснөөр		
		Байвал зохиx	Байгаа нь	Зөрүү

Дүгнэлт

.....

.....

.....

.....

.....

Ахлах инженер

Сорилт инженер-химич

Лаборант

Чанарын баталгаажуулалтад хамрагдах
экспорт, импортин барааг хилээр
нэвтрүүлэх, шалгах журмын 2 дугаар
хэвсрэлт

ЧАНАРЫН ГЭРЧИЛГЭЭ/QUALITY CERTIFICATE

Худалдагч/Seller		Чанарын гэрчилгээ/Quality Certificate No.			
		Хүчинтэй хугацаа/Valid until			
		Гэрээний дугаар/Contract No			
Хүлээн авагч/Consignee		Худалдан авагч/Buyer			
Баталгаа гаргасан байгууллага/Issued by:		Гарал үүсэл, улсаар/Country of origin			
Тээвэрлэлтийн мэдээлэл/Transport details		Стандартын дугаар/Standart No			
Ачааны тэмдэглэгээ Чингэлэг Shipping marks; Container No.	Баглааны тоо, төрөл Number and kind of packing	Барааны нэр Denomination of goods	Барааны код Code	Бохир жин Gross weight	Эзэлхүүн Cubage (m ³)
				Цэвэр жин Net weight	
				Тоо хэмжээ, хэмжих нэгж Quality and unit	Үнийн дүн/ Value

Барааны чанарын тодорхойлолт
Quality description

Нийлүүлж буй барааны чанар нь стандарт болон гэрээний нөхцөлүүдтэй тохирч байна.
The quality of the delivered goods is in conformity with the State Standart of Mongolia and condition of the Contract

Он, сар, өдөр
Date

Гарын үсэг
Signature

Импортын баталгаажуулалтад хамрагдах экспорт, импортын барааг хилээр нэвтрүүлэх, шалгах журмын 3 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ СТАНДАРТЧЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ

БАРААГ ХУДАЛДАХ ЗӨВШӨӨРӨЛ

№ _____

/аж ахуйн нэгж, байгууллагын нэр/

-ийн _____ улсаас _____
/чанарын баталгаа, холбогдох стандарт,
баримт бичгийн нэр, дугаар/

-тайгаар 19 оны дугаар сарын -нд оруулж ирсэн _____

/барааны нэр, тоо хэмжээ, хэмжих нэгж/

нь холбогдох стандарт, баримт бичигт заагдсан чанарын шаардлагыг хангаж байгаа тул худалдахыг зөвшөөрөв.

Энэхүү зөвшөөрөл нь 19 оны дугаар сарын өдөр хүртэл гучинтэй.

/Чанарын баталгаажуулалтын байгууллага,
албан тушаалтны нэр/

Тэмдэг

/гарын үсэг/

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Бронхий эрхлэгч	Н. Ринчиндорж
Нарийн бичгийн дарга	Сав. Жаргалсайхан
Гшүүд	Т. Баасансүрэн
	Ч. Бавуу
	Б. Ганбат
	Б. Янжинлхам
Техник редактор	Т. Сарантуяа
Уншиж хявсан	Сав. Жаргалсайхан
	Б. Янжинлхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1995 оны 12-р сарын
25-нд. Өрөлтөд 1996 оны 1-р сарын 2-нд.
Хэвлэлтэд 1996 оны 1-р сарын 26-нд.
Хэвлэлийн хуудас 7,75. Хэвлэсэн тоо 4650.

Манай хаяг: Улаанбаатар-12,
Төрийн ордон. Утас: 322838

Засгийн газрын хэвлэх үйлдвэр